

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ГАЗАРЗҮЙ-ГЕОЛОГИЙН СУРГУУЛЬ**

**ЭДИЙН ЗАСГИЙН ТӨВ БҮСИЙН НЭН ТЭРГҮҮНД ЭРЧИМТЭЙ
ХӨГЖҮҮЛЭХ ДЭД БҮС БОЛОН ХОТ, СУУРИНЫ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ**

**УЛААНБААТАР ХОТ
2012 ОН**

Төслийн карт

- | | |
|--|---|
| 1. Төслийн нэр | Эдийн засгийн Төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги |
| 2. Төслийн хугацаа | Эхлэх - 2010 оны 01-р сар
Дуусах - 2010 оны 12-р сар |
| 3. Захиалагч | Барилга, хот байгуулалтын яам \ БХБЯ \ |
| 4. Гүйцэтгэгч | МУИС, Газарзүй-Геологийн Сургууль |
| 5. Санхүүжүүлэгч | Шинжлэх Ухаан Технологийн Сан \ШУТС \ |
| 6. Төслийн удирдагч | В.Батцэнгэл / МУИС-ын Газарзүй Геологийн сургуулийн захирал, нийгэм эдийн засгийн газарзүйч, др. проф / |
| 7. Төсөлд оролцогчдын овог нэр, мэргэжил, эрдмийн зэрэг цол, төсөлд оролцох хэлбэр | Хуудас №3-т үзүүлэв |

Төсөлд оролцогчдын тодорхойлолт

№	Овог, нэр	Мэргэжил	Эрдмийн зэрэг цол	Төсөлд оролцох хэлбэр
1	В.Батцэнгэл	Газарзүйч	Др. Проф	Төслийн удирдагч
2	М.Баянтөр	Газарзүйч	Др. Проф	Гүйцэтгэгч
3	Б.Чинбат	Газарзүйч	Др. Проф	Гүйцэтгэгч
4	С.Шийрэв-Адъяа	Газарзүйч	Доктор	Гүйцэтгэгч
5	Б.Даажав	Архитектор	Доктор	Гүйцэтгэгч
6	Г.Гантулга	Газрын менежер	Доктор	Гүйцэтгэгч
7	Н.Одхүү	Газарзүйч	Докторант	Гүйцэтгэгч
8	Б.Баасанхүү	Газрын менежер	Магистр	Гүйцэтгэгч
9	С.Намжилмаа	Хот төлөвлөгч	Магистр	Гүйцэтгэгч
10	Г.Бямбахүү	Газарзүйч	Магистрант	Туслан гүйцэтгэгч
11	О.Мэндбаяр	Газарзүйч	Магистрант	Туслан гүйцэтгэгч

Гарчиг

УДИРТГАЛ.....	5
I БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГАЗҮЙ.....	6
1.1 Судлагдсан байдал	6
1.2 Судалгааны арга, аргачлал	11
II БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН БҮС НУТАГ	22
2.1 Бүс нутгийн тухай.....	22
2.2 Монгол улсын бүсчилсэн хөгжил.....	22
2.3 Монгол улсын эдийн засгийн төв бүс	24
III БҮЛЭГ. ТӨВИЙН БҮСИЙН ХҮН АМЫН НУТАГШИЛТ, ХОТЖИЛТ	45
3.1 Төвийн бүсийн нутагшилтийн өнөөгийн байдал	45
3.2 Төвийн бүсийн хотжилт.....	50
3.3 Нутагшилтанд нөлөөлөх хүчин зүйл.....	54
3.3.1 Аж үйлдвэр.уул уурхай.....	54
3.3.2 Газар тариалан	57
3.3.3 Мал аж ахуй	59
3.3.4 Зам тээвэр.....	60
3.3.5 Боловсрол, эрүүд мэнд.....	62
3.4 Хүн амын нутагшилт суурьшлын өнөөгийн байдал, нөлөөлж буй хүчин зүйлсэд хийсэн SWOT дүн шинжилгээ	63
IV БҮЛЭГ. БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ.....	65
4.1 Бүс нутгийн хөгжлийн стратегид нөлөөлөх хүчин зүйлс.....	65
4.2 Бүс нутгийн чиг үүргийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд	93
4.3 Төвийн бүсийн үндсэн үүрэг	101
4.4 Төвийн бүсийн хот суурингийн ангилал.....	106
4.4.1 Дархан-сэлэнгийн бүсийн эдийн засгийн болон нийгмийн хөгжлийн түвшний харьцуулсан үнэлгээ.....	112
4.5 Хот суурингийн хөгжлийн төлөвлөлт ба бүсийн тулгуур төвүүдийг илрүүлэн тогтоох аргазүйн асуудал	121
ДҮГНЭЛТ	129
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	132
ХАВСРАЛТ 1.....	134
ХАВСРАЛТ 2.....	147

УДИРТГАЛ

Сүүлийн 20-иод жилд зах зээлийн эдийн засгийн харилцаанд зохицуулан боловсруулж, батлан гаргасан “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Үндэсний хөгжлийн стратеги”, “Эдийн засгийн ба Худалдааны Чөлөөт бүс” байгуулах хууль зэрэг хөгжлийн бодлогын шинжтэй боловсруулагдсан үзэл баримтлал, хууль эрхзүйг амьдрал практикт хэрэгжүүлэх дараачийн бодит алхамыг хийхийг Монгол улсын өнөөгийн байдал шаардаж байна. Иймд Монгол Улсад нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх эдийн засгийн дэд бүс болон хот сууринг тодорхойлж, түүнд тохирсон хөгжлийн стратеги боловсруулах шаардлага бий болж байна.

Үүнд:

- ✓ Монгол Улсын ойрын 15-25 жилийн хөгжлийн гол стратеги нь нийгмийн баримжаатай, байгаль орчиндоо зохицсон, оюуны болон технологийн шинэ суурьт тулгуурласан, экспортын чиглэл бүхий харьцангуй бие даасан эдийн засагтай, ардчилалд үндэслэсэн улс төрийн боловсронгуй тогтолцоотой, соёл, оюуны өндөр хөгжилтэй, үйлдвэржсэн орон болох явдал мөн.
- ✓ Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн Баруун, Хангайн, Төв, Зүүн, Улаанбаатарын 5 бүсээр хөгжүүлэх ерөнхий схемийн хүрээнд төлөвлөлт менежмент явуулахад нэгжийн хувьд хэт том учир хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сарниулах, менежментийн үйл ажиллагаа хэрэгжилтийг хянах зохицуулах боломжийг багасгаж байна. Түүнчлэн хөгжлийн нөөцүүдийн орон зайн харилцан хамаарал, орон зайн хуваарилалтыг иж бүрнээр нь тогтоон тодорхойлсон стратеги хөтөлбөргүй байна.
- ✓ Монгол Улсын нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах, тодорхой нутгийн түвшинд эдийн засгийг төрөөс зохицуулах нийтлэг болон ялгавартай бодлого явуулж бүс нутгийн хөгжлийг түргэтгэх шаардлагатай байна.
- ✓ Нутагшилт, суурьшил, хот байгуулалтын оновчтой бодлогоор, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, соёл, ахуйн үйлчилгээ хэт төвлөрч багтаамжаасаа томорсон нийслэл хот болон том хотуудын хүн амын бөөгнөрлийг багасгах шаардлагатай байна.
- ✓ Орон нутгийн хотуудын бие даан хөгжих чадавхийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- ✓ Эдийн засгийн бүс бүрд нэн түүрүүнд хөгжүүлэх шаардлагатай дэд бүсийг тогтоож, тэдгээр тохирох хөгжлийн стратегийн боловсруулах эрэлт үүсээд байна.
- ✓ Монголын одоогийн хотуудаас эдийн засгийн бүсийн хөгжилд түлхүү ач холбогдолтой нэн тэргүүнд хөгжүүлбэл зохих хот суурингуудыг тогтоох, тэдний хөгжлийн стратегийг тодорхойлох

I БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГАЗҮЙ

1.1 Судлагдсан байдал

1960-аад оны дунд үеэс Англи, Америкийн нийгэм эдийн засгийн газарзүйчид судалгааны объектын байршил, орон зайн зохион байгуулалт, орон зайн харилцан хамаарал болон орон зайн ялгаатай байдал гэсэн үндсэн 4 асуудлыг тодорхойлох, загварчлах, тайлбарлах асуудалд онцгой анхаарал хандуулж иржээ. Хүний үйл ажиллагааны орон зайн тархалтыг судлахдаа нийгэм эдийн засгийн олон онол аргазүйг ашиглаж ирсэн бөгөөд ялангуяа хөгжлийн онол концепцийг хэрэглэх зайлшгүй шаардлага гардаг. Хөгжил гэдэг нь цаг хугацаа болон тодорхой үйл явдлаар дамжин илэрдэг өөрчлөлтийн үйл явц юм. Улс орон бүс нутгийн хөгжил нь өсөлт, хүн амын амьдралын чанрыг дээшлүүлэх, өөрийн биеэ даасан байдлыг сайжруулах гэсэн үндсэн дөрвөн үйл явцаар тодорхойлогдоно.

Улс орны орон зайн зохион байгуулалтын судалгаа нь хүн амын тархалт, шилжих хөдөлгөөний урсал, эдийн засгийн үйл ажиллагааны хэлбэр, тээвэр харилцаа холбооны систем, татвар, хөрөнгө оруулалтын бодлого, үйлчилгээний байгууллагын байршил шинжилгээ хийж бусад орнуудтай харьцуулан тайлбарладаг. Үндэсний хөгжлийн бодлогын нутаг дэвсгэрийн хүчин зүйлийг хэрхэн яаж тодорхойлох вэ? төвлөрөл сарнилын хамгийн тохиромжтой түвшинг яаж тогтоох вэ? асуудлууд нь улс орны орон зайн зохион байгуулалтын чиглэлээр судалгаа явуулдаг судлаачид, шийдвэр гаргагчдын анхааралын төвд байдаг. Энэ асуудал нь үнэхээр хариулахад бэрхшээлтэй, шүүмжлэлтэй олон асуудлуудыг дагуулж түүнд тохирох онол, загварчлалыг сонгоход бэрхшээлтэй. (cf.Gore 1984)

1970-аад оноос орон зохион байгуулалтын судалгаа дахин сэргэж Preston(1980,1987), Gilbert(1981,1987), Morris(1987), Bromley(1989) зэрэг судлаачид энэ чиглэлээр судалгаа явуулж олон ном, өгүүлэл бичиж хэвлүүлжээ.

RichradWilkie Латин америкийн хүн амын тархалт, шилжих хөдөлгөөн, хотжилтын одоогийн болон түүхэн байдлыг харьцуулсан шинжилгээ хийж судалгаандаа зурагзүйн шинэ аргуудыг ашиглажээ.

Robert Gwynne улс орны үйлдвэржилт түүний хотжилт, эдийн засгийн хөгжилд нөлөөлөх нөлөөг судласан байна. Тэрээр судалгаагаа Чили, Бразили, Перу, Мехсик зэрэг улс орнуудад явуулсан бодит судалгаан дээрээ үндэслэн бүс нутаг улс орны хэмжээнд явуулжээ. Судлаач Peter Ward 1987, 1990 онуудад дэлхийн улс орнуудад томоохон хотууд үүсч бий болох нийслэл хотууд түүний үндэсний болон олон улсын ач холбогдол, улс орнуудын хотын хөгжлийн стратеги талаар судалгаа хийжээ.

Судлаачид сүүлийн жилүүдэд улсын орлого зарлагын газарзүйн тархалт, засаг захиргааны нэгжүүдийн хоорондох санхүү, мөнгөн гүйлгээ, шилжүүлгийн орон зайн ялгааны талаар шинжилгээ хийх асуудалд анхаарал хандуулах болжээ.

Дэлхий дахины даяаршлын эрин үед монгол улс зах зээлийн харилцаанд шилжсэнээр тус улсын эдийн засгийн харилцаа, хөгжлийн үзэл баримтлал шинэчлэгдэн өөрчлөгдөж гео эдийн засгийн цоо шинэ орчин бий болжээ. Манай орны газарзүйн байрлал, байгалийн нөхцөл нөөц, хүн амзүйн хүчин зүйлс нь нийт нутаг дэвсгэрийн эдийн засгийн хөгжлийн жигд бус байдлыг бий болгожээ. Дэлхийн улс орнууд нутаг дэвсгэрээ жигд хөгжүүлэх нийгэм, эдийн засаг, хүрээлэн орчны тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэхийн тулд орон зайн хөгжлийн бодлого боловсруулж эдийн засгийн бүсчлэлийн олон хэлбэрийг ашиглаж иржээ. Орчин үеийн газарзүйн шинжлэх ухааны ангилалд региональ эдийн засгийн газарзүй бие даан төдийлөн хөгжөөгүй ч эдийн засгийн газарзүйн иж бүрэн судалгаанд улс орон, бүс нутаг, районы хүрээнд судалгаа явуулах нь бий.¹

1961 онд Монгол – Зөвлөлтийн эрдэмтэд хамтран БНМАУ-ын эдийн засгийн мужлалтын анхны бүдүүвчийг боловсруулсан нь Монгол улсын бүс нутгийн судалгааны эхлэлийг тавьжээ. Энэ үеэс тухайн үеийн зөвлөлтийн эрдэмтэдтэй хамтран монгол улсын эдийн засгийн мужлалын багагүй судалгааг явуулсан. Тухайлбал, 1967 онд “БНМАУ-ын эдийн засгийн төв муж” гэсэн нэгэн сэдэвт бүтээл туурвиж, энэ мужийн байгалийн нөхцөл нөөц, хүн ам, аж ахуйн хөгжлийн өнөөгийн түвшин хэтийн төлөв, нутаг дэвсгэр үйлдвэрлэлийн таталцаа, эдийн засгийн газарзүйн байрлалд дүн шинжилгээ хийж зарим аймгийг эдийн засгийн нэг мужаас нөгөө мужид шилжүүлэн мужлалын системд зарим өөрлөлтүүдийг оруулжээ.

1976 онд БНМАУ-д үйлдвэрлэх хүчний хөгжил байршлын хүрээлэн байгуулснаар БНМАУ-ын улс ардын аж ахуй, түүний салбарын аж ахуйн нутаг дэвсгэрийн бүтэц, байгалийн нөхцөл нөөцийн нутаг дэвсгэрийн бүтэц, хүн ам болон хөдөлмөрийн нөөцийн нутаг дэвсгэрийн бүтцийг нарийвчлан тодорхойлж том, дунд, бага масштабын зураглал, атлас, ном зохиолуудыг хэвлүүлсэн нь нутаг дэвсгэрийн орон зайн зохион байгуулалтын судалгаанд зохих нөлөөг үзүүлсэн.


Монгол зөвлөлтийн эрдэмтэд эдийн засгийн дээд, дунд, доод гэсэн 3 гишүүнт мужлалтын сүлжээг үндэс болгон БНМАУ-ын эдийн засгийн мужлалын сүлжээг дараах байдалтай тогтоож байжээ.

1. Төв муж
 - a. Ерөө-Туулын дэд муж
 - b. Хангай Хөвсгөлийн дэд муж
 - c. Онги-Байдрагийн дэд муж
 - d. Говийн дэд муж
2. Дорнод муж

¹Д.Даш, Н.Мандах “Газарзүйн шинжлэх ухааны хөгжлийн түүх”, УБ 2011, хуудас №535

3. Өрнөд муж

- a. Ховд – Увсын дэд муж
- b. Завхан - Бэгэрийн дэд муж



Зураг 1. МУ-ын эдийн засгийн муж/Б.Гунгаадаш - 1962 он/

Эдгээр 3 шат бүхий эдийн засгийн мужлалын сүлжээг боловсруулахын зэрэгцээ аж ахуйн олон салбар тус бүрийн хөгжил байршлыг судалж мужлах чиглэлээр олон судалгааны ажлыг явуулж бүтээл ном олныг туурвижээ.

1990 –ээд он гарснаар Монгол улс нийгмийн шинэ харилцаанд шилжиж, хөгжлийн үзэл баримтлал шинэчлэгдсэнээр бүс нутгийн судалгааны цоо шинэ үе эхэлсэн.

Улс орныхоо эдийн засаг, нийгмийн хөгжлийн нутаг дэвсгэрийн тэнцвэргүй байдлыг бууруулж, тогтвортой хөгжлийн замд дэвшин орохын тулд бүсчилсэн хөгжлийн арга замыг боловсруулж, бүсчлэлээр дамжуулан нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах төрийн байгуулалт, эдийн засаг, нийгэм соёл, хүн амын нутагшилт, хот байгуулалт, гадаад хамтын ажиллагааны таатай орчныг бүрдүүлэх, эдийн засгийн бүсүүдийн хүрээнд бүс нутаг-хот байгуулалтын уялдааг хангах замаар аймаг, орон нутгийн хөгжлийг дэмжих төрийн бодлого, зохицуулалтын тогтолцоог бий болгох чиглэл, үйл ажиллагааны зарчмын үндсийг тодорхойлжээ. 2001 оны 6-р сарын 14-нд УИХ –ын 57-р тоот тушаалаар “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг батлан гаргаж, үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх зорилт тавьсан². Үүнд :

1. Төрийн байгууллага
2. Эдийн засаг

²Улсын Их Хурлын 2001 оны 6-р сарын 14-ны 57-р тогтоол

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

3. Нийгэм соёл
4. Байгаль орчин
5. Хүн амын нутагшилт, хот байгуулалт
6. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэхээр баталсан.

Монгол Улсын эдийн засгийн бүс бүрд хамаарах аймгуудын ерөнхий хуваарийг дараах байдлаар тогтоож, хөгжлийн тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан уг хуваарийг өөрчлөн гаргасан.

Хүснэгт 1. Монгол улсын эдийн засгийн бүсүүд

№	Эдийн засгийн бүс	Хамрагдах аймаг	Тулгуур төв, хот
1	Баруун бүс	Ховд, Увс, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан	Ховд, Улиастай
2	Хангайн бүс	Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Булган, Орхон, Хөвсгөл	Эрдэнэт, Хархорин
3	Төвийн бүс	Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр	Дархан, Зуунмод
4	Зүүн бүс	Дорнод, Хэнтий, Сүхбаатар	Чойбалсан, Өндөрхаан
5	Улаанбаатарын бүс	Улаанбаатар хот түүний дүүргүүдийн нутаг дэвсгэр, хот орчмын бүсийн дагуул хотууд	Улаанбаатар

Энэхүү үзэл баримтлалтай холбогдуулан бүс нутгийн судалгааны чиглэлээр судалгааны багагүй ажлууд хийгдэж өөрийн болон ОУ-ын байгууллагуудтай хамтран олон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүллээ. Тухайлбал:

- 2003 онд “Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги (2010 он хүртэл)” болон “Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай” хуулиудыг батлан гаргасан ба тус бүс нутгуудад бүсийн хөтөлбөрийг 2005 оны 9 сарын 28-ны өдрийн 202, 2006 оны 8-р сарын 16-ны өдрийн 197 –р тогтоолоор батлан амьдралд бодитойгоор хэрэгжүүлж байна³. Тус хөтөлбөр нь гурван үе шатыг дамжин хэрэгжинэ гэж тооцож байгаа:
 - ❖ I үе шат (2004-2010 он)
 - ❖ II үе шат (2011-2015 он)
 - ❖ III үе шат (2016-2021 он)
- Монгол улсын ерөнхийлөгч асан Н.Энхбаярын санаачилсан “Мянганы зорилтод суурилсан Монгол улсын үндэсний хөгжлийн цогц бодлого”⁴

³МУ-ын ерөнхийлөгчийн тамгын газар, ШУА-ын харъяа Үндэсний хөгжлийн хүрээлэн “Монгол улсын хөгжлийн судалгаа”, эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл 2007(2), УБ 2007

⁴МУ-ын ерөнхийлөгчийн тамгын газар, ШУА-ын харъяа Үндэсний хөгжлийн хүрээлэн “Монгол улсын хөгжлийн судалгаа”, эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл 2007(1), УБ 2007

- Австралийн ПДП компаний төслийн хүрээнд “Бүс нутгийн хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн чадавхийг бүрдүүлэх нь” сэдвийн дор бүс нутгийг хэв шинжийн давамгайлал буюу үйлдвэр аж ахуйн кластераар хөгжүүлэх судалгаа хийгдсэн байдаг⁵.
- Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газар, шинжлэх ухааны академийн харьяа Үндэсний хөгжлийн хүрээлэн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд гарч ирж буй болон тулгамдсан асуудлуудыг судлан хэлэлцэж “Монгол улсын хөгжлийн судалгаа” бүтээлийг жил бүр хэвлэн гаргадаг.

⁵Бодлогын зөвлөмжийн баримт бичиг №5, “Тулгуур төвүүд, үйлдвэр, аж ахуйн газрын кластер ба бүс нутгийн хөгжил”

1.2 Судалгааны арга, аргачлал

Сүүлийн жилүүдэд хүн төрөлхтний материаллаг хэрэглээ болон оюун санааны хүрээнд бодит өөрчлөлт бий болж иргэншлийн шинэ үе бий болсоноор дэлхий улс орон бүс нутгийн хүрээнд байгаль, нийгэм, эдийн засгийн бүтэц нэгэн зэрэг шинэ хэлбэрт шилжиж байна. Энэхүү орон зай цаг хугацааны хамаарал бүхий байгаль нийгэм эдийн засгийн шинэ бүтцийг судлах асуудал бүс нутгийн хөгжлийн судалгааны үндсэн асуудал болж байна.

Бүс нутгийн хөгжлийн судалгаа нь цогц байдал, орон зайн ялгаа, цаг хугацаанд хувьсах чанар гэсэн онцгой 3 шинж чанараар тодорхойлогддог газарзүй, нөөцийн болон хүрээлэн буй орчин, эдийн засаг менежментийн ухаануудын дундах салбар хоорондын судалгааны онцгой талбар юм.

Бүс нутгийн хөгжлийн асуудал нь байгаль нийгмийн үзэгдэл үйл явцыг хамтад нь авч үздэг цогц систем юм. Бүс нутгийн эдийн засгийн хөгжилд эдийн засаг нийгэм, байгалийн нөхцөл нөөц, хүрээлэн буй орчин зэрэг өргөн хүрээний цогц хүчин зүйлс нөлөөлдөг. Бүс нутгийн хөгжлийн механизмыг тодорхойлоход зөвхөн нийгэм эдийн засгийн судалгааны үндсэн онолоос гадна физик, хими, биологи зэрэг байгалийн шинжлэлийн онол, аргазүйг ашиглах шаардлагатай байдаг. Бүс нутаг бүрийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйлс нь харилцан адилгүй ялгаатай байхаас гадна түүнд нөлөөлөх, эрчим, хэмжээгээрээ ялгаатай мөн хөгжлийн ялгаатай үе шатанд байгаа бүс нутгуудын хөгжилд нөлөөлөх нөлөөлөл өөр өөр байдаг. Иймээс бүс нутгийн хөгжлийг шинжлэн судлах арга зүй нь системлэг нэгдмэл хандлагыг ашиглана. Тухайлбал физик газарзүйн голлох үйл явцыг жолоодох механизмыг судлахаас гадна дэлхийн глобаль өөрчлөлтөнд хүний үйл ажиллагааны нөлөөлөл, байгалийн нөөцийн ашиглалт зэрэг нийгэм эдийн засгийн газарзүйн судалгааны асуудлыг ч цогцод нь авч үздэг.

Бүс нутгийн судалгааны арга нь цогц нийлмэл асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай олон талын асуудлуудыг тэдгээрийн хоорондын уялдаа холбооныг нь үүднээс авч үздэг. Бүс нутгийн хөгжлийн судалгаа нь тухайн системийн дотоод бүтцийн хүрээнд дэх бүс нутгийн ялгарал, тэдгээрийн хоорондын харилцан хамаарал болон бүхий л системийн хүрээнд дэх бүс нутгийн үүргийг илрүүлэх ухаан юм. Бүс нутгийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэхийн тулд юуны өмнө бүс нутгийн ялгарал үүсэх, хувьсан өөрчлөгдөх механизмыг шинжлэн судлах шаардлагатай. Орон зайн ялгарал нь бүс нутгийн хөгжлийн үйл явцаас бий болж байдаг байнгын үйл явц юм. Аливаа системийн үйл явц түүний үүрэг бүтцэд нөлөөлөх байгаль, нийгмийн хүчин зүйлс нь орон зайд тэнцвэргүй байдалтайгаар тархсан байдаг. Иймээс энэхүү хүчин зүйлсийн тэнцвэргүй тархалт түүнийг жолоодох механизмын орон зайн ялгарал нь тухайн бүс нутгийн үндсэн ялгааны суурь асуудал болж байдаг. Бүс нутгийн судалгаанд хүчин зүйлийн болон бүс нутгийн шинжилгээний аргыг өргөн ашигладаг. Хүчин зүйлсийн шинжилгээний арга нь дэлхийн байгаль нийгмийн систем дэх үйл явцын орон зай цаг хугацааны хувьсал, үүрэг, бүтцийг нээн илрүүлэх, түүний дэд системүүдэд нөлөөлөх хүчин зүйлсийг судлах, тэдгээрийн хоорондын харилцан үйлчлэлийг нээн илрүүлэх зэрэг олон асуудлуудыг шийдвэрлэх зорилготой байдаг.

Бүс нутгийн судалгааны чиглэлээр онолын олон үзэл баримтлал байдаг. Сүүлийн жилүүдэд бүс нутгийн хөгжлийн судалгааг бүс нутгийн өрсөлдөх байдлын асуудалтай холбон тухайн бүс макро эдийн засгийн судалгааны онол аргазүйг өргөн ашиглах болжээ. Үүнд дараах эдийн засаг хөгжлийн онолууд багтана.

1. Эдийн засгийн сонгодог онол
2. Шинэ сонгодог эдийн засгийн онол
3. Кейнсийн эдийн засгийн онол
4. Хөгжлийн эдийн засгийн онол
5. Шинэ эдийн засаг хөгжлийн онол
6. Шинэ худалдааны онол

Сонгодог онол

Сонгодог эдийн засгийн онолын хувьд улс орон бүр ажиллах хүчний бүтээмжийн хувьд ялгаа бүхий эдийн засгийн хуваарийг хангадаг Адам Смитийн “ажиллах хүчний хуваарилалт” гэсэн загварыг ашигладаг. Капиталд хөрөнгө оруулалт хийх (сайжирсан багаж хэрэгсэл), худалдаа нь зах зээлийн хувьд өсөн нэмэгдэх, бүтээгдэхүүний гарцын өсөлт, бүтээмжийг нэмэгдүүлнэ гэж Смит үзсэн. Түүнчлэн тухайн улс орон бүтээгдэхүүнийг хамгийн боломжит бага зардлаар (цөөн ажиллах хүч) үйлдвэрлэсэн тохиолдолд үнэмлэхүй давуу талтай болно, энэ бүтээгдэхүүнээ экспортлох эсвэл хямд өртгөөр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг импортлох гэсэн хувилбар байж болно.

Харин Дэвид Рикардогийн онолоор улс орнууд үйлдвэржилтийн хувьд янз бүрийн технологи ашигладаг ч ажиллах хүчний бүтээмжийн хувьд ялгаатай. Улс үндэстнүүд технологийн хувьд ялгаатай ч үйлдвэржилт нь олон улсын худалдаанд сэдэл болж өгдөг. Технологийн хувьд давуу байна гэдэг нь тухайн үйлдвэрлэл амжилттай өрсөлдөхүйц байна гэсэн баталгаа биш. Гэсэн хэдий ч дотоодын үйлдвэрлэгчид гадаадын үйлдвэрлэгчдээс технологийн хувьд давуу байсан ч харьцангуй давуу тал байхгүй тохиолдолд үйлдвэрлэл үгүй болох талтай.

Түлхүүр ойлголтууд:

- Ажиллах хүчний хуваарилалт нь улс орнуудын дунд технологийн ялгааг бий болгодог (ажиллах хүчний бүтээмжийн хувьд улс орнууд ялгаатай байна)
- Үнэмлэхүй давуу тал бүхий худалдаа арилжаа (Smith), харьцангуй давуу тал бүхий худалдаа (Ricardo)
- Улс орнуудын хувьд үйлдвэрлэх хүчин зүйл (ажиллах хүчин) үйлдвэрлэлүүдийн хувьд төгс нүүдлийн шинжтэй байдаг

Түлхүүр хүчин зүйлс:

- Капиталд хөрөнгө оруулалт хийх (сайжруулсан технологи) нь ажиллах хүчний хуваарилалтыг нэмэгдүүлдэг. Ингэснээр ажлын бүтээмж нэмэгдэнэ.
- Худалдаа арилжаа нь өсөлт хөгжилтийг түлхэгч гол хүч нь болдог.

Бүсийн өрсөлдөх чадварын талаар

- Бүх улс орнууд өөрсдийн харьцангуй давуу тал дээрээ үндэслэн ажиллах хүчний хуваарьт гол үүрэг хүлээдэг. Гэхдээ улс орон бүр технологи ажлын бүтээмж нь ижил бол худалдааны хувьд ямар ч суурь байхгүй гэж ойлгож болно
- Тухайн улс бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хувьд илүү бүтээмж үр ашигтай байсан ч чөлөөт зах зээлд үйлдвэрлэл буурна.

Неоклассик онол

Неоклассик онолын гол үзэл нь дэлхийн хэмжээнд төгс өрсөлдөхийн тулд төгс мэдээлэлтэй байна.

Түлхүүр ойлголтууд:

- Төгс мэдээлэл (улс орнууд технологийн хувьд адилхан) -тэй байх
- Санхүүгийн хүчин зүйлс дээр тулгуурласан худалдаа (ажиллах хүч ба капитал)
- Тухайн улс орон дотор бүтээгдэхүүний хүчин зүйлс үйлдвэрлэлийн хувьд төгс нүүдлийн шинжтэй байна.

Түлхүүр хүчин зүйлс:

- Худалдаа нь өсөлтийг дэмждэг гол хүчин зүйл нь болдог

Бүс нутгийн өрсөлдөх чадварын тухайд:

- Бүх улс орнууд хуваарилалтын хүчин зүйл дээрээ суурилсан ажиллах хүчний хуваарилалтандаа гол анхаарлаа хандуулдаг. Хэрэв хуваарилалтын хүчин зүйлс бүх улс орны хэмжээнд адилхан бол худалдаа хийх үндэслэл байхгүй. Энэ онол нь Хойд болон Өмнөд эсвэл хөгжингүй болон хөгжиж буй орнуудын худалдаанд хамгийн их ач холбогдолтой.
- Үнийг тогтворжуулах хүчин зүйлс нь капитал болон ажиллах хүчинд нөлөөлнө
- Төгс өрсөлдөөнийг бий болгосноор “өрсөлдөх чадвар” гэсэн ухагдахуун нь урт хугацааны туршид зохимжгүй.

Кейнсийн эдийн засгийн онол

Кейнсийн онол нь сонгодог эдийн засгийн онолуудаас маш чухал шинж чанараараа ялгаатай бөгөөд хамгийн чухал нь зах зээлийн үйл ажиллагаа юм. Кейнсийн үзлээр бол үнэ зах зээлийг үгүй болгодог гэдэгт итгэдэггүй. Харин үнийн хөдөлгөөнгүй байдал нь бүтээгдэхүүний хэмжээнд нөлөөлнө. Өөр нэг ялгаа нь капитал болон ажиллах хүчийг өөрөөр өнцгөөс хардаг. Сонгодог эдийн засагчид капитал болон ажиллах хүч нь үйлдвэрлэлийн ба даасан хоёр хүчин зүйл гэж авч үздэг. Харин Кейнс бол капитал болон ажиллах хүч нь харилцан бие биенээ нөхсөн хүчин зүйл гэж авч үздэг. Кейнсийн онол, баримталдаг бодлого нь макро эдийн засгийн түвшинд бүс нутгийн анализид тусгалаа олсон байдаг бөгөөд 1950-1960-аад онд оролцооны бодлого нь уламжлалт бүс нутгийн

бодлогын үндэс болсон. Энэ нь бүс нутгийн хооронд тэгш байдлыг хангах, олон нийтийн хөрөнгө оруулалтыг дэмжих, хөгжил буурай ядуу бүс нутгууд руу фирмүүдийг нүүлгэн шилжүүлэхийг дэмжих мөн нөхөн төлбөр олгох.

Кейнсийн онолын түлхүүр ойлголтууд:

Түлхүүр ойлголт:

- Үнэ зохицуулалт удаашрах, бүтээгдэхүүний хэмжээнд нөлөөлөх
- Зах зээл тогтвортой байх шаардлагагүй (эрэлт нийлүүлэлт багасах)
- Шударга худалдааны боломж (тогтвортой буй үнийн эсрэг)
- Капитал, ажиллах хүч хоёр бие биенээ нөхсөн хүчин зүйлс

Түлхүүр хүчин зүйлс:

- Капиталын эрчим
- Хөрөнгө оруулалт
- Засгийн газрын зарцуулалт тухайлбал олон нийтийн хөрөнгө оруулалт, нөхөн төлбөр, байгууллагуудын татварыг багасгах

Бүс нутгийн өрсөлдөх чадварын талаар:

- Засгийн газрууд эдийн засгийн эргэлтэнд амжилттай оролцож болно, харин цаг хугацаа чухал.
- Зах зээл доголдолтой байх нь бүс нутгийн ялгааг үүсгэнэ
- Эдийн засгийн бодлогоор бүс нутгуудыг хөгжлөөр нь ойртуулах
- Капиталын эрчим бүтээмж болон өсөлтийг нэмэгдүүлдэг.

Хөгжлийн эдийн засаг

Хөгжлийн эдийн засгийн хамгийн чухал ойлголтууд бол зээл тусламжийн үр нөлөө, чөлөөт худалдаа, гадны шууд хөрөнгө оруулалт. Гэсэн ч зарим нэг чухал үзэл баримтлалуудын үндэс нь хөгжлийн эдийн засагт байдаг. Ялангуяа бүс нутгийн өрсөлдөх чадвар гэсэн ойлголт.

Ростовын хөгжлийн онол нь нийгмийг 5 өөр үе шатанд ангилж авч үздэг (1960). Уламжлалт, шилжилтийн үеийн, өсөлтийн, боловсорсон, их хэмжээний хэрэглээ шаардсан гэж байна. Эдгээр хөгжлийн үе шатууд эдийн засгийн өндөр түвшинд хүрэхээсээ өмнө өөрийн онцлог шинж чанар, тодорхой нөхцлүүдтэй таарч байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл зах зээл ажил хийхийг шахах харин ажил хийгдсэн байх биш юм. Мөн энэ онол нь хөдөө аж ахуйд маш чухал хувь нэмрээ оруулсан тухайлбал өсөлтийн түвшинг нэмэгдүүлэх үүднээс хөрөнгө оруулалт хийх, хөгжилд тохирсон улс төр болон социологийн тодорхой урьдчилсан нөхцлийг бий болгосон.

Хөгжлийн эдийн засгийн түлхүүр ойлголтууд:

- Орлого байнга нэг чиглэлтэй байх албагүй

- Зарим улс орнууд илүү бусдаасаа илүү хөгжиж байна
- Эдийн засгийн бодлого нь амжилтыг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг.

Түлхүүр хүчин зүйлс:

- Хөдөө аж ахуйгаас илүү өндөр нэмүү өртөгтэй салбар луу шилжих
- Худалдааг дэмжих, нээлттэй болгох
- Гадаадын шууд хөрөнгө оруулалт
- (Гадаадын) хөгжлийн сан

Өрсөлдөх чадварын хүрээнд:

- Бүсүүдийн бүтээмжийг нэмэгдүүлэх нь удаашрах шинжтэй
- Бодлогууд нь бүсийн хөгжлийн үе шатуудыг анхаарч авч үзэх
- Бодлогууд нь “тархах үр нөлөө”-г сурталчлах хэрэгтэй тухайлбал гадаадын шууд хөрөнгө оруулалт болон хөгжлийн сангаар дамжуулан

Шинэ эдийн засгийн өсөлтийн онол-эндогенийн өсөлтийн онол

Эндогенийн өсөлтийн онол нь эдийн засгийн түүхийн онол бөгөөд энэ утгаараа яагаад зарим эдийн засагчид амжилттай байхад яагаад зарим нь унаж байгааг тайлбарлахыг оролддог. Эндогенийн онолын түлхүүр ухагдахуун нь хуримтлуулсан мэдлэг нь эргээд өсөн нэмэгдэж буй ашиг тусыг бий болгодог гэж үздэг. Мэдлэг, шинэ технологи туршлага нь улс үндэстэн, бүс нутаг, салбар компаниудын дунд хурдацтай дэлгэрдэггүй ч үүнийг өөрийн болгох хэрэгтэй. Нэг талаас засгийн газар нь мэдлэгийг түгээх тал дээр тэнцвэртэй бодлого баримтлах нөгөө талаар оюуны эрхийг хамгаалах тал дээр анхаарах нь зүйтэй. Ур чадвар сайтай ажилчид тухайн компанид төдийгүй эдийн засагт эерэг нөлөө үзүүлдэг.

Эдийн засгийн өсөлтийн онолын түлхүүр ойлголтууд

- Хуримтлуулсан мэдлэг нь эргээд өсөн нэмэгдэж буй ашиг тусыг авчирна
- Хүмүн капиталыг танилцуулснаар үйлдвэрлэлийн хүчин зүйл болно
- Зах зээл нь автоматаар таатай нөхцлийг үүсгэдэггүй

Түлхүүр хүчин зүйлс:

- Шинэ санаачлага патент
- Боловсролын түвшин
- Хүмүн капиталд хөрөнгө оруулалт хийх (сургууль, сургалт)
- Мэдлэгийг үр ашигтайгаар түгээн дэлгэрүүлэх

Өрсөлдөх чадварын хүрээнд:

- Бүтээмж, өсөлтөн дэх бүс нутгийн ялгаа нь технологи болон хүмүн капиталын ялгаагаар тооцогдоно
- Технологи болон хүмүн капиталыг сайжруулах нь өсөлтийн гол хөдөлгүүр нь болно
- Нээлттэй худалдаа нь өсөлт болон технологийн хөгжлийг дэмжинэ

- Судалгаа болон хөгжилд хөрөнгө оруулах нь маш чухал хүчин зүйл
- Хүмүн капиталыг сайжруулах нь түлхүүр ач холбогдолтой.

Шинэ худалдааны онол

Уламжлалт худалдааны онол нь (сонгодог болон неоклассик) янз бүрийн технологи, санхүүгийн хүчин зүйл бүхий улс орнуудын дунд хийгдэж буй худалдааг ойлгоно. Ер нь ижил улс орнууд, бүс нутгуудын хувьд яагаад худалдаа явагддагийг тайлбарлах боломжгүй. Үйлдвэржсэн орнуудын дунд шинэ худалдааны онол нь эдийн засгийн хэр хэмжээ, бүтээгдэхүүний ялгаатай байдал, шударга бус өрсөлдөөн, худалдааны хэв маягийг тайлбарлахад чиглэсэн.

Шинэ худалдааны онолын түлхүүр ухагдахуун

- Технологи нь бүтээгдэхүүний тодорхой ба эндоген хүчин зүйл болно
- Шинэ технологийн бүтээгдэхүүн нь капитал болон ажиллах хүчний хэрэглээг багасгахад хүргэдэг
- Шударга бус өрсөлдөөн
- Технологи бол нүүдлийн шинжтэй харин тухайн технологийг ашиглах байдал нь эзэмших чадварын хувьд харилцан адилгүй
- Шинэ технологийг маш ихээр ашиглаж байна

Түлхүүр хүчин зүйлс:

- Ур чадвартай ажиллах хүч
- Тусгай дэд бүтэц
- Ханган нийлүүлэгчдийн сүлжээ
- Дотоод технологи

Өрсөлдөх чадварын хүрээнд:

- Тухайн үйлдвэрлэл, салбарын түвшинд мэргэшсэн байдал шаардлагатай
- Дотоодын эдийн засгийн хэмжээг барихын тулд дотоодын зах зээлийн хэмжээ маш чухал
- Ур чадвартай ажиллах хүч, тусгай дэд бүтэц, ханган нийлүүлэгчдийн сүлжээ, дотоодын технологи зэрэгт хөрөнгө оруулалт хийх

Бүс нутгийн өрсөлдөх чадварын талаар ярихдаа бүс нутгийн өрсөлдөх чадварын тухай дараах үндсэн гурван ойлголтыг танилцуулах хэрэгтэй:

1. *Бүс нутаг нь экспортын түшиц газар болох нь.* Энэ ойлголт нь санхүүгийн дэмжлэгийн хүчин зүйл болон экспортод суурилсан эдийн засагтай нягт холбоотой.
2. *Бүс нутаг нь ашиг орлогыг нэмэгдүүлэх эх сурвалж болох нь.* Энэ нь эдийн засгийн газарзүйн амин чухал ойлголт юм.
3. *Бүс нутаг нь мэдлэгийн гол төв болох нь.* Энэ ойлголт нь “илүү зөөлөн” хүчин зүйлтэй холбоотой бөгөөд үүнд социологийн болон институцын элементүүд багтана.

Бүх нутаг нь экспортын түшиц газар болох нь.


1970-аад оны үед эдийн засгийн газарзүй нь аж үйлдвэрийн газруудын байршлын динамикт голлон анхаардаг байсан. Энэ ажлын ихэнхийг неоклассик эдийн засагчид эхлүүлсэн байдаг. Неоклассик эдийн засагчдын судалгааны гол ухагдахуун нь “үйлдвэрлэлийн функц” байдаг учраас эдийн засгийн газарзүйчид үйлдвэрлэлийн газарзүйг “орон нутгийн функц” гэсэн нэр томъёогоор авч үздэг ба эдийн засгийн үйл ажиллагааны /ажил хэрэгч идэвх/ байршлыг “орон нутгийн санхүүгийн гол тусламж дэмжлэг”-ийн хуваарилалтаар тайлбарладаг. Чухамдаа, бүс нутгууд нь эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил хэрэгч идэвхийг өөртөө татахын тулд өөр хоорондоо “өрсөлддөг”. Эдийн засгийн байдлыг ийнхүү байршлын хувьд судлах онол нь бүс нутаг бүр өөрийнхөө хувьд харьцангуй боломжтой, ашигтай гэж үзсэн үйл ажиллагаа, үйлдвэрээр дагнах хандлагатай байдаг гэсэн санааг агуулдаг.

Харамсалтай нь, энэ үзэл хандлага нь эдийн засгийн үйл ажиллагааны байршлын талаар зарим нэг ойлголт өгөх авч худалдаа арилжаа болон бүс нутгийн хөгжилд гүйцэтгэх үүрэг тун бага юм. Энэ хандлагаар бол бүс нутгийн эдийн засгийн гүйцэтгэл ба хөгжил нь үндсэндээ тухайн бүс нутагт буй экспортын чиг хандлагатай үйлдвэрүүдийн хэмжээ ба амжилтаас шалтгаалдаг аж. Хамгийн хялбар загвар бол эдийн засгийн үндэс суурийн загвар юм. Уг загвараар, бүс нутгийн харьцангуй өсөлт нь түүний эдийн засгийн үндэс суурийн (орон нутгийн эдийн засгийн экспортын салбар) өсөлтөөс шууд шалтгаалдаг. Илүү нарийвчилсан хувилбар нь экспортын эрэлт хэрэгцээ болон нийлүүлэлтийн функцийг томъёолох арга замыг эрэлхийлдэг. Дэлхийн зах зээл дээрх бүс нутгийн экспортын салбарын өрсөлдөх чадвар нь тухайн салбарын өсөлтөд нөлөөлдөг.

Бүс нутгийн экспорт өргөжсөнөөр үйлдвэрийн газруудын түүхий эдийн эрэлт хэрэгцээ нэмэгдэж, үнэ өсдөг. Ингэснээр тухайн бүс нутгийн үйлдвэрлэлийн өсөлт буурч, бүс нутгийн экспортын өрсөлдөх чадвар буурахын сацуу үнэ харьцангуй доогуур байгаа бүс нутаг руу капиталын шилжилт явагддаг.

Бүс нутаг нь ашиг орлогыг нэмэгдүүлэх эх сурвалж болох нь.

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн салбарт ашиг орлогыг нэмэгдүүлэх загваруудыг дахин шинэчилж, улмаар эдгээр загварыг эдийн засгийн газарзүйд хэрэглэх явдлыг чухалчлах боллоо. Үүний нэг жишээ бол бүс нутгийн *цогц өрсөлдөх чадварыг* илтгэсэн Калдорианы загварыг шинэчилсэн явдал юм. Энэ загвар нь бүс нутгийн цогц өрсөлдөх чадварын боломжийг дараах байдлаар харуулдаг.



Схем 1. Цогц байдлыг нөхцөлдүүлэгч ба бүс нутгийн өрсөлдөх чадвар

Бүс нутгийн бүтээгдэхүүний өсөлт нь түүний экспортын эрэлт хэрэгцээнээс шууд хамараалтай гэж үздэг. Бүс нутгийн экспортын хэрэгцээ буюу өрсөлдөх чадвар нь тухайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх хэрэглээний өсөлт ба бүс нутгийн бүтээгдэхүүний дэлхийтэй харьцуулсан үнийн өсөлтийн хэмжээнээс хамаардаг.

Бүтээгдэхүүний өсөлт нь бүтээмж өсөхөд хүргэдэг. Ашиг орлогын динамик өсөлтийн гол утга учир нь үүнд орших агаад энэ нь уг загварын үндэс суурь юм.

Дээрх загварууд нь бүс нутгийг ашиг орлогыг нэмэгдүүлэх эх үүсвэр мөн гэдгийг хүлээн зөвшөөрсөн хэд хэдэн нэмэлт загварыг гаргаж тавьдаг. *Бүс нутгийн эндогенийн өсөлтийн загварууд* нь неоклассик өсөлтийн загварын стандарт үндэслэгдсэн байдаг. Бүс нутгийн хувьд аваад үзвэл өсөн дэвжиж буй бүс нутаг уруу чиглэсэн ажиллах хүчний урсгал явагддаг бөгөөд тэдний ихэнх нь чадварлаг, идэвх санаачлагатай ажилчид байдаг аж.

Эдгээр янз бүрийн загваруудыг харвал бүс нутгийн өрсөлдөх чадварын үндэс суурьтай холбоотой хоёр сэдэв байнга давтагдаж байна. Тэдгээр нь: орон нутгийн үйлдвэржилтийн чиглэл ба бүс нутаг ба орон нутгийг гадаад ашиг орлогыг нэмэгдүүлэх эх сурвалж хэмээн үзэх үзэл санаа юм. Өнгөрсөн 10-20 жилийн хугацаанд бичигдсэн онол, практикийн бүтээлүүдэд энэ хоёр сэдвийн талаар нэлээд түлхүү өгүүлсэн байдаг. Тэдгээр нь аж үйлдвэрийн дүүргүүд болон бүсчлэлийн эдийн засгийн талаарх Маршаллын (1890 он) санаан дээр үндэслэгдсэн байдаг. Аж үйлдвэрийн газрууд тодорхой чиглэлээр дагнан, нэг газар төвлөрөх нь аж үйлдвэрийн эдийн засгийн хөгжлийн нэг хэсэг мөн гэж Маршалл үздэг байжээ.

Бүс нутаг нь мэдлэгийн гол төв болох нь.

Маршалл дотоодын эдийн засгийн гурван гол зүйлийг (мэргэшсэн ажилчид, мэргэшсэн пүүс, ажиллах хүчнийг пүүсийн дотор бүлэглэн хуваарилах боломж) онцлоод зогсохгүй энэ гурвын хоорондох уялдаа холбоог мөн онцолсон. Тэрээр мэдлэг ба дадлага туршлага хуримтлагдсаар тухайн “орон нутгийн аж үйлдвэржилтийн ерөнхий дүр төрхийг” бүрдүүлдэг ба улмаар шинэ санаа, бизнесийн арга барилыг бий болгоход сайн нөлөө


үзүүдэг гэж үзсэн байдаг. Тиймээс Маршаллын бүтээл нь “орон нутгийн шинэ санаачлагын цар хүрээ” хэмээх газарзүйн шинэ уламжлалыг гаргаж ирсэн юм.

Ийм мэдлэг бүхий байгууллага ба сүлжээг хөгжүүлэх нь дотоодын эдийн засагт, тухайлбал, пүүс компаниуд, ажилчин албан хаагчид болон байгууллагуудад нэн чухал бөгөөд үүнийг “хамт олноороо суралцах үйл явц”-аар хэрэгжүүлдэг. “Мэдлэгээр удирдуулсан, мэдээллээр баялаг” өнөөгийн эдийн засагт шинийг санаачлах болон бизнесийн мэдлэгийг бий болгож, түүнийгээ амьдралд хэрэгжүүлэх нь бүс нутгийн эдийн засгийн давуу байдлыг хамгаалахад туйлын чухал юм.

Бүс нутгийг мэдлэгийн төв хэмээн үзэх онол нь шинийг санаачлах үйл явцтай холбоотой бөгөөд Шумпетрийн болон эволюцийн эдийн засгийн ойлголт дээр үндэслэгддэг. Шинэ санаачлага гэдгийг харилцан бие биенээсээ суралцах үйл явц гэж ойлгож болно. Энэ үйл явц нь тухайлбал, гэрээгээр болон давхар гэрээгээр ажил гүйцэтгэгчийн хооронд, хэрэглэгч болон нийлүүлэгчийн хооронд, өрсөлдөгчдийн хооронд эсвэл хувийн болон улсын судалгааны лабораторуудын хооронд явагдаж болох юм.

Институцын буюу хамт олны хүчин зүйлийг хүчтэй онцолсон нь хэд хэдэн “зөөлөн” хүчин зүйлийг онцгойлон анхаарсан явдал байлаа. Зөөлөн хүчин зүйл гэдэгт бизнесийн эрч хүч, найдвартай байдал, харилцан хамааралтай байдал, удирдлагын талаарх нэгдсэн хараа гэх мэт зүйл багтдаг.

Майкл Портерын *газарзүйн бөөгнөрлийн* тухай ойлголт нь АНУ-ын болон Европын орнуудын бодлого боловсруулагчдын дунд нэлээд нөлөөтэй бөгөөд энэ нь нэлээд хувьсамтгай чанартай учраас онолын аль хэсэгт хамруулах нь бидний хувьд хүндрэлтэй байдаг. Портер нь Маршаллын загварын үндэс суурийг пүүсүүдийн өрсөлдөх чадварын бодлогын талаарх өөрийн бүтээлд дурьдсан зүйлстэй хослуулан авч үздэг. Мөн санхүүгийн хандив тусламжийн хүчин зүйлийг тооцсон байдаг. Тэрээр дэлхийд өрсөлдөх чадвартай аж үйлдвэр бүхий улс орнуудын хувьд тодорхой бүс нутгуудад газарзүйн бөөгнөрөл байнга ажиглагддаг гэдгийг маш олон орны жишээн дээр тайлбарлан өгүүлсэн байдаг. Энэхүү бөөгнөрөл нь “өрсөлдөгч ромб”-ын харилцан үйлчлэлийн үр дүн бөгөөд энэ харилцааг бататгаж байдаг аж. Бүс нутгийн өрсөлдөх чадвар нь энэхүү ромбын үндсэн дөрвөн дэд системийн хөгжлийн төвшин ба харилцан үйлчлэлээс шалтгаалдаг.



Схем 2. Бүс нутгийн өрсөлдөх чадварын талаарх Портерийн бөөгнөрлийн онол


Практик бүтээл туурвил

Эдийн засгийн салбарт ерөнхий болон өрсөлдөх чадварын практик судалгаа хийхэд багагүй олон саад бэрхшээл тулгардаг. Тухайлбал:

1. Шугаман харилцааг тусгаарлахад тулгардаг бэрхшээл
2. Нэгэн зэрэг явагдах шинж чанар
3. Өгөгдлийн тоо хэмжээ ба чанар гэсэн шийдвэрлэвэл зохих асуудлууд байдаг.

Нутаг дэвсгэрийн эдийн засгийн өрсөлдөх чадварыг үндэсний, бүс нутгийн болон микро гэсэн 3-н үндсэн түвшинд ялган авч үздэг.

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**



Схем 3. Бүс нутгийн хөгжлийн стратеги дах төрийн бодлогын нөлөөлөл

II БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН БҮС НУТАГ

2.1 Бүс нутгийн тухай

Аливаа улс орон өөрийн нутаг дэвсгэрээ эдийн засгийн хувьд жигд хөгжүүлэхийг эрмэлздэг. Гэвч тухайн улсын байгалийн нөхцөл нөөц, нийгэм эдийн засгийн чадавхи орон зайд жигд бус хуваарилагдсан байдаг. Иймд тэрхүү нөөцийг орон зайн хүрээнд зөв зохион байгуулах зорилгоор эдийн засгийн бүсчлэлийг хий шаардлагатай болдог.

Газарзүйн шинжлэх ухаанд тодорхой шинж чанар эсвэл тодорхой шалгуур үзүүлэлтээр өгөгдсөн орон зай, нутаг дэвсгэрийн ялгаатай хэсгүүд буюу нэгжүүдийг **бүс** гэж ерөнхийд нь тодорхойлдог бөгөөд хүн ам, аж ахуйн олон салбаруудын өөр хоорондоо нийгэм эдийн засгийн талаар харилцаа холбоо бүхий засаг захиргааны нэгжийг хамарсан нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг **бүс нутаг** гэнэ.

Нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах зорилгоор үндэсний хэмжээнд, бүс нутгийн хөгжлийг түргэтгэх, тодорхой нутгийн түвшинд эдийн засгийг төрөөс зохицуулах нийтлэг болон ялгавартай бодлого явуулах шаардлагыг харгалзан тогтоосон нутаг дэвсгэрийн зааг хүрээг **эдийн засгийн бүс** гэж тодорхойлдог. Түүнчлэн „...Эдийн засгийн бүс нь засаг захиргаа болон байгалийн бүсүүдийн нэгэн адил тодорхой хил хязгаараар урьдчилан тодорхойлогддоггүй, харин түүний хил хязгаар нь байгаль газарзүйн болон эдийн засаг, улс төрийн байгууллын хүчин зүйлсийн нөлөөн дор байнга хувьсан өөрчлөгдөж хөгжиж байдаг”⁶ айуу́и́ í í î ù í ÷èäëýèèéä àíõààð÷ ¿çýõ õýðýäýé.

Эдийн засгийн бүсчлэлийг хийхдээ тодорхой онол арга зүй, бүсчлэлийн шалгуур үзүүлэлтүүдийг ашигладаг. Эдийн засгийн бүс түүний хил хязгаарыг тогтоож тодорхойлохдоо:

- Улс орны болон тухайн бүсийн хөгжлийн хэтийн төлөв
- Тухайн орон нутгийн байгалийн нөхцөл нөөц, даац чадавхи
- Хүн ам, ажиллах хүчний нөөц, байршил,
- Аж ахуйн голлох чиглэл
- Аж үйлдвэрийн төвүүд, тээврийн сүлжээ түүний тэнхлэгийн таталцал
- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарь зэргийг зайлшгүй харгалзана.

2.2 Монгол улсын бүсчилсэн хөгжил

Өргөн уудам нутагтай, хүн ам цөөнтэй, хүн амын тодорхой хэсэг бэлчээрийн мал аж ахуй эрхлэн нэлээд таруу байршин нутагладаг онцлогтой Монгол Улсад бүс нутгийн хөгжлийн асуудалд түлхүү анхаарах шаардлагатай билээ. 1960-аад оноос Монгол улсыг байгаль нийгэм эдийн засгийн нөхцөл нөөц, хөгжлийн цаашдын чиг хандлагыг харгалзан *Төв, Дорнод, Өрнөд* гэсэн эдийн засгийн 3 бүсэд хувааж улс орныг төлөвлөн хөгжүүлэхэд ашиглаж байсан туршлага бий.

⁶Эрдэнэт хотын эдийн засгийн оронзайн бүтэц, хүрээ” сэдэвт судалгааны тайлан/ ГТХАН-МУИС, 2009/

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги


1990-ээд оноос Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжин орж эдийн засаг нийгмийн бүхий л харилцаанд хүн амын нутагшил суурьшил, үйлдвэрлэх хүчний байршилд өөрчлөлт бий болсонтой уялдаж улс орныг шинээр бүсчлэх асуудал гарч ирсэн.

Сүүлийн жилүүдийн нэг хүнд ногдох ДНБ, боловсролын байдал, хүн амын дундаж наслалт, ажилгүйдлийн түвшин, дэд бүтцийн хангамж, хүний хөгжлийн индекс зэрэг хөгжлийн шалгуур үзүүлэлтийг тооцон үзэхэд аймаг, хот, бүсүүдийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн ерөнхий түвшний ялгаа их болсон, байгаль орчин, экосистемийн тэнцвэрт байдлын алдагдал ч улам бүр бүс нутгийн шинж чанартай болж байна. Эдгээр сөрөг өөрчлөлтийг засаж залруулж, нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах, эдийн засаг, нийгэм соёл, хүн амын нутагшилт, хот байгуулалт, гадаад хамтын ажиллагааны таатай орчныг бүрдүүлэхийн тулд улс орныг шинээр бүсчлэн хөгжүүлэх шаардлага тавигджээ.

2001 онд УИХ –ын тогтоолоор “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг батлаж, эдийн засгийн 5 бүс болгон, бүс бүрт багтах аймаг, тулгуур төв хотуудыг дараах байдлаар тогтоожээ.

Хүснэгт 2. Эдийн засгийн бүсийн хуваарь

№	Эдийн засгийн бүс	Хамрагдах аймаг	Тулгуур төв, хот
1	Баруун бүс	Ховд, Увс, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан	Ховд, Улиастай
2	Хангайн бүс	Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Булган, Орхон, Хөвсгөл	Эрдэнэт, Хархорин
3	Төвийн бүс	Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр	Дархан, Зуунмод
4	Зүүн бүс	Дорнод, Хэнтий, Сүхбаатар	Чойбалсан, Өндөрхаан
5	Улаанбаатарын бүс	Улаанбаатар хот түүний дүүргүүдийн нутаг дэвсгэр, хот орчмын бүсийн дагуул хотууд	Улаанбаатар



Зураг 2. Монгол улсын эдийн засгийн бүс /2001/

Бүсчилсэн хөгжлийн үндсэн зорилгыг хангахын тулд эдийн засгийн хүрээнд: тухайн бүс дотроо аймаг сум бүр голлон эрхлэх аж ахуйн чиглэлээ зөв тогтоон өөр хоорондоо хоршин хөгжих замаар бизнесийн орчныг бүрдүүлэх, дотоод гадаад зах зээлтэй зохистой холбоо тогтоож, тэнцвэргүй тэгш бус байдлыг багасгах, эдийн засгийн өсөлт үр ашгийг тогтвортой нэмэгдүүлэх нөхцлийг хангах ёстойг тодорхойлсон.

Хөгжлийн гол бүсүүдийг тогтоохдоо засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваариас хамааралгүйгээр эдийн засгийн бүтцийн шинэчлэлт, хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл, бүс нутгийн нөөцийн ашиглалтын зохистой харьцаа, байгалийн бүс бүслүүр, экосистем, цаг уурын өөрчлөлт, экологийн тэнцвэрт байгаль зэргийг харгалзах шаардлагатай байдаг.

2.3 Монгол улсын эдийн засгийн төв бүс

Нутаг дэвсгэр, газарзүйн байрлал. Төвийн бүс нь манай улсын нутаг дэвсгэрийн 30.3% буюу нийт 470 гаруй мян (473.6мян) ам км нутагтай. Төвийн бүсийн нутаг дэвсгэрийн 80.3 хувийг хөдөө аж ахуйн газар, 11.1 хувийг ойн сангийн газар, 0.2 хувийг усан сан бүхий газар, 0.2 хувийг хот, суурин, үйлдвэр уурхайн газар, 0.2 хувийг зам, шугам сүлжээний газар, 8.0 хувийг нөөц болон ашиглах боломжгүй газар тус тус эзэлж байна.

Энэ бүсэд нийт 27 орчим сумыг хамарсан 6671.9 мян. га газрыг эзэлсэн тусгай хамгаалалттай газар нутаг 12 байгаа нь улсын нийт тусгай хамгаалалттай газар нутгийн 31.8 хувийг эзэлж байна.

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

Тухайн эдийн засгийн төв бүсийн нутаг дэвсгэр нь уртрагын дагуу сунаж тогтсон байрлалтай. Дунджаар далайн түвшнээс дээш 800-1500 м өндөрт байрладаг. Баруун талаар Хангайн нуруу, зүүн хойд талаараа Хэнтийн хил залган оршино. Өмнөд талыг нь Говь цөл эзэлдэг. Нутгийн гадаргын тогтоцын хувьд хойд хэсгээрээ дундаж нам өндөртэй уулстай, биомассын хэмжээ ихтэй бол урагшлах тутам биомассийн хэмжээ багасч тал хээр, говь цөлийн бүс үргэлжилнэ. Энэ нь бусад эдийн засгийн бүсүүдээс байгалийн орчин нөхцөлийн хувьд эрс тэс ялгаатай байдгаараа онцлог юм.

Газарзүйн байрлалын хувьд Монгол улсын зам тээвэр дэд бүтцийн хамгийн ашигтай байрлалд орших ба гадаад болон дотооддоо авто зам, төмөр замаар шууд харилцах боломжтой. Энэ бүсэд Орхон-Сэлэнгийн бэлчир, Бага Хэнтийн уулсаас урагш улсын хил хүртэлх тал хээр, говь, цөлийн, бүсийн тэгшивтэр гадарга зонхилдог бол бүсийн хойд хэсэг нь гадаргын усан сүлжээ сайтай, ой модны багагүй нөөцтэй.

Монгол орны газар нутаг гадаад далай тэнгисээс ихээхэн алслагдсан, Евразийн эх газрын төвд тал бүрээсээ өндөр уул нуруугаар хүрээлэгдсэн, далайн түвшнээс дунджаар километр хагас илүү өндөр өргөгдсөн зэргээс шалтгаалан эх газрын эрс тэс, хатуу ширүүн уур амьсгалтай. Өвлийн улирлын дундаж температур $-15^{\circ}\dots-30^{\circ}\text{C}$ ($6^{\circ}\dots22^{\circ}\text{F}$), зуны улирлынх нь $10^{\circ}\dots26.7^{\circ}\text{C}$ ($50^{\circ}\dots80^{\circ}\text{F}$) байна. Ойт хээрийн бүсэнд 250-300 мм, хээрийн бүсэнд 150-250 мм, говь цөлийн бүсэнд 150-50 мм орчим хур тунадас унана. Хур тунадас хойноос урагшавч түүний хуваарилалтанд газрын хотгор гүдгэрийн нөлөө их байна. Хур тунадасны 85% орчим нь жилийн дулаан улиралд /IV-IX сард/ үүнээс зөвхөн 7,8 дугаар сард 50-60% нь орно. Нутгийн хойд уулархаг хэсгээр 60-70 өдөр, говьд 30 орчим өдөр бороотой байх боловч жилийн хур тунадасны ихэнх нь цөөхөн хэдэн борооноос бүрэлддэг онцлогтой.

Төвийн бүс нь Монгол орны байгалийн ил задгай усны нөөц харьцангуй ихтэй нутаг юм. Бүсийн усны сангийн газар Монголын бүх усны сангийн газрын 29 хувийг эзэлдэг бөгөөд нутгийн 1.2 хувь нь гол мөрөн, нуур тойром, горхи булгийн ус байна. Монголын 3800 гаруй гол горхины 65.6 хувь нь, 1200-аад томхон нуур тойрмын 42.6 хувь нь, 6900-гаад булаг шандын 38 хувь нь энэ бүсэд байна.

Хүснэгт 3. Хөрсний хэв шинж

Хамгаалалттай газрын			Бэлчээрийн			Атаршсан газрын		
чийг	ялзмаг		чийг	ялзмаг		чийг	ялзмаг	
Шаварлаг хар хүрэн хөрс	XXXII (2,1,5)	0-10	5,1	2,1	5,4	2,08	7,9	1,33
	08.08.06	10-20	2,6	1,72	4,3	2,87	5,6	1,71
		20-30	2,2	0,88	3,3	2,1	5,3	1,49
Нунтаг карбонатлаг хөрс	XXXV (2.1.3)	0-10	2,9	5,58	4,0	2,1	5,3	1,83
	10.08.06	10-20	2,8	1,95	3,8	1,53	6,5	1,72
		20-30	4,2	0,95	4,4	1,14	5,5	0,95
Хайргархуу карбонатлаг	XXVI (2.1.3)	0-10	8,3	2,09	10,3	3,24	8,7	1,81
	03.08.06	10-20	8,2	2,34	7,4	1,81	13,4	1,14

хөрс		20-30	9,5	1,91	13,1	0,47	11,1	1,08
------	--	-------	-----	------	------	------	------	------

Жилийн ихэнх хугацаанд хөрс хуурай, салхины нөлөөгөөр хөрс элэгдэх процесс идэвхитэй явагддаг нутаг юм. Мөн энд Сэлэнгэ, Орхон, Туул зэрэг томоохон голууд хамаарагдах ба эдгээр голуудын хөндий, дэнжүүд, уулсын хормой бэлээр газар тариаланд тохиромжтой хүрэн хөрс тархжээ. Ургамалын бүрхэвчинд жинхэнэ нугын ба хээрийн бүлгэмдлүүд зонхилно.


Нутгийн хойд хэсгээр ан амьтдын тархалт шигүү тархсан харин өмнөд хэсгээрээ хээрийн бүсийн амьтад голлон тархжээ. Ан амьтны хувьд 4 баг, 11 овог, 20 төрөлд хамрагдах амьтан тархсан. 4 төрлийн туурайтан, 7 төрлийн махчин, 5 зүйл мэрэгч, 8 төрлийн жигүүртэн, хэвлээр явагч амьтан, шавжтай. Чойрын Богд, Сансар уулсын орчимд 150 гаруй аргаль, Халзангийн говь, Хүрэн дух, Баянхошууны говь, Нүхэн сондуул, Тогоогийн булаг орчимд хар сүүлт, цагаан зээр нутагшиж, 2000 оны судалгаагаар 6000 гаруй байна гэсэн тооцоо гарсан. Хээрийн тарвага 1 га-д 42 коэффициент байгаа нь улсын дундаж хэмжээнд байна. Жигүүртэн шувуудаас талын бүргэд, элээ, харцага, сар, ууль, ховордсон шувуудаас цармын бүргэд, идлэг шонхор зэрэг шувууд уул, хад асга бүхий газруудад амьдарч байна.

Эдийн засгийн төв бүсийн хөгжлийн нөхцөл, нөөц

Байгалийн нөхцөл, нөөцийн хувьд түлш-эрчим хүч, уул уурхайн олборлох ба баяжуулах үйлдвэр, газар тариалан МAA-г хослуулан хөгжүүлэх боломж ихтэй. Улсын ой модны нөөцийн 30% (29,7%), алт, газрын ховор элементийн ихэнх нөөц, нүүрсний нөөцийн 80 гаруй хувь (84%), жоншны 40 гаруй хувь тус бүсэд байдаг.



Зураг 3. Эдийн засгийн төв бүс



Зураг 4. Төвийн бүсийн хүн амын нутагшилт, сумдаар, 2010 оны байдлаар

Хүн ам.Төв бүс нь 7 аймаг, 95 сум, 359 багийн 430 гаруй мян (436 мян) хүн амтай. Энэ нь улсын хүн амын 17%-ийг эзэлдэг. Хүн амын 43% нь хот суурин газар суудаг. Бүсийн хамгийн том хотнь улсын хэмжээнд Улаанбаатар хотын дараа орох 80-аад мян хүн амтай, Дархан хот юм. Тус бүс нь Алтанбулаг, Замын-Үүд,Сүхбаатар хотын байнгын ажиллагаатай хилийн гарц боомтуудтаар гадаад зах зээлтэй харилцдаг байсан бол сүүлийн жилүүдэд уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй хөгжих болсноор Гашуун сухайт, Шивээ Хүрэн зэрэг байнгын ажиллагаатай боомтууд шинээр бий боллоо. Алтанбулагт "худалдааны чөлөөт бүс", Замын-Үүдэд "эдийн засгийн чөлөөт бүс" үүсгэн байгуулах аж үйлдвэрийн

цогцолбор”байгуулах ажил эхлээд байна.

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ 1918 онд 647.5 мянга байсан бол 2012 оны байдлаар 2.8 сая хүрч ХХ зуунаас бараг 4 дахин өсжээ. Томоохон өсөлт нь 1960 болон 1970 онд болж тухайн үед хүн амын дундаж өсөлтийн коэффициент 2.8-д дөхөж , 25 жилийн дотор хүн ам 2 дахин өссөн байна.

Төвийн бүсийн хүн амын өсөлт. Монгол улсын хүн ам 1918 онд 647.5 мянга байсан бол 2012 оны байдлаар 2.8 сая хүрч ХХ зуунаас бараг 4 дахин өсжээ. Томоохон өсөлт нь 1960 болон 1970 онд болж тухайн үед хүн амын дундаж өсөлтийн коэффициент 2.8-д дөхөж , 25 жилийн дотор хүн ам 2 дахин өссөн байна.

Төвийн бүсэд нийт 457690 хүн ам амьдардаг бөгөөд монгол улсын нийт хүн амын 16,3% оршиж байна. Нийт 95 сум, 362 баг хамаарах бөгөөд дундаж нягтшил 1.1 байгаа бөгөөд улсын дундажаас 0.72-оор бага байна. Төвийн бүсийн хувьд 2000 он хүртэл хүн ам харьцангуй тогтвортой өсөж байсан бол 2005онд 3% -иар буурч , 2010 оны байдлаар 6,7%-иар өсөлт ажиглагдаж байна.





График 1. Бүсүүдийн хүн амын өөрчлөлт



Зураг 5. Хүн амын тооны өөрчлөлт 2000, 2012он сумдаар

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

Хүн амын нягтшил байгалийн бүс, тэнхлэгээс алслагдсан байдал, дэд бүтцийн хөгжлийн ялгаатай байдлаас болж харилцан адилгүй, Баян-Өлгий аймаг, Хөвсгөлийн өмнөд, Өвөрхангайн хойд, Архангайн ихэнх нутаг, Төв, Сэлэнгэ аймагт хүн ам шигүү суудаг (Х.Цэдэнсодном 2003).

Хүснэгт 4. Хүн амын нягтшил

	Аймгууд	Сум, дүүргийн тоо	Баг, хорооны тоо	хүн ам	Газар нутаг ам км	нягтшил
1	Сэлэнгэ	17	56	103698	41153	2,52
2	Төв	27	97	87410	74041	1,18
3	Дархан	4	24	88875	3275	27,14
4	Говь-Сүмбэр	3	10	15240	5542	2,75
5	Дундговь	15	64	44601	14176	3,15
6	Дорноговь	14	57	60936	109472	0,56
7	Өмнөговь	15	54	56930	165450	0,34
8	Нийт	95	362	457690	413107	1,11
9	Улсын хэмжээнд	340	1662	2859982	1564100	1,83
10	Эзлэх хувь	27,94%	21,78%	16,00%	26,41%	

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Дээрх хүснэгтээс харахад Дархан-Уул, Сэлэнгэ, Говьсүмбэр аймгууд харьцангуй нягтшил ихтэй улсын дундажаас ойролцоогоор 2 дахин илүү байна. Харин Дундговь болон Өмнөговь аймгууд харьцангуй нягтшил багатай байгаа бөгөөд улсын дундажаас 3 дахин бага байна. Нягтшилтыг сумын хэмжээгээр авч үзвэл Даланзадгад(1км-т 808хүн), Сүхбаатар(1км-т 488хүн), Зуунмод(1км-т 791 хүн), Шарын гол(1км-т 85хүн), Дархан(1км-т 711 хүн), Замын үүд(1км-т 31хүн) харьцангуй өндөр нягтшилтай байгаа бол 1км-т 0,5хүн бага харцангуй сийрэг сууршилтай байгаа нь Мөнгөнморьт, Эрдэнэ, Баяндэлгэр, Баян-Өнжүүл, Сэргэлэн, Цагаандэлгэр, Баянцагаан, Дэлгэрэх, Айраг, Алтанширээ, Баянжаргалан, Өндөршил, Өргөн, Гурвансайхан, Хулд, Дэлгэрхангай, Өлзийт, Сайхандулаан, Мандал овоо, Эрдэнэ, Мандах, Булган, Улаан бадрах, Цогт овоо, Манлай, Гурвантэс, Ханхонгор, Сэрвэй, Хөвсгөл, Баяндалай, Хатан булаг, Ханбогд, Баян овоо, Хүрмэн, Ноён, Номгон зэрэг сумдад ажиглагдаж байна.

Төвийн бүсийн төрөлт, нас баралт

Төвийн бүсэд нийт 11082 хүүхэд төрсөн бөгөөд 22% Дархан Уул, 21%Төв аймаг, 17% Сэлэнгэ аймаг, 14% Дорноговь аймаг, 13% Өмнөговь аймаг, 9% Дундговь аймаг, 4% Говьсүмбэр аймаг эзэлж байна. Бүсийн хэмжээнд нийт 2925 хүн нас барсан бөгөөд Төв аймаг, Дархан уул аймаг болон Сэлэнгэ аймгууд нас баралт өндөр байна.

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

Хүснэгт 5. Хүн амын цэвэр өсөлт 2000, 2012 оноор

	Аймаг, сум	Төрөлт		Нас баралт		Цэвэр өсөлт	
		2000	2012	2000	2012	2000	2012
1	Сэлэнгэ	1 976	1932	654	543	1 322	1389
2	Төв	1 969	2279	627	668	1 342	1611
3	Дархан	1 561	2381	606	645	955	1736
4	Говь-Сүмбэр	242	449	107	109	135	340
5	Дундговь	1 214	950	335	291	879	659
6	Дорноговь	1 114	1587	343	373	771	1214
7	Өмнөговь	1 114	1490	370	296	744	1194

Эх сурвалж: Статистикийн эмхтгэл 2000он, Үндэсний статистикийн хороо

Хүн амын төрөлт болон нас баралтыг 12 жилийн өөрчлөлтийг аймгуудаар График 3, График 4-г харууллаа.




График 2. Хүн амын төрөлт 2000, 2012 он /аймгаар/




График 3. Хүн амын нас баралт 2000, 2012 он /аймгаар/

Төвийн бүсийн шилжих хөдөлгөөн. Хүн амзүйн нэг чухал үзүүлэлт бол хүн амын шилжих хөдөлгөөн юм. **“Шилжих хөдөлгөөн”** гэдэг нь *тусгайлан тогтоогдсон хил хязгаар бүхий засаг захиргааны нэгжүүдийн хооронд газар нутгийн байршлын /хот, хөдөө/ хувьд явагдах хүн амын суурьшлын өөрчлөлт юм.* Тэдгээрийн дотор шилжих хөдөлгөөний урсгалыг тодорхойлсон Рейвенштэйний шилжих хөдөлгөөний хууль голлох байр эзэлдэг юм. Эрдэмтэн судлаач Рейвенштэйн энэ онолоо 1880-аад онд анх томъёолсон бөгөөд уг хууль нь боломж нөхцөл багатай газар нутгаас, харьцангуй илүү сайн боломж нөхцөлтэй тийм бүс нутаг руу хүн ам тодорхой үе шаттайгаар шилждэг нь зүй тогтолт үзэгдэл гэдгийг тогтоожээ. Суурьших нутгаа сонгох сонголт нь зайнаас хамаардаг бөгөөд шилжигчид өөрийн уугуул нутагтаа ойр хөрш зэргэлдээ нутгийг илүүтэй сонгодог. Хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал, мөн хотоос хөдөө рүү буцах шилжих хөдөлгөөний урсгалыг бий болгодог нөхцлүүд ч байдаг гэдгийг эрдэмтэн Рейвенштэйн олон жилийн судалгааныхаа үр дүнд дэвшүүлсэн байдаг.

Хүн амын шилжих хөдөлгөөн гэдэг нь хүмүүсийн байнгын оршин суух газраа сольж, нутаг дэвсгэрийн хувьд нэг нутгаас нөгөө нутагт шилжин суух үзэгдэл (О.Сүхбаатар 1971) бөгөөд нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хүн амын тоо, бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлтөнд голлон нөлөөлдөг хүчин зүйл юм. Монгол улсад сүүлийн гаруй жилд хүн амын дотоод, гадаад шилжих хөдөлгөөн эрчимжиж, аймаг, нийслэл, бүс нутгийн хүн амын тоо, бүтцэд ихээхэн өөрчлөлт гарсан төдийгүй нийгэм, эдийн засгийн хөгжилд хүчтэй нөлөөлж байна.

1990 оноос өмнөх жилүүдэд манай улсад хөнгөн аж үйлдвэр, газар тариалангийн салбарыг шинээр үүсгэн хөгжүүлж эхэлсэнээр түүнийг дагасан шилжих хөдөлгөөн өрнөж, байсан бол 1990-ээд оноос эхэлсэн ардчиллын үр дүнд социализмын үед хүн амын шилжих хөдөлгөөнийг ялангуяа хөдөөнөөс Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод шилжихийг эрс хориглож байсан шийдвэр хүчингүй болж, шинэ үндсэн хуулиар монгол улсын иргэн оршин суух газраа өөрсдөө сонгох эрхтэй болсоноор баруун аймгуудаас төвийн район руу хүн амын шилжилт ихэссэн билээ. 2000 оноос хойш шилжих хөдөлгөөний үндсэн хоёр урсгал үүссэн:

1. Улаанбаатар хотруу чиглэсэн урсгал
2. Төвийн бүсрүү чиглэсэн урсгал

Шилжих хөдөлгөөнд оролцож буй хүн амын дийлэнх олонх нь хөдөө орон нутагт ажлын байр хомс ажилгүйдэл ихтэйн улмаас хөдөөгөөс хот руу болон төв суурин руу шилжин суурьшиж байна.

Судалгаанд хамрагдсан аймгуудын хүн амын шилжилт хөдөлгөөнийг 1990 оноос хойш арван жилийн хугацаатайгаар авч үзэхэд хамгийн их шилжин ирэгчдтэй аймагт Төв аймаг 1990-2000оны хооронд 8856 хүн, 2000-2012онд 11532 хүн тус тус шилжин ирсэн бөгөөд энэ хугацаанд шилжин явагчид хамгийн их аймагт мөн Төв аймаг багтаж байна. 1990 оноос шилжих хөдөлгөөн нийслэл хотруу чиглэж байснаас гадна газар тариалан эрчимтэй хөгжиж байсан Сэлэнгэ, Дархан, Төв аймагт түлхүү хандсан байна. Үүнээс үзвэл шилжилт хөдөлгөөн гэдэг нь аж амьдрал дээшлүүлэх түлхүүр болж, амьдрах өгөөж хаана сайн байна, тийш хүн амын шилжих хөдөлгөөн чиглэгдэж байдаг

байна.




График 4. Хүн амын шилжин ирсэн байдал 2000, 2010, 2012 он

Эх сурвалж: Статистикийн эмхтгэл 2000, 2010 он, Үндэсний статистикийн хороо




График 5. Хүн амын шилжин явсан байдал 2000, 2010, 2012 он


Эх сурвалж: Статистикийн эмхтгэл 2000, 2010 он, Үндэсний статистикийн хороо

Энэхүү хүн амын механик өсөлт болон тэнцвэргүй шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалан олон сөрөг нөлөө гарч байна. Өмнөговь аймгийн шилжих хөдөлгөөнийг авч үзэхэд 1990-2000 онд 11926 хүн шилжин ирж, 17153 хүн шилжин явсан байна. 2000 оноос 2012 онд нийт 8893 хүн шилжин ирж, 11131 хүн шилжин явсан байна.

Монгол орны газар тариалангийн гол нутаг болох Сэлэнгэ аймагт шилжилт хөдөлгөөн их байгаа бөгөөд тус аймагт газар тариалан эрхлэх зорилготой болон эдийн

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

засгийн хөгжлийг даган хүн ам шилжин ирж суурьшиж байна. Тус аймагт шилжин ирж буй хүн ам нь орон нутгаас Улаанбаатар хотыг чиглэсэн шилжих хөдөлгөөний хэмжээтэй харьцуулахад маш бага боловч, сууринд шилжин ирэх хүн амын тоо бусад аймгаасаа өндөр байна. Энэ бүсийн шилжин явагчдын 54% нь УБ хот руу шилжиж байна.



Зураг 6. Хүн амын шилжих хөдөлгөөн

Эхсурвалж: Статистикийн эмхтгэл 2000 он, Үндэсний статистикийн хороо

Шилжих хөдөлгөөнд орж буй шалтгаан. Хүн амын шилжих хөдөлгөөнийг хэрхэн тодорхойлж үнэлэлт, дүгнэлт өгдөг байх талаар дэлхийн олон эрдэмтэд төрөл бүрийн чиглэлээр судалгаа явуулж шилжих хөдөлгөөний үйл явцын үндэс болж буй хүчин зүйлийг тодорхойлох, түүнийгээ тодорхой параметрт хөрвүүлж цаашдын бодлого төлөвлөлтөд тус дөхөм болохуйц онол, практикийн ач холбогдол бүхий олон загваруудыг боловсруулан гаргасан байдаг. Шилжилт хөдөлгөөн хийхэд нөлөөлдөг хувь хүний үзэл бодол ба түүнийг дагасан дараалсан шилжих хөдөлгөөний үзэгдлээс дүгнэлт хийж, эрдэмтэн судлаач Эверет Лий 1966 онд шилжих хөдөлгөөний татах, түлхэх хүчин зүйл"-ийн тухай онол, загварыг боловсруулсан нь шилжих хөдөлгөөнийг нөхцөлдүүлэгч хүчин зүйлүүдийн нөлөөллийг нарийвчлан судлах арга зүйд үнэтэй хувь нэмэр болжээ.

Судалгаанд хамрагдсан аймгуудын хүн амын шилжилт хөдөлгөөнд “Татах-Түлхэх хүчин зүйлс” дараах байдлаар нөлөөлж байна. “Татах” хүчин зүйлд: 1). Эдийн засгийн хүчин зүйлд: томоохон хот суурин газар нь үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд зах зээл том, ажлын байр олох магадлал өндөртэй, авто зам төмөр зам, цахилгаан хангамж, дэд бүтцийн нөхцөл сайтай, барилга, уул уурхайн бүтээн байгуулалтын үйлдвэрлэл нь цалин өндөртэй гэх мэт, 2). Нийгмийн хүчин зүйлд: боловсрол эзэмших, чанартай эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах, ах дүү хамаатан садангаа бараадах гэх мэт, 3). Байгалийн хүчин зүйл мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд ойт хээр, хээрийн бүс нь зарим бүсээс газрын үршил шим илүүтэй зэрэг нь хүн амыг хамгийн ихээр шилжих хөдөлгөөнд оролцуулж байна.

Харин “Түлхэх” хүчин зүйлд: ажилгүйдэл, ядуурал боловсрол, эрүүл мэнд зэрэг төрийн үйлчилгээний чанар хүртээмж муу, мал аж ахуй, газар тариалан эрхлэхэд хүнд ган зуд байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт гэх мэт хүчин зүйлийн улмаас шилжих хөдөлгөөн хүн амаар оролцдог байна. Төвийн бүсийн хувьд нутгийн хойд хэсгийн аймгуудаар хүн амын татах хүчин зүйл нь түлхэх хүчин зүйлээсээ их байгаа боловч говийн аймгуудын алслагдсан сумдын хувьд харьцангуй түлхэх хүчин зүйл нь татах хүчин зүйлээсээ илүү их байна.

Хүн амын ажил эрхлэлт. Хүн амын ажил эрхлэлт нь хүн амын нутагшилт болон хотжилтонд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг. Ажил эрхлэлт гэсэн ойлголтонд хөдөлмөрийн насны хүн ам, эдийн засгийн идэвхтэй хүн ам, ажилчид, ажилгүйчүүд гэсэн ойлголтууд багтдаг бөгөөд судалгаанд хамрагдсан бүс нутгийн хувьд хөдөлмөрийн насны хүн ам 60,7 хувиар, эдийн засгийн идэвхтэй хүн ам 34,5 хувиар, ажилчдын тоо 20,6 хувиар өссөн бол ажилгүйчүүдийн тоо 21 хувиар буурсан байна. Энэ нь бүсийн ажил эрхлэлтийн түвшин өндөр байгааг харуулж байна.

Хүснэгт 6. Хүн амын ажил эрхлэлт 2000, 2012он

	Хөдөлмөрийн насны хүн ам		ЭЗ-ийн идэвхтэй хүн ам		Ажилчдын тоо		Ажилгүйчүүд	
	2000	2012	2000	2012	2000	2012	2000	2012
Дархан	47815	59204	22300	59204	20600	32100	1742	1732
Дорноговь	28279	40314	17360	24428	17360	23524	535	904

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

Дундговь	27287	29600	22638	20972	21775	21400	863	656
Говь-Сүмбэр	6535	9723	3900	3400	3600	3200	229	169
Өмнөговь	20781	34209	20800	21500	20085	20000	696	224
Сэлэнгэ	52088	69973	32200	41100	30700	38600	1508	669
Төв	53141	59280	42575	46900	37629	44200	1279	1088

Эх сурвалж: Статистикийн эмхтгэл 2000 он, Үндэсний статистикийн хороо




График 6. Ажилчдын тоо




График 7. Ажилгүйчүүдийн тоо




График 8. Хөдөлмөрийн насны хүн ам




График 9. Эдийн засгийн идэвхтэй хүн ам

Төв бүсийн аж ахуй. Төвийн бүсийг бусад бүстэй харьцуулбал түлш-эрчим хүч, уул уурхайн олборлох болон баяжуулах үйлдвэр, барилга, барилгын материалын үйлдвэр, хөнгөн-хүнс зэрэг аж үйлдвэрийн олон салбар харьцангуй сайн хөгжсөн. Газар тариалан МАА хослосон ХАА-н салбартай. ДНБ-ий 35%-ийг ХАА, 23%-ийг аж үйлдвэрийн салбар эзэлдэг. Тус бүс нь ашигт малтмалын нөөцөөр баялаг, улсын хэмжээнд дээгүүрт орох стратегийн ач холбогдол бүхий олон ордууд энэ бүсэд байрладаг.

Эрдэс баялгийн нөөц

Байгалийн нөөц баялаг түүн дотроос эрдэс баялгийн нөөц нь улс орны хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Эрдэс баялгийн нөөцийг зөв удирдан зохион байгуулж эдийн засгийн өсөлтөд оруулах нь улс орны хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Эрдэс баялгийн нөөцийг зөв удирдан зохион байгуулж эдийн засгийн өсөлтөд оруулах нь улс орны хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг.


áóóðàé õýâýúðýú ¿ëãñýí îðíóóà áèé. Эрсдийн нөөц нь гадаад валют болон хөрөнгө оруулалтын эх үүсвэр болдог. Эрдэс баялгийн нөөцөд суурилсан эдийн засгийг бусад байгалийн нөөцөд суурилсан эдийн засагтай харьцуулахад ДНБ-ий өсөлтийн түвшин нь хамгийн удаан⁷ гэж үздэг хандлага байхад ашигт малтмалын нөөц нь эдийн засгийн өсөлтийг хурдасгагч хөдөлгүүр гэж дүгнэсэн чиглэл байдаг. Түүнчлэн байгалийн нөөц бол хөгжлийг сааруулж, эдийн засгийн эрүүл бус тогтолцоог бий болгодог ч гэж дүгнэсэн байдаг. Гэхдээ эдгээр нь харьцангуй ойлголт бөгөөд тухайн улс орон өөрийн нутаг дэвсгэр дээрх нөөцийг хэрхэн зөв удирдан зохион байгуулж, эдийн засгийн эргэлтэнд оруулснаас шалтгаалан эдийн засгийн үр нөлөө нь гарч ирнэ.

Байгалийн нөөцийг ерөнхийд нь нөхөн сэргээгдэх ба нөхөн сэргээгдэхгүй нөөц гэж ангилдаг авч эдийн засгийн хөжилд нөлөөлөх байдал, байгаль орчинд үзүүлэх өөрчлөлт, нөлөөллөөс хамааран олон хэлбэрээр ангилж байна.

Харин газарзүйн үүднээс нөөцийг оронзайн ðóâüä **төвлөрөл, тархалтын** байдал áíëíí ðóðàéí í°°òèéä ðóâáààððèéàð äýä á¿ðüðèéí áíëíìæ ¿ýðýä íü ÷óðàé ¿¿¿¿ëýðè¿¿ä áíëäíã äàéíà. Эдийн засгийн төвийн бүсийн хувьд ашигт малтмалын нөөц баялаг ихтэй бөгөөд улсын хэмжээний томоохон стратегийн орд газрууд байршиж байна. Эдгээр орд газруудад тулгуурласан үйлдвэрүүдийг бий болгохын тулд тухайн үйлдвэрлэл явагдахад шаардагдах эрчим хүчний эх үүсвэр, ажиллах хүчний хангамж, үйлдвэрийн цогцолборыг барих барилгын түүхий эдийн хангамжийн асуудал тавигдана.

Энэ хэсэгт төвийн бүсийн эдийн засгийн хөгжилд тухайн бүс нутгийн эрдэс баялгийн нөөц ямар үр нөлөө үзүүлж буй нөлөөг илэрхийлэхийн тулд төвийн бүсийн íòðàä äýãñãýð äýõ ýðäýñ äàýèäèéí í°°ò, ðýääýððèéí àøèäèèèðüí äàéäàè, äàçàð¿¿éí äàèðøèüíõ íü ðóâüä ðàðóòèèàð, äýä á¿ðüðüé ðýððýí ðíèáíãíæ äàéäããä ¿óðãããð èëýððèééíý.

Àøèäò ìàèðìàèä ñóððèèñàí äæ ¿èèäýððèéä ð°äæ¿¿ëýðýä ðàìàèéí ÷óðàè ñóððü áíëíõ ð¿÷èí ¿¿èè áíè òñàí ðàíããíæ þì. Óòè óóððàéí äæ ¿èèäýð ð°äè°ð÷ áóé °íí°ä ðýñýä áíè äàéäàèèèéí á¿ñ á¿ñè¿¿ðèéí ðóâüä äíâü, ðýýððèéí á¿ñýä îðøèð ó÷èð äãããðäüí òñàí ðàíããíæ ìóððàé þì.



Схем 4. Байгалийн нөөц

Эдийн засгийн төвийн бүс нь металл ашигт малтмал болон шатах ашигт малтмал түүнчлэн бусад эрдсийн нөөцөөр ихээхэн баялаг юм.

Ò°àèéí á¿ñ äýõ øàðàð àøèäò ìàèðìàè üí í°°ò, îðä äàçðóóä

Ò°àèéí á¿ñýä í°°ò íü ðíãðíãñíí îðä äàçðüí ðíí 20 îð÷èì äàèò á°ã°ä ¿¿íýýñ ðíãðíèè àæèèèäí í¿¿ðñ íèáíðèíæ äàéäããä óèññí ÷àíàððàè óóððàéí ðíí 5 äàèò äã áóñãä

⁷ R. M. Auty "Resource Abundance and Economic Development" 2004

Цагаан-Овоо, Тавантолгой, Хөмүүлгэй, Шивээ-Овоо, Багануур, Тэвшийн говь, Баянжаргалан, Нарийн сухайт, Улаан-Овоо

байна. /График №1/




График 10. Төвийн бүсэд орших нүүрсний орд газар, уурхайнууд

Цагаан-Овоо, Тавантолгой, Хөмүүлгэй, Шивээ-Овоо, Багануур, Тэвшийн говь, Баянжаргалан, Нарийн сухайт, Улаан-Овоо

- **Таван толгой**-Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Улаан нуурын хөндийд байрлах Таван толгойн чулуун нүүрсний орд газар нь нийт 80 мянган га газрыг хамрах бөгөөд 1.5 миллиард тонн коксжих болон эрчим хүчний батлагдсан, 4.9 миллиард тонн олборлох боломжит нөөц бүхий стратегийн ач холбогдол бүхий орд газар юм. Нийт нөөц 6,420 тэрбум тонн, үүний 1,781 тэрбум тонн нь коксжих, 4,639 тонн нь эрчим хүчний нүүрс юм.
- **Нарийн сухайт**-Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт оршдог бөгөөд Даланзадгад хотоос 296 км, Улаанбаатар хотоос 849 км, Гурвантэс сумын төвөөс зүүн урагш 34 км зайд оршдог. Нөөц нь 125.5 сая тонн.
- **Багануур** -Төв аймгийн нутагт Улаанбаатар хотоос зүүн тийш 130 км, Баяндэлгэр сумаас зүүн тийш 15км, төмөр замын Мааньт өртөөнөөс 80 км зайд оршино. 560 сая тн нүүрсний нөөцтэй болох нь тогтоогдсон.
- **Шивээ-Овоо**-Дорноговь аймгийн Сүмбэр сумын нутагт оршино. Орд нь Чойрын төмөр замын станцаас 25 км, Шивээ овоо уулаас зүүн хойш 3 км-т байрладаг. Шивээ овоогийн ордын Шинэ-Усны хэсэг нь Чойрын станцаас зүүн 20 км-т байрлах ба баруун хэсгээр нь Чойр-Сайншандыг холбосон төмөр замтай бөгөөд Чойр- Сайншандыг холбосон шороон зам Шивээ-Овоог дайрч гарна. Нөөц нь 646.2 тн байна.
- **Шарын голын нүүрсний уурхай**- Аюулхан-Орлоо аймагтай Өмнөговь аймгийн Дархан, Эрдэнэтийн дулааны станцууд руу нийлүүлдэг. 11441.6 тн байна. Дайрч гарна. Нөөц нь 11441.6 тн байна.

áàãà áíëíâ- òíìíîíí ÄÕÑ-óòá ðóó í¿¿ðñýú íèëë¿¿ëäýã, ò°âèéí á¿ñèéí òíéá òýñýãð íèëýýí à- òíéáíããíèðíé óòððäé þì.




График 11. Олборлолт хийж буй нүүрсний уурхайн олборлолтын хэмжээ⁸

Төвийн бүсийн металл ашигт малтмалын ордууд

- **Төмөртэйн орд** нь Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших бөгөөд төмрийн хүдрийн бодит болон боломжит нөөц нь 229.3 сая тн, ба хүдэр дэх төмрийн дундаж агуулга нь 51.64% юм. Төмөртэйн орд нь уул техникийн нөхцлийн хувьд ил аргаар ашиглахад тохиромжтой ба хүдрийн биетийн хэсгүүдээс хамааруулан 3 карьер байгуулж, эхний жил 2,0 сая тонн, дараах 2 жилд 4,0 сая тонн, цаашид жилдээ 6.5 сая тн төмрийн хүдэр олборлох уурхай, баяжуулах үйлдвэр барих ба баяжуулах үйлдвэрээс гарсан бүтээгдэхүүнийг Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийг түшиглэн барих үйлдвэрт нийлүүлэхээр төлөвлөж байна.
- **Оюу толгойн зэс-молибдений орд.** Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах уг орд нь 26 сая тонн зэс, 800 тн алтны нөөцтэй болох нь тогтоогдсон байна. Ашиглалтыг дараах байдлаар хийхээр төлөвлөж байна.
 - Ил уурхай болон баяжуулах үйлдвэр 2009-2010 оноос,
 - Далд уурхай 2014 оноос ажиллаж эхлэх боломжтой.
 - 2015 он хүртэл хугацаанд 500 мян. тн-оос доошгүй баяжмал боловсруулах хүчин чадалтай зэсийн заводыг барьж байгуулна.
 Уурхайн олборлолт, болон хийгдэх ажлуудыг дараахь байдлаар тооцоолоод байна.
- **Цагаан суврагын орд** - Цагаан Суваргын зэсийн орд нь Дорноговь аймгийн нутагт, Сайншанд хотын төмөр замын станцаас баруун урагш 220 км-т, Мандах сумын төвөөс урагш 75 км-т дэд бүтэц хөгжөөгүй говь, хээрийн бүсэд оршдог.

⁸ Эрдэс баялаг, эрчим хүчний яамны эрчим хүчний салбарын үйлдвэрлэлтийн мэдээ

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

Зэсийн энэ орд нийт 7 хүдэржилтийн бүсэд хуваагддаг ба үйлдвэрлэлийн сонирхол татсан хэсэг нь Сэрвэн Сухайтын хэсэг юм. Сэрвэн Сухайтын хэсэгт 44 400 тонн зэс агуулсан 10 сая 639 200 тонн исэлдсэн хүдэр, 1 280 850 тонн зэс бүхий 240 сая 044850 тонн сульфидын хүдрийн нөөцийг ашиглахад бэлэн байна.

Хүснэгт 7. Төвийн бүсэд байрлах стратегийн орд газрууд

	Ордын нэр	Байршил	Төрөл	Нөөц /сая.тн/
1	Төмөртэй	Сэлэнгэ Хүдэр сум	Төмөр	229.3
2	Бороо	Сэлэнгэ Мандал сум	Алт	24.533
3	Багануур	Улаанбаатар Багануур дүүрэг	Нүүрс	600
4	Шивээ Овоо	Говьсүмбэр Шивээговь	Нүүрс	646.2
5	Таван толгой	Өмнөговь Цогтцэций сум	Нүүрс	6420
6	Цагаан суварга	Дорноговь Мандах сум	Зэс молибден	240.1
7	Нарийн Сухайт	Өмнөговь Гурвантэс	Нүүрс	125.5
8	Оюу Толгой	Өмнөговь Ханбогд	Алт зэс	2300

Ордын нэр, байршил, төрөл, нөөц /сая.тн/ 2007 оны 27-д өгөгдөлийн үндэстэн дээр үндэслэн 15 дахь жилд өөрчлөлт оруулж байна. Үүнийг 8-ий дахь жилд өөрчлөлт оруулж байна. /Хүснэгт №4/ Өөрчлөлт оруулж өгөгдөлийн үндэстэн дээр үндэслэн 15 дахь жилд өөрчлөлт оруулж байна.


Төвийн бүсийн барилгын материалын орд газрууд

1980-1990 он хүртэл барилгын материалын эрдэс түүхий эдийн баазыг бэхжүүлэх, олборлосон эрдэс, түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх, шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцлийг хангах, чанарыг дээшлүүлэх зорилгоор геологийн эрэл хайгуул эрчимтэй явуулж байснаар төмөр, бетон эдлэхүүн, ханын материал /хүрмэн блок, тоосго/, дулаан тусгаарлагч материал /эрдсийн хөвөн/, нүх сүвэрхэг дүүргэгч материал /керамзитан элс, хайрга, галт уулын шаарга/, барьцалдуулагч материал /цемент, шохой/ бусад төрлийн барилгын материал үйлдвэрлэх түүхий эд болох барилгын чулуу, элс-хайрга, барилгын ба силикатын элс, галт уулын шаарга, перлит, керамзитийн ба тоосгоны шавар, шохойжин, эрдсийн хөвөнгийн түүхий эд /хүрмэн чулуу, доломит/, гөлтгөнө зэрэг барилгын материалын гол нэр төрлийн эрдэс түүхий эдээс зарим нь манай оронд ихээхэн түгээмэл тархжээ.

Төвийн бүсийн хувьд бусад бүсүүдтэй харьцуулахад барилгын материалын түүхийн эдийн тархалт ихтэй юм. Тухайлбал Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт бүх төрлийн барилгын материалын тархац жигд байгаагаас гадна эрдэс хөвөнгийн үйлдвэрлэлийн түүхий эдийн орд манай улсын хэмжээнд 4 байдгаас 2-нь уг аймгийн нутаг дэвсгэр дээр төвлөрсөн байна. Барилгын материалын үйлдвэрлэлийн хөгжлийн бодлогод тэргүүлэх чиглэлд нь дулаан тусгаарлах материалыг оруулж, тэдгээрийн дотроос хөөсөн ба хийжсэн силикат бетон хийц, эрдэс түүхий эдийн бэлэн байгаа нөөцөд түшиглэсэн перлитэн, алевролитон, керамзитан хөнгөн дүүргэгч бүхий

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

эдлэхүүний үйлдвэрлэлийг нэн тэргүүнд тавьж хөгжүүлэх зорилтууд тавигдаж байгаатай холбогдуулан Дархан-Уул аймагт барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хуучин байгаа үйлдвэрүүдийг сэргээх, хүчин чадал болон технологийн шинэчлэл хийх нь чухал болоод байна.



Зураг 7. Барилгын чулууны орд газрууд /нөөц/





График 12. Барилгын материалын олборлолт

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги



Зураг 8. Төвийн бүс дэх хотуудыг түүхий эдээр хангах байршлын зураг

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

Хүснэгт 8. Төвийн бүсийн голлох ашигт малтмалын орд газрууд

¹	Ордын нэр	Байршил	Төрөл
1	Ар наймган	Төв, Заамар сум	Алт
2	Бороо	Сэлэнгэ, Мандал сум	Алт
3	Бумбат	Төв, Заамар сум	Алт
4	Хайлааст	Төв, Заамар сум	Алт
5	Их ташир	Сэлэнгэ, Мандал сум	Алт
6	Нарантолгойн	Төв, Жаргалант	Алт
7	Нарангийн голын	Төв, Заамар	Алт
8	Өлөнт цамхаг	Сэлэнгэ, Орхон-Туул сум	Алт
9	Сүжигтэй	Төв, Борнуур	Алт
10	Толгойт	Дархан-Уул, Шарын гол сум	Алт
11	Цагаан гозгор	Сэлэнгэ, Орхонсум	Алт
12	Шарын гол	Сэлэнгэ, Орхон-Туул сум	Алт
13	Үлбаг	Сэлэнгэ Мандал сум	Алт
14	Оюу толгой	Өмнөговь, Ханбогд сум	Алт Зэс
15	Цагаансуврага*	Дорноговь	Зэс Молибден
16	Баянгол	Сэлэнгэ, Ерөө сум	Төмөр
17	Төмөртэй*	Сэлэнгэ, Хүдэр сум	Төмөр
18	Хар морьт	Өмнөговь, Номгон сум	Цагаан тугалга
21	Зүүн элстэй	Төв, Эрдэнэ сум	Цагаан тугалга
22	Элстэй	Төв, Эрдэнэ сум	Цагаан тугалга
23	Оорцог овоо	Дундговь, аймаг	Цагаан тугалга
24	Хар айраг	Дорноговь, Айраг сум	Хайлуур жонш
25	Чулуут цагаан дэл	Төв, Баянцагаан сум	Хайлуур жонш
26	Зүлэгт	Төв, Баян сум	Бал чулуу
27	Алаг тогоо	Дорноговь	Нүүрс
28	Багануур*	Улаанбаатар, Багануур	Нүүрс
29	Баянжаргалан	Дундговь, Баянжаргалан сум	Нүүрс
30	Их улаан нуур	Төв, Баянжаргалан сум	Нүүрс
31	Налайхын орд	Улаанбаатар, Налайх	Нүүрс
32	Нарийн сухайт*	Өмнөговь, Гурвантэс сум	Нүүрс
33	Таван толгой*	Өмнөговь, Цогтцэций сум	Нүүрс
34	Түшлэг	Дорноговь, Өргөн сум	Нүүрс
35	Тэвшийн говь	Дундговь, Дэлгэрцогт сум	Нүүрс
36	Улаан овоо	Сэлэнгэ, Түшиг сум	Нүүрс
37	Хамрын хурал	Дорноговь, Өргөн сум	Нүүрс
38	Хөмүүлтэй	Дундговь, Баянжаргалан сум	Нүүрс
39	Цагаан овоо	Дундговь, Цагаан Овоо сум	Нүүрс
40	Шарын гол	Дархан-Уул, Шарын гол сум	Нүүрс
41	Шивээ-Овоо*	Говь-Сүмбэр, Шивээговь сум	Нүүрс
42	Баян эрхэт	Дундговь, Баянжаргалан сум	Шатдаг занар

*- стратегийн орд газрууд

Дээрх орд газруудаас стратегийн ач холбогдол бүхий ордуудыг түшиглэсэн уул уурхайн газруудыг шинээр байгуулж, түүнийг дагасан аж үйлдвэрийн томоохон

цогцолборууд, хот суурин, зам харилцааны тэнхлэгүүдийг бий болгохоор зорьж байна. Тухайлбал Оюу толгой, Таван толгой төслүүд, Сайншандын аж үйлдвэрийн парк зэрэг болно.


Тус бүсийн Өмнөговь аймгаас бусад аймгууд төвийн эрчим хүчний системд холбогдсон бөгөөд Сүхбаатараас Замын-Үүдийн боомт хүрдэг эрчим хүчний систем (ЭХС) хойшоо ОХУ-ын Буриадын ЭХС-тэй Галуутгнуурын ДЦС-аар дамжин холбогддог. Өндөр хүчдэлийн ЦДШ-аар урагшаа Замын-Үүд-Эрээний чиглэлээр БНХАУ-ын Өвөр Монголын ӨЗО-ны ЭХС-тэй холбогдсон.

Төвийн бүсийн аймгийн төв хотуудад аймаг орон нутгийн болон бүс нутгийн ач холбогдолтой хөнгөн-хүнс, барилгын материалын үйлдвэрүүд бий. Аж үйлдвэрийн төв хотоос Дархан хот нь аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний хэмжээгээр улсад 3-рт ордог 1961 онд анх байгуулагдах үеэсээ Дархан хотыг хүнд аж үйлдвэр, тухайлбал түлш-эрчим хүч, барилгын материалын үйлдвэрийн төв байхаар төлөвлөгдөн байгуулагдсан юм. Энэ хотод шохой, тоосго, керамзит, бетоны үйлдвэрүүдээс гадна монгол улсын хар төмөрлөгийн үйлдвэр ажилладаг. Мөн мах, гурилын комбинат, хүнсний үйлдвэрийн салбаруудтай. Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар хот Монгол улс ба ОХУ-ын Зүүн Сибирьтэй холбосон төмөр ба автозамын хилийн чухал боомт төдийгүй цаашид аж үйлдвэрийн олон салбар хөгжих боломжтой хот юм. Энд чүдэнзний үйлдвэр, орон нутгийн чанартай хүнсний болон хөнгөн үйлдвэрийн зарим салбарууд ажилладаг.

Хөдөө аж ахуй. Төвийн бүс нутаг нь харьцангуй чийглэг ойт-хээрийн заримдаг хээр, говийн гэсэн харьцангуй өөр хоорондоо байгалийн нөхцөл нөөцөөр ялгаатай экосистемийн 3 үндсэн бүс бүслүүрт хуваагддаг. Энэ нь ХАА-г төрөлжүүлэн хөгжүүлэх чиг хандлагыг ерөнхийдөө бүрдүүлж байгаа юм. Бүсийн хойд хэсэг нь газар тариаланд тохиромжтой байхад өмнөд хэсэг нь МАА эрхлэхэд илүү тохиромжтой байдаг.

Бүсийн газрын сангийн 80-аад хувийг бэлчээрийн талбай эзэлдэг. Энэ нь улсын дүнгийн 29%-тай тэнцэх юм. Бүсийн бэлчээрийн талбайн ихэнх нь өмнөд хэсгийн говийн аймгуудад ногдож байна.

Төв бүсэд сүүлийн 5 жилийн дунджаар 6 сая гаруй мал байгаагийн ихэнх нь говийн аймгуудад ноогдож байна. Бүх малын бараг 90 хувийг ямаа, хонь эзэлдэг. Түүнийг



Зураг 9. Малын тоо толгойн өсөлт, бууралт 1990-2010

хангай ба говийн бүсээр авч үзвэл эрс ялгаатай. Ямааны 60-70%, хонь, адууны 50-60%, тэмээний 97 хүртэлх хувь нь хээр, говийн бүсийн аймгуудад байхад ойт-хээрийн бүсэд үхрийн 60 гаруй хувь нь байна. Энэ нь нутагбэлчээрийн онцлог, хот суурингийн суурьшилтай шууд холбоотой юм. Харин тариалангийн талбай нь Төвийн бүсийн газрын сангийн 1,2%-ийг эзлэх юм. Гэвч тариалан болон хадланд тохиромжтой талбайн дийлэнх хувь хойд хэсгийн Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймагт ноогддог нь өмнө дурдсан байгалийн онцлогтой холбоотой. Төвийн бүсийн хэмжээнд нийт 120 гаруй мян га газар (124,3 мян) тариалж байгаагийн 99,7% нь Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймаг ноогдож байна. Тариалангийн талбайн бараг 90 хувьд үр тарианы ургамал, тухайлбал хатуу сортын улаан буудай тариалж байна.

Үйлчилгээний олон салбар харьцангуй сайн хөгжсөн. Үүнээс аялал жуулчлал бол энэ бүсийн ирээдүйтэй салбарын нэг мөн. Тухайлбал Дорноговь аймагт шашин, түүх, соёл, амралт, рашаан сувилал хосолсон, Дундговь аймагт амралт, спорт-аялал, ардын урлаг (уртын дуу), нүүдлийн уламжлал, суурин соёлын ололтыг хосолсон, Өмнөговь аймагт тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН)-ийн сүлжээнд түшиглэн байгалийн аялал жуулчлалыг тус тус хөгжүүлж байгаа одоогийн байдлыг улам лавшруулан, тэдгээрийг УБ-ын болон Хангайн бүсийн аялал жуулчлалын төвүүдтэй зам тээвэр, холбоо-мэдээллийн нэгдсэн сүлжээгээр холбох бодлогыг баримталж байна.

III БҮЛЭГ. ТӨВИЙН БҮСИЙН ХҮН АМЫН НУТАГШИЛТ, ХОТЖИЛТ

3.1 Төвийн бүсийн нутагшилтийн өнөөгийн байдал

Хүн амын нутагшилтын тухай ойлголт

Хүн амын нутагшилт нь хүмүүсийн оршин амьдарч буй хэв маягийг илэрхийлсэн байдаг. Ийм учраас тодорхой хэмжээний нутаг дэвсгэрийн хүн амын тархалтын хэлбэрийг тодорхойлохын тулд нутагшилт гэдэг нэр томъёог хэрэглэдэг.

Монгол улсын хүн амын нутагшилт, суурьшилын үндсэн 2 хэлбэр болох хот, хөдөө бөгөөд хүн амын шилжих хөдөлгөөний нөлөөгөөр хотжилт эрчимтэй явагдаж 2012 оны байдлаар 63 хувьд хүрчээ. Тодруулбал хүн амын 42.9 % нь нийслэл хотод (аглемраци буюу том хот дагасан), 32 хувь нь 350 хот, суурин газар, үлдсэн хувь нь 25.1 хувь нь хөдөө (жигд буюу засаг захиргааны нэгжүүд дагасан) амьдарч байна.

Хүснэгт 9. Хотжилтын түвшин бүсээр

Бүсийн нэр	Хотжилтын хувь					
	1990	1995	2000	2005	2010	2012
Баруун бүс	25.4	27.6	28	29.3	30.3	32
Төвийн бүс	38.6	41.5	43	42.5	42.4	45
Хангайн бүс	31	32.9	33	34.8	37.4	38
Зүүн бүс	35	38.2	39.3	40.7	39.9	42
Улаанбаатар	100	100	100	100	100	100

Эх сурвалж: Статистикийн эмхтгэл, Үндэсний статистикийн хороо

Судалгаанд хамрагдаж буй төвийн бүсийн хувьд 45 хувь нь хотжсон бөгөөд 1990 оноос 2000 он хүртэл хотжилт 4.4%-аар өссөн бол 2000 оноос 2012 оны хооронд 2.5% -иар өсч, Төвийн бүс нь хотжилтын түвшнөөрөө Зүүн бүсээс 3%-иар, Хангайн бүсээс 7%-иар, Баруун бүсээс 12% илүүтэй байна. (График 13)




График 13. Хотжилтын түвшин

Эх сурвалж: Статистикийн эмхтгэл, Үндэсний статистикийн хороо

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

Сумдын төвийн хүн амын тоонд шинжилгээ хийж үзэхэд хөдөөгийн суурингийн тоо болон хот маягийн суурингийн харьцангуй тогтвортой, хотын тоо өсөлтэй байгаа хүн ам Аймгийн төв болон томоохон үйлдвэрлэл уул уурхайн сууринд ихээр татагдаж байгааг харуулж байна.

Хүснэгт 10. Хотын хүн амын тоо

Хэлбэр	Сумын төвийн хүн ам	1990	1995	2000	2005	2010	2012
Хөдөөгийн суурин	500-1500	55	57	59	62	59	60
Хот маягийн суурин	1501-5000	29	27	23	22	24	24
	5001-10000	4	6	6	4	4	3
Хот	10001-дээш	7	5	7	7	8	8
	Нийт сумын тоо	95	95	95	95	95	95


Эх сурвалж: Статистикийн эмхтгэл, Үндэсний статистикийн хороо

Хот, хөдөөгийн хүн амын нутаг дэвсгэрийн ялгаа

Хүн амын суурьшлын судалгааны объект нь хот, хот маягийн суурин, хөдөөгийн бус суурин газар юм. Үндсэн хуулинд хот гэсэн ухагдахуун байхгүй тул хот гэдэгт аймгийн төв, хот маягийн сууринд сумын төв, хөдөөгийн бус сууринд уул уурхай олборлох үйлдвэрийн, амралт сувилалын, тээврийн транзит суурин, зам дагуух суурин, төмөр замын станцуудыг оруулав.

Төв байршлын онолоор ямар ч суурин газар өөрийн гэсэн үйлчлэх орон зай, нутаг дэвсгэрийн хүрээтэй байна. Сумын төвүүд хоорондоо татагдаж, бэхжиж гүйцэтгэх үүрэг нь томорсноор, түүний үйлчлэх хүрээ нэмэгдэж, үйлчлэх хүрээнүүдийн давхцал явагдсанаар хотуудын гинжин холбоог үүсгэдэг.

Хүн амын тооны өөрчлөлт



Зураг 10. Сумын төв болон хөдөөгийн хүн амын харьцаа

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

Аймгийн төв болон тэнхлэгээс алслагдсан зайн шатлалыг тооцоолохдоо “У/Шат КөШу”-ийн аргачлалыг ашигласан бөгөөд аймгийн төвөөс 40 хүртэл км, 40-100км, 100- аас дээш км болон тэнхлэгээс 30 хүртэл км, 30-100 км, 100-аас дээш км гэсэн шатлалын тооцоо гарсан.

Аймгийн төвөөс алслагдсан байдлыг хувьд хамгийн хол нь 278км зайтай, хамгийн ойр нь 12км зайтай байна.

Хүснэгт 11. Аймгийн төвөөс алслагдсан байдал

№	Аймгийн нэр	Аймгийн төвөөс алслагдсан байдал																Бүгд
		0-30 км				30-50 км				50-100 км				100-с дээш				
		I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	
1	Сэлэнгэ		1	1	1						1	1	2	1	3	2	3	16
2	Говьсүмбэр				1			1										2
3	Дархан Уул			1				2										3
4	Дорноговь								1		2	1	1	1	3	4		13
5	Төв		2				1			1	2	4	1	4	3	4	4	26
6	Дундговь							2		2		3	1	1	2	1	2	14
7	Өмнөговь			1				1			1	1	2		2		6	14
	Нийт	0	1	3	2		1	6		3	3	9	11	10	8	13	17	88

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 12. Алслагдсан байдлаас хамаарсан хүн амын өсөлт


№	Аймгийн нэр	Аймгийн төвөөс алслагдсан байдал																Аймгийн өсөлт			
		0-30км				30-50 км				50-100 км				100-с дээш							
		I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV				
1	Сэлэнгэ		18,9	31,4	6,8									18,6	4,2	11,9	31,4	6,2	-5,2	1,5	5,5
2	Говьсүмбэр				19,5			13,4													16,5
3	Дархан Уул			1,2				2,2													1,7
4	Дорноговь									-3,0		17,3	-3,1	14,4	7,9	1,6	2,8				-2,0
5	Төв		-7,4				23,4			17,3	60,0	27,6	4,0	29,8	44,0	34,0	12,5				-8,4
6	Дундговь						64,9		15,5	19,2		27,9	23,4	26,0	49,3	18,6	-7,3				-18,0
7	Өмнөговь			22,8				22,9			12,2	57,7	-7,3		23,0		7,7				-1,6
	Дундаж		13,1	3,2	13,1		44,1	-2,4	15,5	-1,6	17,8	-2,2	-3,5	-9,7	20,4	12,5	-1,5				-1,23

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Сэлэнгэ, Дархан Уул .говьсүмбэр аймгуудийн хувьд хүн ам нь 16.5% хүртэл өсөлтэй ажиглагдаж байгаа бол бусад аймгийн хувь -18% хүртэл бууралтай байна.

Аймгаас 30км хүртэл зайтай сумд 0.5% ийн өсөлттэй Аймгаас 30-50км хүртэл зайтай сумд -10.3%ийн бууралт Аймгаас 50-100 км хүртэл зайтай сумд -1.3% ийн бууралттай Аймгаас 100 км ээс дээш зайтай сумд -2.4% ийн бууралттай байна.

Энэ нь аймгийн төвөөс ойр (30 км хүртэл) болон хэт хол буюу (50км хүртэл) сумдын хувьд хүн ам харьцангуй бууралт багатай байгаа бөгөөд 30-50 км хүртэл зайтай сумдын бууралт өндөр байгаа нь ажиглагдаж байна.



Зураг 11. Хүн амын нутагшилтын хэлбэр

Эх сурвалж: НЭЗ секторын 2006 тайлан, Статистикийн эмхтгэл

Нутагшилтын хэлбэрүүд:

- ХАА, газар тариалан эрхлэхэд тохиромжтой үржил шимт хөрс болон ашигт малтмалын олборлох үйлдвэртэй шууд уялдаж Улаанбаатар лүн, Улаанбаатар багануур салбар тэнхэлгийн дагуу суурингууд олноор байгуулагдаж байгаа нь хүн амын нутагшилтын шугаман хэлбэр
- Аймгийн төвүүд болон томоохон уул уурхайн боловсруулах үйлдвэрүүдийг түшиглэсэн хүн амын нутагшилтын төвлөрсөн хэлбэр
- Сум, багийн төвүүд, тосгон, төмөр замын өртөө, амралт сувилал зэрэг суурингууд хүн амын нутагшилтын ареал хэлбэр
- Газар тариалан, мал аж ахуй эрчимжсэн, цаашид эрчимжих боломжтой хүн амын олонхи нь суурьшилтай нутаг нутагшилтын бичил бүсийн хэлбэр
- Улаанбаатар, Дархан, Сүхбаатар, Алтан булаг зэргийг холбосон засмал болон төмөр замд татагдсан дэд бүтэц олон жил хөгжсөн хүн амын нягтшил ихтэй зурвас талбайг хамарсан хүн амын зурвас хэлбэрүүд үүснэ.

3.2 Төвийн бүсийн хотжилт

Хотын тухай ойлголт

Хот гэдэг ойлголтыг улс орон бүр өөрөөр тодорхойлсон байдаг. Зарим улс оронд хотын статусыг хуулчлан тогтоосон байхад (ОХУ, АНУ, Канад, Алжир), зарим оронд үзүүлэлтээр болон түүхэн уламжлалыг харгалзан тогтоох (Өмнөд америкийн ихэнх улс орон) эсвэл Англи, Ирланд зэрэг оронд хууль эрхзүйн болон түүхэн уламжлалыг хослуулах зарчмыг баримтлан тодорхойлсон байдаг. (Перцик 1991)

Хот гэж аж үйлдвэр аж ахуйн зохион байгуулалтыг удирдах шинжлэх ухаан тээврийн болон бусад (хөдөө аж ахуйг оруулахгүй) үүргийг гүйцэтгэх хүн амын их төвлөрсөн суурийн газрыг хэлнэ гэж үздэг. (Перцик 1991)

Хотыг ангилахдаа дараах үзүүлэлтүүд харгалзан үздэг.

- ❖ Хүн амын тоог харгалзах
- ❖ Улсын аж ахуйд гүйцэтгэх үүргийг харгалзах
- ❖ Хотын гарал үүслийг харгалзах
- ❖ Эдийн засгийн газарзүйн байршилыг харгалзах

Хүн амын тоо, үйлдвэрлэл үйлчилгээний төрөл, чанар, төрөлжилт буюу улс орны нийгэм эдийн засагт гүйцэтгэх үүргээс болж хот суурингийн эрэмбэ үүсдэг. Манай улсад хот, хөдөөгийн суурин газрын гүйцэтгэж байгаа эдийн засгийн үүрэг хоорондоо төдийлөн ялгаатай биш байгаагаас хот суурингийн эрэмбэ үүсэж чадаагүй байна.

Харин Монгол улсад зах зээлийн харилцаанд шилжсэнээр нийгэм-эдийн засгийн хөгжил нь тэгш бус, цэгэн байдлаар хөгжих чиг хандлагатай болж, нийслэл Улаанбаатар болон цөөн тооны аймгийн төвүүдэд бусдаас илүү хөгжиж, хүн амыг татах (Зубаревич, 2003) болсон. Энэ хотжилт нь зөвхөн Монгол биш хөгжиж буй улс орнуудын нийгэм-эдийн засгийн хөгжлийг түргэтгэж буй хүчин зүйлүүдийн нэг болж, уламжлалыг орчин үетэй хослуулсан онцлогтой явагдаж байна (Хорев 1976, Негтап 1999).

Хүснэгт 13. Хот суурин газрын хүн амын өөрчлөлт


Хот суурин газрын хүн ам	Хот, томоохон тосгоны хүн ам		Зөрүү 2000/2012	Хувь
	2000	2012		
Сүхбаатар	20282	22798	2516	11,04%
Мандал(Зүүн хараа)	23211	23600	389	1,65%
Зуунмод	14837	15297	460	3,01%
Дархан	65791	71784	5993	8,35%
Шарын гол	8727	8121	-606	-7,46%
Сайнцагаан (Мандалговь)	10063	13643	3580	26,24%
Чойр	8983	11279	2296	20,36%
Замын үүд	6031	14995	8964	59,78%
Сайншанд	15585	21109	5524	26,17%
Даланзадгад	11739	18740	7001	37,36%

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

Эх сурвалж: Статистикийн эмхтгэл 2000 он, Үндэсний статистикийн хороо

Төв байршлын онолоор аливаа үйлдвэрлэл үйлчилгээ нэг цэгт төвлөрч эндээс үйлчилгээний хүрээ орон зайд тархах бөгөөд тэр үйлчилгээний хүрээ тодорхой орон зайгаар бусад төвийн үйлчилгээний хүрээгээр зааглагдах шинж бүхий төвийг тухайн системд төв байршил гэж тайлбарладаг.


Хоёр төвийн үйлчлэх хүрээний шүргэлцэж байгаа харилцан тэмцлийн хамгийн хурцгаж байгаа цэгийг хил хязгаар гэнэ. Энэ цэг нь дараагийн төв үүсэх потенциалыг хамгийн их хадгална. Эндээс дүгнэж үзвэл хүн ам шилжин нүүдэлснээр олон жижиг сумын төвүүд бий болж, нэг талаас улс төр, эдийн засгийн хувьд үүрэг нь суларч байгаа мэт байгаа боловч зарим сумын төвүүд шинэ үе шатанд орж гүйцэтгэх үүрэг нь дамжин өнгөрөх гэхээс илүү томоохон хот суурингуудыг холбох түшиц цэг болон хувирч байна.



Зураг 12. Эдийн засгийн төвүүдийн нөлөөллийн хүрээ

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нэг хот нь өөртөө хир зэрэг олон суурин газрууд татна, төдий чинээ гүйцэтгэх үүрэг, эдийн засгийн чадавхи нэмэгдэж, улс орны нийгэм эдийн засагт гүйцэтгэх үүрэг нь томордог.



Зураг 13. Хотуудын үүргийн ангилал

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хот суурин нь оршин суугаа хүн амын тоо, тэдгээрийн эрхэлж буй ажил, тэрчлэн хотын гүйцэтгэж буй үүрэг, түүний үйлчилгээнд хамрагдаж буй нутаг

дэвсгэрийн хэмжээ зэрэг олон үзүүлэлтээр ялгаатай. Хот суурингийн нийгэм-эдийн засгийн хөгжлийг шийдвэрлэх

гол хүчин нь хүн амын тоо олон цөөн байх явдал юм.

Хот суурингийн хүн амын тоо, хотын нийгэм эдийн засгийг тодорхойлон, түүнд шууд нөлөө үзүүлдэг. Монголын бүх суурин газрууд нь оршин суугчдын олон цөөн, эдийн засгийн үүргийн хувьд ихээхэн ялгаатай тул энэхүү ялгааг илрүүлэх үүднээс хот суурингийн ангилалыг тогтоох хэрэгтэй.

Томоохон хот орчмын бүс болж байгаа сумууд аймгийн бараг бүх сумдаас малчин өрхүүд зах зээлд ойртох нүүдлээр ирэхэд тэдгээрийг хүлээн авдаг бамбай сум болдог (НЭЗГ-н сектэр 2010 тайлан). Хэрэв эдгээр бамбай сумдыг татан буулгавал малчин өрхүүд нь хол, ойрын хотууд тийш хаяа залган буух нь судалгаагаар батлагдсан. Нүүдлийн мал аж ахуйгаас суурин аж ахуй хэлбэрлүү шилжих шилжилтийн үе шатны нэгэн хэлбэр (Оа¹³ 2004). Тодруулбал: их нүүдлийг зогсоох бамбай сум болдог ач холбогдолтойгоос гадна нүүдэлчдийг хот орчмын аж ахуй эрхлүүлэх замаар ядуурлаас аварч тогтворжих суурьшилд шилжүүлж байна (Базаргүр 2007). Энэ нь хот хөдөөгийн нийгэм эдийн засгийн системийн шилжилтийн бүс гэж тодорхойлсон байдаг (РакосП 1998, Ас!e11 1999). Энэ нь бүсэд эрчимжсэн аж ахуйн хөгжиж, эдийн засгийн, нийгмийн дэд бүтцийн томоохон өөрчлөлтүүд явагддаг бүс нутаг юм. Тус бүс нутагт амьдарч буй малчид нийгмийн, эдийн засгийн талаас том хот сууринд татагдаж амьдарна. Ингэснээр аймгийн төв, томоохон хотын орчимд байгаа сумын гүйцэтгэх үүрэг буурч, эдгээр суурин газраас хараат байх дагуул хот үүсч байна.

3.3 Нутагшилтанд нөлөөлөх хүчин зүйл

Нутагшилтанд нөлөөлж буй хүчин зүйлсийг хүн ам зүйн буюу нийгмийн, эдийн засгийн болон байгалийн гэж ангилна.

Хүн ам зүйн буюу нийгмийн хүчин зүйлд:

- ✓ Хүн амын төрөлт, нас баралт
- ✓ Хүн амын шилжих хөдөлгөөн
- ✓ Хүн амын ажил эрхлэлт
- ✓ Хүн амын боловсрол, эрүүл мэнд


Эдийн засгийн хүчин зүйлд:

- ✓ Үйлдвэрлэл үйлчилгээ
- ✓ Авто зам болон төмөр зам
- ✓ Цахилгаан хангамж
- ✓ Дэд бүтцийн нөхцөл
- ✓ Уул уурхай

Байгалийн хүчин зүйлд:

- ✓ Мал аж ажуй
- ✓ Газар тариалан

Мөн голлох нөлөө үзүүлж буй салбараар нь дараах 5 ангилж авч үзлээ.



Схем 5. Голлох нөлөө /Салбараар/

3.3.1 Аж үйлдвэр, уул уурхай

Төвийн бүсийн аж үйлдвэрийн хувьд бусад бүсээс харцангуй өндөр хөгжсөн бөгөөд нутгийн хойд харцангуй илүүтэй байна. Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний 20 орчим хувийг нийт бүтээгдэхүүн борлуулалтын 16.6 хувийг эзэлж

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуултын хэмжээ сүүлийн Южилийн хугацаанд 11 дахин нэмэгдсэн нь уг бүсийн эдийн засгийн хөгжил харьцангуй өндөр байгааг харуулж байна.

Хүснэгт 14. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт 2000 он

	Нийт хүн ам /2000 он/	Бүтээгдэхүүн борлуулалт /сая.төг/	Нэг хүн ноогдох аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт /сая.төг/
Сэлэнгэ	94794	15153,2	0,16
Төв	99268	47138,3	0,47
Дархан	83271	18788,3	0,23
Говь-Сүмбэр	12230	2903,1	0,24
Дундговь	51608	985,6	0,02
Дорноговь	49237	1640,6	0,03
Өмнөговь	72900	819,5	0,01
Нийт	463308	87428,6	0,19
Улсын хэмжээнд	2407500	574162,5	0,24

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 15. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт 2012 он


	Нийт хүн ам /2012 он/	Бүтээгдэхүүн борлуулалт /сая.төг/	Нэг хүн ноогдох аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт /сая.төг/
Сэлэнгэ	103698	347543,2	3,35
Төв	87410	33700,5	0,39
Дархан	88875	146213,8	1,65
Говь-Сүмбэр	15240	26928,2	1,77
Дундговь	44601	2644,2	0,06
Дорноговь	60936	18377,7	0,30
Өмнөговь	56930	44393,1	7,80
Нийт	457690	1019338,5	2,23
Улсын хэмжээнд	2859982	6058023,8	2,12

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Уг бүсийн нэг хүнд ноогдох аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ 2000 онд 0.19 сая, төг байсан бол 2012 он гэхэд 2.23 болж даруй 11.7 дахин нэмэгдсэн байна. Үйлдвэрлэл дагасан хот суурингийн хүн амын тоо 10 орчим хувиар нэмэгдсэн байгаа нь аж үйлдвэр уул уурхай нь хүн амыг татах гол хүчин зүйл гэдгийг харуулж байна.

Сүүлийн жилүүдэд илүүтэй хөгжиж байгаа томоохон уул уурхай болон аж үйлдвэр дагасан төвлөрөл нь Дархан болон Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сумуудад ажиглагдаж байна.

Төвийн бүсийн уул уурхайн томоохон ордуудын нөлөө



Зураг 14. Төвийн бүсийн уул уурхайн байршил, нөлөөлөл

3.3.2 Газар тариалан


Уг судалгааны бүсийн хойд хэсгээр Орхон сэлэнгийн сав нутаг болон хангай хээр бүсэд газар тариалан маш эрчимтэй хөгжсөн бөгөөд газар тариалангийн хөгжлөөр Монгол улсдаа тэргүүлдэг бүс юм. Нутгийн өмнөд хэсгээр говийн аймгууд болох Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр, Дорноговь аймгуудын хувьд газар тариалан харьцангуй бага хөгжсөн байдаг ба уур амьсгал шууд нөлөө үзүүлдэг.

Энэ бүсийн газар тариалан эрчимтэй хөгжсөн Төв, Сэлэнгэ, Дархан аймгуудад 2000 оноос хойш төмсний тариалалтын хэмжээ 3.2 дахин, Үртариан тариалалтын хэмжээ 1.6 дахин, Хүнсний ногоо тариалалтын хэмжээ 1.5 дахин нэмэгдсэн байна. Харин говийн аймгуудын хувьд Төмс 1.2, хүнсний ногоо -7%-иар өссөн бөгөөд Өмнөговь аймаг 17.2 тн үр тариа тариалж эхлээд байна.

Хүснэгт 16. Төвийн бүсийн газар тариалан

Аймгийн нэр	Төмс тн		Үр тариа тн		Хүнсний ногоо тн	
	2000	2012	2000	2012	2000	2012
Говьсүмбэр	8	4,5	-	-	6	4,8
Дархан-Уул	456,7	1189,5	13500	9050,9	595,3	961,6
Дорноговь	19,2	52,3	-	-	16,2	38,4
Дундговь	27,1	45,6	-	-	9,9	15,2
Өмнөговь	87,7	65,8	-	17,4	82,3	48,2
Сэлэнгэ	899,6	4064,4	92186	140147	570,8	2139,9
Төв	1785,4	5051,2	26314	62295	1479,5	992,5
Нийт	3283,7	10473,3	132000	211510	2760	4200,6

Эх сурвалж: Статистикийн эмхтгэл 2000 он, Үндэсний статистикийн хороо



Зураг 15. Төвийн бүсийн хурааж авсан үр тариа болон ногооны хэмжээ

Эх сурвалж: Доктор Д. Базаргүр, Д. Баасандорж

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

3.3.3 Мал аж ахуй

Монгол орны хувь нүүдлийн мал аж ахуй ноёлох салбар байсан бөгөөд одоо ч хамгийн гол салбарын нэг билээ. Судалгаанд хамрагдсан бүс нутгийн хувьд монгол улсын нийт малын 23% оршдог бөгөөд үүнээс тэмээний 48%, адууны 24%, үхэр сүрэгийн 19% , хонины 23%, ямааны 24% хувь нь оршиж байна. Дархан , Сэлэнгэ , Төв аймгийн хувьд хангай хээрийн бүсэд орших байгалийн нөхцөл сайтай бөгөөд энэ нь хүн амыг татах гол хүчин зүйлийн нэг болж өгдөг. Бүсийн малын 30%-ийг төв аймагт оршиж байна.

Хүснэгт 17. Төвийн бүсийн малын тоо, нэр төрөл

	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Дархан	434	11253	35609	135966	85107
Дорноговь	31446	95555	50298	531494	619137
Дундговь	22978	71979	27574	775796	773619
Говьсүмбэр	628	9586	5606	99406	110876
Сэлэнгэ	619	68087	159579	612137	465147
Төв	2425	243719	202613	1610079	1145253
Өмнөговь	97317	50100	10912	299816	961258
Нийт	155847	550279	492191	4064694	4160397
Улсын нийт	323463	2304675	2547273	17911775	17345714
Эзлэх хувь	48%	24%	19%	23%	24%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 18. Малчин өрх болон малын харьцаа

Аймаг	2005 он		2012он		2005 он	2012он
	Нийт малын тоо	Малчин өрх	Нийт малын тоо	Малчин өрх	1 малчинд ноогдох малын хэмжээ	1 малчинд ноогдох малын
Дархан	135406	1046	268369	941	129	285
Дорноговь	933529	3773	1327930	4418	247	301
Дундговь	1829059	7129	1671946	5744	257	291
Говьсүмбэр	155865	677	1305569	1033	230	1264
Сэлэнгэ	627492	3110	226102	4056	202	56
Төв	1787247	10268	3204100	13781	174	233
Өмнөговь	1121524	6276	1391217	5131	179	271
Нийт	6590122	32279	9395233	35104	204	268

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

3.3.4 Зам тээвэр

Төвийн бүс нь харцангуй зам тээвэр болон холбоо харилцаа сайн хөгжсөн бүс бөгөөд Төмөр замын урт 1374км, Хар замын урт 1495км, сайжруулсан зам 801 км байна.

Хар зам болон төмөр зам аль нэг дайрч өнгөрдөг 6 аймаг, 28 сум байгаа бөгөөд үлдсэн 67 сум нь шороон замаар аймгийн төвүүдтэйгээ холбогдсон байна.

Хүснэгт 19. Төвийн бүсийн зам дагуу хотууд

Төмөр зам дайрдаг	Харзам дайрдаг	Төмөрзам болон харзамтай	Бусад	Нийт
Алтанбулаг, Шаамар, Орхон, Шарын гол, Орхон туул, Баянгол, Мандал, Батсүмбэр,, Баян, Баянтал, Сүмбэр, Шивээговь, Даланжаргалан, Айраг, Өргөн, Эрдэнэ, Сайншанд, Замын үүд , Сүхбаатар, Орхон(сэлэнгэ), Дархан	Эрдэнэсант, Лүн, Эрдэнэ, Баяндэлгэр, Баянчандмань.Баянгол , Хонгор,Дархан, Орхон, Шаамар, Орхон(сэлэнгэ), Баруунбүрэн Алтанбулаг, Сайнцагаан, Зуун мод, Сүмбэр, Баянтал, Сүхбаатар,	Алтанбулаг, Шаамар, Дархан, Орхон, Хонгор, Орхон(сэлэнгэ) , Баянгол, Баянтал, Сүмбэр,	67сум	95сум


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Уг бүсийн хэмжээнд төмөр зам дайрсан сумдын хүн амын өсөлт 9.55%, хар зам дайрч өнгөрдөг сумдын хүн амын өсөлт 9.55%, Хар зам болон төмөр зам хоёулаа зэрэг дайрдаг сумдын хүн амын өсөлт 12.68%-н өсөлттэй байгаа бол бусад сумдын хүн амын тоо 11.40%-иар буурсан байна. Үүнээс үзэхэд хар зам болон төмөр зам нь хүн амыг ихээр татах хүчин зүйл болохыг харуулж байна.

Хүснэгт 20. Төвийн бүсийн зам дагуу хотуудын хүн амын өсөлт

Хүн амын тоо	Төмөр зам дайрдаг	Харзам дайрдаг	Төмөрзам болон хар замтай дайрдаг	Бусад	Нийт
2000	200993	178555	138019	262315	463308
2012	222220	197408	158060	235470	457690
Өсөлтийн хувь	9,55%	9,55%	12,68%	-11,40%	-1,23%

Эх сурвалж: Статистикийн эмхтгэл 2000 он, Үндэсний статистикийн хороо



Зураг 16. Төвийн бүсийн зам тээвэр

3.3.5 Боловсрол, эрүүд мэнд

Хүснэгт 21. Төвийн бүсийн ЕБС, Их сургуулийн тоо болон суралцагчдын тоо

Аймгийн нэр	Сургуулийн тоо	Их дээд сургууль	Мэргэжлийн сургалтын төв	10 жилийн сурагчид	Оюутан
Говьсүмбэр	5	-	0	2920	697
Сэлэнгэ	35	-	1	18501	1253
Дархан	28	4	3	18265	1229
Өмнөговь	19	-	0	10524	809
Дорноговь	20	1	2	10897	743
Дундговь	18	-	0	8143	862
Төв	31	-	1	13841	962
Нийт	156	5	7	83091	6555

Эх сурвалж; Үндэсний статистикийн хороо

Монгол улсын хэмжээнд нийт ЕБС-ийн 0.8% , улсын хэмжээнд 505409 сурагч байгаа бөгөөд уг судалгааны бүсэд 16.4 хувь, 7 Мэргэжлийн сургалтын төв ,5 их дээд сургууль үйл ажиллагаа явуулдаг бөгөөд нийт 6555 оюутан суралцах бөгөөд монгол улсы нийт оюутны 13.6 хувь нь оршиж байна. Бусад бүстэй харцуулахад их дээд сургууль, коллежийн тоо илүүтэй байна.




График 14. Сургуулийн тоо

3.4 Хүн амын нутагшилт суурьшлын өнөөгийн байдал, нөлөөлж буй хүчин зүйлсэд
хийсэн SWOT дүн шинжилгээ

Хүснэгт 22. SWOT дүн шинжилгээ

Давуу тал	<ul style="list-style-type: none">✓ Хүн амын хувьд харьцангуй нутаг дэвсгэрээр жигд тархан суурьшсан✓ Улсын эдийн засгийг дотоод, гадаад зах зээлтэй холбосон босоо, хэвтээ тэнхлэгийн төмөр болон автозам, эрчим хүчний нэгдсэн систем, холбоо мэдээллийн сүлжээтэй.✓ Эрүүл мэнд, боловсрол болон нийгмийн суурь үйлчилгээний дэд бүтэц бүрэлдсэн.✓ Газар тариалан нутгийн хойд хэсгийн аймгуудад маш эрчимтэй хөгжсөн✓ Байгаль орчны чадавхид нийцүүлэн зохистой ашиглах боломжтой ой, ус, ан агнуурын нөөцтэй✓ Хүн ам суурьшин амьдарч, нийгэм, соёлын олон төрлийн үйлчилгээг хүртэх боломж олгосон, харьцангуй тохижиж холбогдсон олон тооны хот, тосгоны сүлжээтэй✓ Алт (шороон ба үндсэн орд), төмрийн хүдэр, нүүрс, газрын ховор элемент, хайлуур жоншны балансын үндсэн нөөц, үйлдвэрлэлийн гол хүч чадал тус бүсэд байршиж байгаа✓ Уул уурхай үйлдвэрлэлийн хөгжлийг дагаад суурьшлын шинэ төвүүд бий болсон.(Цогт цэций, Ханбогд)✓ Нутгийн өмнөд хагаст нарны гэрэл, дулааны хуримтлал сайтай, байгалийн үзэсгэлэнт газар, ховор ан амьтан олонтой, нүүрс, зэс, хайлуур жонш, газрын ховор элементийн баялаг нөөцтэй, мөн газрын тос бага хэмжээ (Зүүнбаян)-гээр илрэн ашиглаж байгаа.
--------------	---

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

Сөрөг тал	<p>Хот байгуулалтын хувьд</p> <ul style="list-style-type: none"> ✓ Зарим аймгийн төвүүдийн (Дархан, Сүмбэр)хувьд хүн амын хэт төвлөрөл үүсч байгаа ✓ Орон нутаг хөдөө сумдын хувьд зах зээлийн зохистой төвлөрөл үүсээгүй улмаас ядуурал, ажилгүйдэл нэмэгдсэн. <p>Эдийн засгийн хувьд</p> <ul style="list-style-type: none"> ✓ Уул уурхай даган хүн амын шилжих хөдөлгөөн харьцангуй идэвхтэй ✓ Харьцангуй олон уул уурхайн лецэнз олгосон бөгөөд энэ нь эргээд малчиддаа сөргөөр нөлөөлдөг ✓ Улаанбаатар хот руу бусад аймгаас шилжиж ирэгсдийн олонхи нь (мал бүхий иргэд) Дархан хот, Төв аймгийн сумдад байрлаж экологийн даац, нийгмийн ачааллыг нэмэгдүүлж байгаа <p>Эклогийн хувьд</p> <ul style="list-style-type: none"> ✓ Нийт нутаг дэвгэрийн талаас их хувь нь цөлжилтын улмаас улирлын бэлчээр дутмаг ✓ Алт, барилгын материал олборлох явцад хөрс эвдрэх, гол, мөрний ус бохирдож байгаа зэргээр байгаль орчны байдал илт доройтож байгаа ✓ Усны хомсдол харьцангуй их ялангуяа нутгийн өмнөд хэсгээр ✓ Сүүлийн жилд Төв, Дундговь аймгийн нутгийг хамарсан байгалийн гамшигт үзэгдлийн (ган, зуд) давтамж ихсэж, мал сүргийн тоо олноор хорогдож байгаа
Аюул занал, эрсдэл	<ul style="list-style-type: none"> ✓ Цөлжилт нэмэгдснээр малчдад сөргөөр нөлөөлж эргээд хотын хүн амын өсөлтөнд нөлөө үзүүлдэг ✓ Хүн амын дотоод шилжих хөдөлгөөн эрчимтэй ✓ Ажиллах хүчний ихэнхи хувь нь мал аж ахуй эрхлэгчид бөгөөд уур амьсгалын өөрчлөлтөнд харьцангуй эмзэг байдаг ✓ Гадаад ажиллах хүч нэмэгдснээр дотоодын ажилчдын эрэлт хэрэгцээ буурсан.

Боломж

- ❖ Сумдын үүргийг нэмэгдүүлэх , татах хүчин зүйлсийг нэмэгдүүлэх жишээ нь ажлын байр нэмэгдүүлэх, малчдыг дэмжиж туслах, мэдээллийн техник технологийг нэвтрүүлэх
- ❖ Төрөөс хөдөө орон нутагийн хөгжүүлэх зорилгоор сумдыг дэмжих төсвийн хөрөнгө нэмэгдсэн. Мөн жижиг дунд үйлдвэрийг дэмжих гадаадын төсөл хөтөлбөрүүд хэрэгжих болсон.
- ❖ Эрчимжсэн мал аж ахуйг болон Фермерийг дэмжснээр малчдын цаг агаарын нөхцлөөс хараат байдал багасна.

IV БҮЛЭГ. БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

4.1 Бүс нутгийн хөгжлийн стратегид нөлөөлөх хүчин зүйлс

Түүхэн явцад бүрэлдэн тогтсон Монгол улсын нийгэм-эдийн засгийн хөгжлийн өвөрмөц онцлог

XX зууны Монгол улсын НЭЗ-ийн хөгжлийн түүх бол нийгэм-улстөрийн ухааны зарим үзэл санаа, онол сургаалийг хэрэгжүүлэх гэсэн туршилтын түүх юм. 1911-1921 оны Богд Хаант Монгол улс нь 1914-1915 оны “Гурван улсын гэрээ”-ээр Хаант Орос, БН Дундад Улс хоёрын аль аль нь Богд Хаант Монгол улсыг нөлөөнийхөө хүрээнд байлгахыг хүсэж, Английн улстөрч Ж.Н.Керзоны шинээр гаргасан зөөлөвч буфер бүсийн санааг Монгол улсын тусгаар байдлын асуудлыг шийдэхэд онол-практикийн хувьд ашигласан байна. 1914-1915 оны “Гурван улсын гэрээ”-гээр Богд хаант Монгол улсыг автономит эрхтэйгээр зөвхөн Халхын 4 аймаг аймаг, Ховдын хязгаарын хүрээнд хязгаарлагдмал нутаг дэвсгэрийг ёс төдий хүлээн зөвшөөрсөн байна.

1921-1991 ийг Үндэстний эдийн засгийн хөгжлийн түүх бол нийгэм-улстөрийн ухааны зарим үзэл санаа, онол сургаалийг хэрэгжүүлэх гэсэн туршилтын түүх юм. 1911-1921 оны Богд Хаант Монгол улс нь 1914-1915 оны “Гурван улсын гэрээ”-ээр Хаант Орос, БН Дундад Улс хоёрын аль аль нь Богд Хаант Монгол улсыг нөлөөнийхөө хүрээнд байлгахыг хүсэж, Английн улстөрч Ж.Н.Керзоны шинээр гаргасан зөөлөвч буфер бүсийн санааг Монгол улсын тусгаар байдлын асуудлыг шийдэхэд онол-практикийн хувьд ашигласан байна. 1914-1915 оны “Гурван улсын гэрээ”-гээр Богд хаант Монгол улсыг автономит эрхтэйгээр зөвхөн Халхын 4 аймаг аймаг, Ховдын хязгаарын хүрээнд хязгаарлагдмал нутаг дэвсгэрийг ёс төдий хүлээн зөвшөөрсөн байна.

Монгол улсын улс төр-эдийн засгийн газарзүйн байрлалын өвөрмөц онцлог

Дэлхийн далайд гарцгүй 47 улс орноос нутаг дэвсгэрийн хэмжээгээр хоёрдугаарт манай улс ордог юм. Дэлхийд хүн ам, нутаг дэвсгэр, эдийн засгийн ба санхүүгийн чадавхи, улстөрийн ба цэргийн чадавхиар тэргүүлэх томоохон хоёр оронтой хиллэдэг нь Монгол Улсын газарзүйн байрлалын онцлог байдлыг тодорхойлж

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

байдаг. 2010 онд ОУВС-аас гаргасан ДНБ-ний хэмжээгээр өмнөд хөрш БНХАУ нь дэлхийд 2-р байр, хойд хөрш ОХУ нь 11-р байрт ордог бөгөөд Монгол Улс энэ үзүүлэлтээр 136-р байр эзэлж байв.

Дэлхийн улсууд дотор Батлан Хамгаалах салбарт зарцуулж буй зардлын хэмжээгээр 2010 оны байдлаар БНХАУ 2-рт, ОХУ 5-рт жагсдаг. Цөмийн зэвсэгтэй, томоохон цэрэг армитай, НҮБ-ын байнгын 5 гишүүний хоёртой нь хиллэдэг нь Монгол улсын газарзүйн байрлалын стратегийн ач холбогдолыг улам нэмэгдүүлж байдаг.

Мөн соёлын хувьд монгол улс нь үнэн алдартаны шашинтай славын соёл иргэншил, күнз-будда хосолсон хятадын соёл иргэншил, лалын шашин-соёл гэсэн гурван соёл иргэншлийн заагт өөрийн гэсэн өвөрмөц будда-бөөгийн соёл иргэншилтэй улс болдог.

АНУ нь Азид ардчиллыг хөгжүүлж байгаа улсын хувьд монгол улсыг дэмжихдээ ОХУ, БНХАУ-ын хооронд “буфер” байдалтай байрласныг онцлон Монгол улсыг олон улсын тавцан дээр улстөрийн харилцааны хувьд дэмжиж байдаг.

Монгол улстай хойд талаар хил нийлдэг ОХУ-ын Алтай, Тува, Буриадын БНУ, Өвөр Байгалийн хязгаарт монгол угсаатан, монгол хэлтэн алтай, тува, буриад нар ОХУ-ын дээрх мужуудын хүн амын 68%, 77%, 28%, 6%-г тус тус эзэлдэг.

Монгол улстай өмнө талаар хил залгадаг БНХАУ-ын Шинжаан-Уйгур, Өвөр Монголын ӨЗО, Ганьсү мужид монгол угсаатнууд БНХАУ-ын дээрх мужуудын хүн амын 1%, 17%, 0,1%-г тус тус эзэлдэг.

Монгол улстай хиллэж байгаа ОХУ, БНХАУ-ын засаг захиргааны нэгжүүд нь гол төлөв монгол угсаатан хүн ам бүхий улс, мужууд (БН Алтай, Тува, Буриад улсууд, Өвөр Байгалийн хязгаар, Шинжаан-Уйгур ба Өвөр Монголын Өөртөө Засах Орон, Ганьсү муж) байгаа нь **улс төр, эдийн засаг, соёлын харилцаанд чухал ач холбогдолтой** байдаг. Алтайн БНУ-ын гадаад худалдааны 45%, Тувагийн 90%, Буриадын импортын 14%-ийг Монгол Улс эзэлдэг⁹.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны экспортод **Монгол улс 3-7 байрыг** 2000-2004 оны байдлаар эзэлж байв. ӨМӨЗО 7436 км төмөр замтай байсны 2 гол шугам нь олон улсын шугам байв.

Монгол улстай шууд хиллэж байгаа ОХУ, БНХАУ-ын нутаг дэвсгэр байгалийн янз бүрийн ашигт малтмал ихтэй, дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн нь манай улсын эдийн засгийн харилцаанд чухал ач холбогдолтой болсоор байна.

⁹Олон Улс Судлал” сэтгүүл. 2005. № 1. 36-р тал

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

Ази-Европын хуурай газрын шинэ гүүр болох 9814 км урт төмөр зам Хөх хотоос эхэлж 7 улсын нутаг дэвсгэр дээгүүр 30 өртөө дамжин өнгөрч ХБНГУ-ын Франкфурт хот хүрдэг. Энэ замаар 14 хоногт Азиас Европт хүрдэг.

ӨМӨЗО 24 сая хүн амтай бөгөөд БНХАУ-ын хойд хэсэгт ОХУ ба Монгол улстай 4221 км газраар хил залган баруун өмнөөс зүүн хойш 2400 орчим км үргэлжилсэн 1,183 сая ам км нутаг дэвсгэртэй нь БНХАУ-ын нутаг дэвсгэрийн наймны нэгтэй тэнцэнэ. 4 тэрбум тонн нефть, 640 тэрбум куб метр шатдаг хийн нөөцтэй.

Монгол улстай шууд хиллэхгүй боловч улсын хилээс шулуунаар 47 км-ийн цаана орших Казакстан улстай соёл, эдийн засаг, улс төрийн салбарт харилцах харилцаа улам нэмэгдэж байна.

Монгол Улс сүүлийн жилүүдэд түргэн хурдацтай хөгжиж байгаа бөгөөд зах зээлийн багтаамж ихтэй БНХАУ-тай хиллэж байгаа нь улс орны бүтээн байгуулалтанд (Оюу толгой, Таван толгой зэрэг) шууд эерэгээр нөлөөлж байна.

Манай улсын засгийн газраас баримтладаг “Олон тулгуурт нээлттэй гадаад бодлого”-ын үр дүнд дэлхийн бүх улс, түүний дотор “гуравдагч хөршүүд” болох Япон, БНСУ, АНУ, Канад, Европын холбооны улсуудтай улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт эрх тэгш гадаад харилцааг хөгжүүлж байна. Эдгээр орнууд нь Монгол Улсыг “төвийг сахисан” нутаг дэвсгэр дээрээ цөмийн зэвсэг байршуулахаас татгалзсан, ардчилал хүний эрх чөлөөг баталгаажуулж зах зээлийн эдийн засагт тууштай шилжин орсон хувьд тал бүрийн дэмжлэг туслалцааг үзүүлдэг юм.

Монгол улстай хиллэдэг ОХУ, БНХАУ-ын БНУ, ӨЗО зэрэг мужууд улсдаа болон бүс нутаг, дэлхийн эдийн засаг, цэрэг-стратегийн талаар багагүй чухал үүрэг гүйцэтгэдэг тул хөрш манай улсын улс, эдийн засгийн ач холбогдлыг улам нэмэгдүүлж байдаг. Нөгөө талаар манай улсын аюулгүй байдал, бие даасан байдалд сөргөөр нөлөөлөх нь бий.

Монгол улсын улс төр-эдийн засгийн газарзүйн байрлалын өвөрмөц онцлогийг илэрхийлж байдаг хамгийн чухал хүчин зүйл бол ОХУ ба БНХАУ хоёрын улстөрийн харилцаа болж байдаг.

Монгол улсын эдийн засгийн бүсүүдийн эдийн засгийн газарзүйн байрлалын онцлог

Эдийн засгийн Баруун бүс: Энэ бүс баруун хойд, хойд талаараа ОХУ-ын Баруун Сибирийн эдийн засгийн бүсэд багтах Алтайн БНУ, Зүүн Сибирийн эдийн засгийн бүсэд багтах Тувагийн БНУ-тай, зүүн өмнө талаараа БНХАУ-ын Өвөр Монголын ӨЗО-той, баруун ба баруун өмнө талаар Шинжаан-Уйгурын ӨЗО-ны Или-Казахын ӨЗ тойрогтой улсын хилээр хиллэдэг. Бүс зүүн талаараа Хангайн эдийн засгийн бүстэй хиллэнэ. Бургастай, Булган, Даянгийн хилийн боомтоор БНХАУ-тай, Цагааннуур,

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

Боршоо, Тэс, Арцсуурийн хилийн боомтоор ОХУ-тай хилийн худалдаа хийдэг. Хойд талаараа Баруун бүс ОХУ-ын Баруун Сибирийн эдийн засгийн бүстэй хиллэдэг. Энэ бүс нь ОХУ-ын нефть олборлолтын гол бүс нутаг бөгөөд ОХУ-ын нефть олборлолтын ¾-ийг Баруун Сибирь, үндсэндээ Тюмень муж хийдэг байна.

Баруун бүсийн өмнөд хөрш ШУӨЗО нь хөвөн тариалалт, хураалалтаар БНХАУ-даа томоохон тооцогддог мужийн нэг юм. 2006 онд БНХАУ 5,4 сая га –д хөвөн тариалж 6,73 сая т хөвөн үйлдвэрлэсний 1/3 буюу 2,18 сая т хөвөнг ШУӨЗО үйлдвэрлэжээ. 2009 онд

ШУӨЗО-ны хөвөнгийн үйлдвэрлэл 3,2 сая т-д хүрч БНХАУ-ын нийт хөвөн үйлдвэрлэлд (7,7 сая т) 42% эзлэх болсон юм.

Баруун бүсийн зөвхөн Говь-Алтай аймагтай хиллэх БНХАУ-ын Ганьсу муж нь ШУТТ-аж үйлдвэр-ХАА өндөр хөгжиж буй “Шинэ Торгон зам” дээр орших эдийн засгийн газарзүйн ашигтай байрлалтай муж юм. Энд 1993 онд Ланжоугийн ЭЗ-Технологийн Хөгжлийн бүс байгуулагдсан нь одоо 17 коллеж, 11 эрдэм шинжилгээний хүрээлэн, 21 том компани, 1735 үйлдвэр, байгууллага ажиллаж байна. Мужийн аж үйлдвэрийн гол салбар болох хуванцар, нэхмэл, ээрмэл, бордоо үйлдвэрлэл, нефть боловсруулах, нефть-хими, төмөрлөгийн үйлдвэрлэлийн чиглэлийн туршилт-эрдэм шинжилгээний байгууллагууд ажилладаг. 1998 онд байгуулагдсан Ланжоугийн Өндөр-Технологийн хөгжлийн бүс нь улсын хэмжээний 27 том өндөр технологийн бүсийн нэг юм. Энэ өндөр технологийн бүсэд биотехнологи, химийн үйлдвэр, барилгын чимэглэлийн материал болон мэдээллийн технологид голлон төвлөрч байна.

Эдийн засгийн Хангайн бүс: Хойд талаараа ОХУ-ын Баруун Сибирийн эдийн засгийн бүсэд багтах Алтайн БНУ, Зүүн Сибирийн эдийн засгийн бүсэд багтах Тува, Буриадын БНУ-тай, өмнүүрээ БНХАУ-ын Өвөр Монголын ӨЗО-ны Алаша аймагтай улсын хилээр хиллэнэ. Тус бүс баруун талаараа эдийн засгийн Баруун бүстэй, зүүн талаараа эдийн засгийн Төв бүстэй шууд хиллэнэ. Хойд талаараа уг бүс Шишгэдийн гол, Баянхзүрх, Ханх, Хээгт, Бага-Илэнхийн хилийн боомтоор ОХУ-ын Тува, Буриадын БНУ-тай шууд харилцан хилийн худалдаа хийдэг. Өмнө талдаа БНХАУ-ын Ганьсү мужтай хиллэдэг нутаг нь Алтайн Өвөр говийн “Говийн Их Дархан Газар”-ын “А” хэсэг орших тул хилийн боомт байдаггүй онцлогтой.

Эдийн засгийн Төв бүс: Хойд талаараа ОХУ-ын Баруун Сибирийн эдийн засгийн бүсэд багтах Алтайн БНУ, Зүүн Сибирийн эдийн засгийн бүсэд багтах Тува, Буриадын БНУ-тай, өмнө талаар БНХАУ-ын Өвөр Монголын ӨЗО-ны Шилийн гол ба Алаша аймаг, Баяннуур, Бугат, Улаанцав хотуудтай улсын хилээр хиллэнэ. Баруун талаараа эдийн засгийн Баруун бүстэй, зүүн талаараа эдийн засгийн Зүүн бүстэй тус тус хиллэнэ. Төв бүсийн бусад бүсээс ялгарах гол давуу тал нь бүсийн умраас өмнийг нэвтэлсэн “УБ төмөр зам” нь ОХУ, БНХАУ-ын холбож байдаг олон улсын тээврийн “хонгил” болж байдаг онцлогтой.

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

БНХАУ-ын ДНБ-ний жил бүрийн 10 орчим хувийн өсөлт нь дэлхийн хамгийн том нүүрс импортлогч орны нэг болсон учраас Монгол улсын Тавантолгой, Нарийнсухайтын нүүрсний ордоос өнгөрсөн 2010 онд 17-18 сая т нүүрс импортлон худалдаж авсан байна.

Монгол улсын Төв бүсийн өмнө талаар БНХАУ-д дэлхийн газрын ховор элементийн хамгийн том орд оршдог нь ӨМӨЗО-ны Баян-Овоо юм. Газрын ховор элементийн нөөц 37 сая тн (дэлхийн бүх нөөц 45 сая т юм) болдог. БНХАУ-ын энэ нөөцийн үндсэн хэсэг нь Өвөр Монголд Баян-Овоогийн ордод байх ба энэ нөөц нь дэлхийн бусад бүх орны нөөцөөс 4,5 гаруй дахин их юм. Мөн Баян-Овоогийн төмрийн хүдрийн нөөц 1 тэрбум т бөгөөд ниобийн нөөцөөр Бразилын дараа 2-рт орно. Мөн ӨМӨЗО төмрийн хүдэр(нөөц ба олборлолтоор БНХАУ-д 2-р байр эзэлдэг муж), хром, зэс, алт, тугалга, давсны ихээхэн нөөцтэй муж юм.

ӨМӨЗО-ны Бугатын Газрын ховор төмөрлөгийн Өндөр технологийн бүс нь улсын ач холбогдолтой үйлдвэрлэл Технологийн Хөгжлийн Бүс бөгөөд Бугат хотын өмнө 15 ам км талбай эзлэн оршино. Энд дэлхийн өнцөг бүрээс ирсэн 1000 илүү компани үйл ажиллагаа явуулж байна. Бугат хот нь 2001 онд газрын ховор төмөрлөгийн үйлдвэрлэлийн 51,2%-г үйлдвэрлэн гаргаж байсан нь БНХАУ-ын стратегийн чухал хот болдог байна.

Хятадын газрын тос олборлолтын үндсэн 6 том сав газрын хоёр нь Шинжаан-Уйгурын ӨЗО-ний Тарим, Зүүнгар-Турфаны орд юм.

Эдийн засгийн Зүүн бүс: Хойд талаараа ОХУ-ын Зүүн Сибирийн эдийн засгийн бүсэд багтах Өвөр Байгалийн хязгаартай, зүүн ба зүүн өмнүүрээ БНХАУ-ын Өвөр Монголын ӨЗО-ны Хайлаар хот, Хянган ба Шилийн гол аймагтай улсын хилээр хиллэдэг. 1939 онд байгуулагдсан Дорнодын төмөр зам энэ бүсийн тээвэр-эдийн засгийн гол тэнхлэг болдог.

ОХУ-тай Ямбалахын гол, Эрэнцавын боомтоор, БНХАУ-тай Хавирга, Баянхошууны боомтоор хөрш улс орнуудтайгаа шууд харилцаж Зүүн Хойд Азийн бүсийн хүрээнд Монгол улсыг оролцуулах боломжийг энэ бүсийг газарзүйн ашигтай байрлал олгодог юм.

Дэлхийн ноолуур бэлтгэлтийн 30% нь Монгол улсад, 60 % нь БНХАУ-д оногдоно. 1993 оны байдлаар БНХАУ-ын Төв Азийн мужууд (Өвөр Монголын ӨЗО-23%, Шинжаан-Уйгурын ӨЗО-21,1%, Хөхнуур – 7,1%, Төвдийн ӨЗО – 3,5%, Баруун Сычуань 1,3%, Ганьсү - 6,4%) ноос үйлдвэрлэлд 62,2% эзэлж байв [1995 САВ J.W.Longworth C.G.Brown “Agribusiness Reform in China”].

ӨМӨЗО-ны газрын ховор төмөрлөгийн нөөц БНХАУ-ын нөөцийн 90% болдог. ӨМӨЗО-ны Бугат хот нь БНХАУ-ын хамгийн том ган төмөрлөгийн үйлдвэрлэлийн төвийн нэг ба машиг, тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг машины үйлдвэрийн хот болно.

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

Монгол улсын зам тээврийн сүлжээ олон улстай холбогдох байдал

Одоогийн байдлаар манай улс нь 21 аймаг, 336 сум 1568 гаруй багтай байна. Үүнээс гадаад оронтой (ОХУ, БНХАУ) хиллэдэг 14 аймаг, 57 сум тус тус байна.

Нийт 21 хилийн боомттой. Үүнээс 7 боомт нь жилийн турш, 14 боомт улирлын чанартайгар үйл ажиллагаа явуулна.

Монгол улс 2 хөрштэйгөө хилийн асуудлаа бүрэн шийдвэрлэсэн бөгөөд 1996 онд Монгол, Орос, Хятадын баруун, зүүн хилийн уулзварыг тогтоох тухай протоколд 3 тал Бээжин хотод гарын үсэг зурсан. Өнөөдрийн байдлаар Монгол улс Орос улстай тээвэр, уул уурхай болон бусад салбарт хоёр орны хамтарсан 160 гаруй аж ахуйн нэгж бүртгэгдэн ажиллаж байна. Харин Хятад улсаас манайд 60 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулахаар 423 орчин аж ахуй нэгж бүртгэгдээд байна. Хятад улс нь манай улсын гадаад худалдааны эргэлтийн 30 гаруй хувь, экспортын 57 хувь, импортын 13 хувийг тус тус эзэлж байна. Монгол болон Хятад улсын харилцаа, хамтын ажиллагааны асуудлыг зохицуулсан 50 гаруй гэрээ хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчилж байна.



Зураг 17. Монголын төмөр замын нэгдсэн сүлжээний олон улсын сүлжээний холбоо

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги




Зураг 18. Ази европын дэд бүтцийн сүлжээ



Зураг 19. Шинээр баригдах төмөр зам

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**



Зураг 20. Бүсүүдийн дэд бүтцийн босоо тэнхлэгүүд нь хөрш

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги


“Замын Үүд” эдийн засгийн чөлөөлт бүс, “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна. “Замын Үүд” эдийн засгийн чөлөөлт бүсийг 2004-2006, 2006-2010, 2010-2015 он гэсэн 3 үе шаттайгаар хөгжүүлэх мастер төлөвлөгөө болон Ерөнхий төлөвлөгөө боловсруулан, тэнд нийт 10 орчим тэрбум ам.долларын хөрөнгө оруулах юм. “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, мастер төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн, цаашид хийх ажлын чиглэлийг гаргаад байна.



Зураг 21. Монгол улсын нийгэм-эдийн засгийн тэнхлэгийн суурь болох замуудын байршилт¹⁰

¹⁰ Д.Хишигдорж “Тэнхлэг дагуух бүс нутгийн хүн амын байршил нутагшилтын зарим асуудал”, 2012


Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги



Зураг 22. Хот хоорондын төмөр замын тээвэр



Батлагдсан нөөцөөрөө Таван толгой нь дэлхийн хамгийн том нүүрсний орд болно¹



Боломжит нөөцөөрөө Оюу толгой нь дэлхийн хамгийн том зэсийн болон алтны орд болно



Зураг 23. Ашигт малтмалын томоохон нөөцүүд ба замын сүлжээ

Бүс нутгийн бодлого

Татварын бодлого: Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57-р тогтоолоор Монгол Улсын Бүсчилсэн Хөгжлийн Үзэл Баримтлалыг баталж бүсчлэлээр дамжуулан нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах төрийн зохион байгуулалт, эдийн засаг, нийгэм соёл, хүн амын нутагшилт, хот байгуулалт, гадаад хамтын ажиллагааны таатай орчныг бүрдүүлэх тэдгээрийн уялдааг хангах замаар аймаг, орон нутгийн хөгжлийг дэмжих төрийн бодлого зохицуулалтын тогтолцоог бий болгох чиглэл, үйл ажиллагааны зарчмын үндсийг тодорхойлсон. Үүний тулд бүсчилсэн хөгжлийг төрийн зохион байгуулалтын хүрээнд дэмжих эрхзүйн зохицуулалтыг бүрдүүлж өгөх зайлшгүй шаардлага бий болсон. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд бүсийн хөгжлийг төсөв, татвар, хөрөнгө оруулалт, мөнгө зээлийн бодлогоор дэмжих мөн бүс нутгийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог дэмжин урамшуулах гэж тусгажээ.

Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын 5.1.1 улсын төсвийн бодлогод зааснаар стратегийн зорилт 3-д бүс нутгийн хөгжлийг татварын бодлогоор оновчтой дэмжинэ гэж заасан нь бүс нутгийг төрөөс санхүү мөнгөний хувьд зохицуулалттайгаар шат дараатай дэмжиж хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлж байна. Энэ зарчмын хүрээнд:

- ✓ Төвөөс алслагдсан, сул хөгжилтэй бүс нутгуудад жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих
- ✓ Бүсийн тулгуур төвүүдийн хөгжлийг дэмжих
- ✓ Үйлдвэрлэл, технологийн паркуудыг дэмжин хөгжүүлэх

Үүнтэй уялдуулж алслагдсан болон говийн бүсийн иргэдэд татварын хөнгөлөлт үзүүлэх нь зүйтэй гэсэн хуулийн төслийг өргөн бариад байна. Түүнчлэн алслагдсан болон говийн бүс нутгийн иргэдийн амьжиргааг дэмжихийн тулд Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Дорнод, Говь-Алтай, Сүхбаатар, Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр дээрх боомтуудаар импортоор оруулж байгаа нэгдүгээр зэргийн гурил, шар болон цагаан будаа, элсэн чихэр, шахмал ногоон цайг гаалийн болон нэмэгдсэг өртгийн албан татвараас 5 жилийн хугацаагаар чөлөөлөх, 90 хүртэлх октантай автобензин, дизель түлшийн тухайд онцгой албан татваргүй байх зохицуулалтуудыг бий болгохоор тусгасан байна.

Алслагдсан бүс нутагт Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд, Хөвсөгл, Баянхонгор, Сүхбаатар, Дорнод аймгийн алслагдсан 92 сумдыг, говийн бүс нутагт Говь-Алтай, Баянхонгор, Сүхбаатар, Өвөрхангай, Увс, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Өмнөговь аймгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлтийн хувьд доогуур байгаль цаг уурын хувьд онцлог, дэд бүтэц, үйлдвэрлэл сул хөгжсөн 87 сумдыг тус тус багтаасан байна.

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги




График 15. Бүсүүдийн татвар төлөлтийн хэмжээ

Бүс нутгийн татвараас орж буй орлогын хувьд 2006 он хүртэл хангайн бүс тэр дундаа Эрдэнэт үйлдвэрээс оруулж байгаа татварын орлого давамгайлж байсан бол 2007 оноос хойш тус үйлдвэрээс төлж буй татварын орлого эрс нэмэгдсэн байна. Мөн сүүлийн үед уул уурхайн хөгжилтэй холбоотойгоор төвийн бүсийн улсад төлөх татварын хэмжээ хамгийн өндөр болсон байна.

Бүс нутгийн эдийн засгийн өсөлт сүүлийн үед тодорхой хэмжээгээр нэмэгдэж байгаа ч өргөн хүрээг хамарч чадаагүй, ажилгүйдлийн түвшин ялангуяа хөдөө орон нутагт өндөр хэвээр байна. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд:

- Татварын бүсчилсэн системтэй болох
- Шинээр ажлын байр бий болгож байгаа тохиолдолд татвараас тодорхой хувиар чөлөөлж байх зэрэг хөнгөлөлтүүдийг үзүүлж байх шаардлагатай байна.

Төсвийн бодлого

Монгол улсын төсвийн бодлого нь эдийн засгийн өсөлт болон төсөв санхүүгийн тогтвортой, тэнцвэрт байдлыг бататгаж санхүүгийн эх үүсвэрийг хөгжлийн тэргүүлэх чиглэлд оновчтой хуваарилах замаар хүн амын бодит орлого, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, бодит салбарын хөгжлийг бүрэн дэмжихэд чиглэгдэж байна. Татварын ерөнхий хууль нь (ТЕХ) улсын болон орон нутгийн татвар, татварын үндэс болон ангилал, орон нутгийн татварын дээд хязгаар болон төсвийн орлогыг бүрдүүлэх ерөнхий журмыг тодорхойлдог. Улсын төсвийн орлогыг УИХ болон засгийн газар тогтоож үндэсний хэмжээнд цуглуулдаг бөгөөд улсын төсвийн орлого нь аж ахуй нэгжийн орлогын албан татвар, гаалийн татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, архи

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

тамхи, түлш, шатахууны онцгой албан татвар, хүн амын орлогын албан татвар, тэмдэгтийн хураамж болон ашигт малтмал, агнуурын нөөц ашигласны төлбөр зэргээс бүрддэг.

Орон нутгийн төсвийн харилцааг зохицуулсан эрхзүйн актууд бол:

- 1944 онд анх “Төсвийн эрхийн тухай” хуультай болсон
- 1963 онд “БНМАУ-ын Төсвийн эрхийн тухай” хууль болж өөрчлөлт орсон
- 1992 онд “Монгол Улсын Төсвийн тухай” хууль
- 2002 онд “Нэгдсэн төсвийн тухай” хууль, “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай” хуулиудаар зохицуулагддаг болсон байна.

Орон нутгийн төсвийн орлого нь орон нутгийн татвар, улсын төсвийн санхүүжилт, орон нутгийн өмчийн орлого, татварын бус орлогоос бүрддэг.

Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлогод

- Хотын оршин суугчийн албан татвар
- төлөвлөлтийн албан татвар
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох албан татвар
- Газрын төлбөр орно.

Сум дүүргийн төсвийн татварын орлогод

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар
- Бууны албан татвар
- Улсын тэмдэгтийн хураамж
- Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж
- Байгалийн баялаг ашиглахад олгох зөвшөөрлийн хураамж
- Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр
- Ус, рашаан ашигласны төлбөр
- Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар зэрэг орно.

Орон нутгийн захиргаа өөрийн нутаг дэвсгэрээс гарсан татварын орлогоос гол хэсгийг бүрдүүлдэг. Нэгдсэн төсвийн тухай хуулийн дагуу хүн амын орлогын албан татвар, газрын түрээсийн төлбөр, ашигт малтмал хайх лицензийн төлбөрийн орлогууд аймаг, сумдад орох ёстой. НӨАТ-аас аймагт хуваарилагддаг боловч хувийг төвөөс жил

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

бүр өөрчлөн тогтоодог. Сумууд НӨАТ-аас шууд хувь хүртдэггүй. Иймэрхүү байдлаар бүс нутгийн санхүүгийн эх үүсвэр хязгаарлагдмал байгаа нь орон нутгийн засаг захиргааны чадавхи, ажлын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх тал ажиглагдаж байна.




График 16. Бүс нутгийн төсвийн гүйцэтгэл /сая. төг/

Бүс нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын гүйцэтгэлээр хангайн бүсэд Орхон-Уул аймаг 26226,2 сая төгрөг, төвийн бүсэд Өмнөговь аймаг 10552,0 сая төгрөг, Сэлэнгэ 4260,9 сая төгрөг, Дорноговь аймаг 3779,9 сая төгрөг, Дархан-Уул аймаг 2736,1 сая төгрөг төвлөрүүлж тэргүүлсэн байна.




График 17. Бүс нутгийн төсвийн зарлага /сая. төг/

Үнийн бодлого

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

Манай улсын эдийн засаг өмнөд, хойд хөршөөсөө ихээхэн хараат байдалтай байдаг билээ. 2010 оны байдлаар ДНБ-ний 16%-ийг ХАА, 18%-ийг уул уурхайн салбар эзэлж байгаа бөгөөд уул уурхай, олборлох салбар сүүлийн үеийн зэсийн үнийн өсөлт, алтны үйлдвэрлэл ихэссэнтэй холбоотойгоор улс орны эдийн засагт голлох үүрэг гүйцэтгэх болов. 2010 оны байдлаар ДНБ 8420.7 тэрбум төгрөг буюу 28.2 хувиар өссөн байна. Энэхүү уул уурхайн хөгжилтэй холбоотойгоор уул уурхайн дагалдах жижиг үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх боломж өргөн нээгдсэн ч олон улсын өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт, дэлхийн газрын тосны үнийн өсөлттэй уялдаад хөрөнгө оруулалт, үнийн таатай орчин, боломж дутагдалтай нь ажиглагдаж байна.

Хэрэглээний үнийн индекс нь тухайн өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм. 2010 оны 12 сарын байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 13.0 хувь өссөний дотор хүнсний барааны үнэ 18.6%, хувцас бөс бараа, гутлын үнэ 10.5%, орон сууц, цахилгаан түлшнийх 12.7%, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээнийх 14.6%, боловсролын үйлчилгээнийх 18.8%. зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээнийх 12.8% өссөн нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд бусад бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ дунджаар 1.3-1.6 хувиар өссөн байна.

Өрхийн нийт хэрэглээнд өндөр хувийн жин эзэлдэг мах, махан бүтээгдэхүүний үнэ 2010 оны эцэст бүх аймагт 8.6-88.9% өссөний дотор хангайн бүс дотроо Баянхонгор, Өвөрхангай аймгуудад 83%, баруун бүсийн Говь-Алтай, Баян-Өлгий аймгуудад 75% орчим, мөн төвийн бүсийн Дундговь, Дархан-Уул аймгуудад 54%-иар өссөн нь хамгийн их үзүүлэлт байна.

Түүнчлэн гурил, гурилан бүтээгдэхүүнийх 20 аймагт 3.3-35.3%, сүү сүүн бүтээгдэхүүн 14 аймагт 3.4-32.6%, төмс хүнсний ногоо 20 аймагт 2.6-71.7% өссөн бөгөөд газар тариалангийн гол бүс нутаг болох Орхон, Сэлэнгээр ногооны үнэ 60-72% болтлоо өссөн байна (график 4-с харна уу).

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги




График 18. Хэрэглээний үнийн индекс /2010/

Дээрх өсөлтөд хүнсний бараа, ундаа 8.9%, үүний дотор сүү сүүн бүтээгдэхүүн 27.2%, төмс хүнсний ногоо 13.1%, бөс бараа 1.6%, орон сууц, ус, цахилгаан, түлш 3.7%-р нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Харин Улаанбаатар хотын хэрэглээний үнийн жилийн индекст нөлөөлсөн бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтөд хүнсний бараа, ундаа ус 20.6%, согтууруулах ундаа, тамхи 8.3%, хувцас бөс бараа, гутал 12.1%, орон сууц, ус, цахилгаан, түлш 12.5%, гэр ахуйн тавилга, бараа 4.5%, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 3.6%, тээвэр 1.8%, холбоо, шуудангийн үйлчилгээ 16.9%, амралт чөлөөт цагийн үйлчилгээ 1.5%, боловсролын үйлчилгээ 20.4%, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 14.9%, бусад бараа үйлчилгээ 3.1%-р тус тус нэмэгдсэн байна.

Мал аж ахуйн гаралтай зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн хувьд ямааны цагаан ноолуурын хувьд Төв, Завхан, Өвөрхангай, Улаанбаатар хотод хамгийн их буюу 49.0-50.0 мян.төгрөг, Сүхбаатар, Дархан-Уул аймагт хамгийн бага буюу 40.0 мян.төгрөг байна. 2м-с дээш урттай үхрийн шир Завхан, Баянхонгор аймгуудад хамгийн бага буюу 12.0 мян.төгрөг, Архангай аймагт хамгийн өндөр буюу 25.0 мян.төгрөг байна.

Хөрөнгө оруулалтын бодлого

Монгол улсын хөрөнгө оруулалтын эх үүсвэр нь гадаад, дотоод гэсэн 2 эх үүсвэрээс бүрдэж байгаа бөгөөд дотоод эх үүсвэр нь улсын төсөв, банкны зээл, хувийн хөрөнгө оруулалтаас, гадаад эх үүсвэр нь гадаадын шууд хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрүүдээс бүрдэж байна. Үндэсний хэмжээнд хөрөнгө оруулалтыг дэмжих

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

талаар төр засгаас авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээний үр дүнд сүүлийн жилүүдэд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ тогтвортой нэмэгдэж ирсэн.




График 19. Орон нутгийн хөрөнгө оруулалт

Хүн ам ихтэй аймагт ахиу хөрөнгө хуваарилах, Улаанбаатар хотоос алслалт ихтэй, хүн амын нягтрал ихтэй эсвэл газар нутаг ихтэй аймгуудад ахиу хөрөнгө хуваарилах, тухайн жилийн орлогын төлөвлөгөөнөөс хамааран орон нутгийн татварын идэвхи санаачлага зэргийг харгалзан хөрөнгө хуваарилдаг зарчим баримталдаг байна.

Бүтэц

Монгол улсад бүс нутгуудын хэмжээнд хөгжлийн тэргүүлэх болон стратегийн зорилтуудыг дэвшүүлэн тавьж, хэрэгжүүлж байх шаардлага урган гарч байдаг. Улсын Их Хурал 2001 онд “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг, 2003 онд “Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги”, “Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль”-ийг тус тус батлан гаргаж хэрэгжүүлсэн.

Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах бүсчилсэн хөгжлийн асуудлаар Засгийн газрын ерөнхий стратегийг тодорхойлохын тулд орон тооны бус Үндэсний хороог дараах бүрэлдэхүүнтэй ажиллуулахаар тогтсон байна. Үүнд:

1. Үндэсний хорооны дарга, орлогч дарга
2. Засгийн газрын гишүүн, засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга
3. Байгаль орчин, зам тээвэр, аялал жуулчлал, хот байгуулалт, түлш эрчим хүч, хүнс хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүд, эдгээрээс бусад яамдын төрийн нарийн бичгийн дарга нар байна.

4. Бүсийн зөвлөлийн дарга нар багтана.

Мөн бүс нутгийн хөгжлийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бүсийн нийгэм эдийн засгийн асуудлыг зохицуулах чиг үүрэг бүхий бүсийн зөвлөл байхыг хуульчлан эрх үүргийг нь тодорхойлж дараах бүрэлдэхүүнтэй байхаар тогтжээ.

1. Зөвлөлийн дарга
2. Тухайн бүсэд багтаж буй аймгийн засаг дарга
3. Бүсийн хөгжлийн тулгуур төв хотын захирагч
4. Нийслэлийн хувьд нийслэл, дүүргийн засаг дарга, дагуул хотын захирагч.

Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд засгийн газрын дэргэд дараахь бүтцүүдийг бүрдүүлэн ажиллуулж байна.

1. Бүсчилсэн хөгжлийн үндэсний хороо
2. Бүсчилсэн хөгжлийн үндэсний хорооны алба
3. Бүсүүдийн зөвлөлүүд.

2005 онд байгуулагдсан бүсчилсэн хөгжлийн хороонд бүх яамны төлөөллийг оролцуулж, даргаар нь монгол улсын ерөнхий сайд, орлогч даргаар нь шадар сайд ажиллаж, ерөнхий сайдын захирамжаар 3 хүнийг томилон ажиллуулжээ. Бүсүүдийн зөвлөлийн ажиллах горим нь аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргатай адилсах эрх хэмжээ, цалинтай нарийн бичгийн даргыг 5 бүсийн зөвлөлд томилсон байна.

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хороо бүсчилсэн хөгжлийн талаар баримтлах засгийн газрын ерөнхий стратегийг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны бүх шатны байгууллага, аймаг, нийслэл, бүсийн зөвлөлүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж бүс нутгийг хөгжүүлэх тал дээр дотоод, гадаадын хөрөнгө оруулагч байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг дэмжин зохион байгуулах зорилготой. Монгол улсын их хурал 2003 онд бүсийн тулгуур төв хотыг:

- Баруун бүсийн тулгуур хотууд- Ховд, Улиастай хотууд
- Хангайн бүсийн тулгуур хотууд- Хархорин, Эрдэнэт хотууд
- Төвийн бүсийн тулгуур хотууд-Зуунмод, Дархан хотууд
- Зүүн бүсийн тулгуур хотууд-Чойбалсан, Өндөрхаан хотууд
- Улаанбаатарын бүс-Улаанбаатар хот байхаар тогтоосон байна.

Бүс нутгийн бодлогын хууль эрх зүйн орчин

Өргөн уудам нутагтай, хүн ам цөөнтэйн зэрэгцээ хүн амын тодорхой хэсэг нь бэлчээрийн мал аж ахуй эрхлэн нэлээд таруу байршин нутагладаг онцлогтой манай улсад бүс нутгуудын хэмжээнд хөгжлийн тэргүүлэх болон стратегийн зорилтуудыг дэвшүүлэн тавьж, хэрэгжүүлж байх шаардлага их байдаг. Ийм ч учраас Монгол улсын

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

хөгжлийн хөтөлбөрийн 1996.5.3-ны үзэл баримтлалын 5-р зүйлд нутаг дэвсгэрийг бүсчилэн хөгжүүлэх дэд бүтцийн нэгдсэн сүлжээ, үүний дотор улсын хөндлөн болон босоо тэнхлэгийн авто замын сүлжээг эхэлж байгуулах зарим бүс нутагт эдийн засгийн худалдаа, чөлөөт бүс бий болгон хөгжүүлэх, бүс нутгийн дотоод гадаад зах зээлтэй дэд бүтцийн сүлжээгээр холбох нутаг дэвсгэрийн таталцлын төв тэнхлэгүүдийг бий болгох зорилго бүхий бүс нутгийн бодлого гаргаж байжээ. МУИХ-ын 1995.12.4-ий өдрийн 87-р тогтоолоор МУ-д эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлалыг батлан гаргажээ. 2001 онд бүс нутгийн бодлогын үндсэн баримт бичиг нь болох Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг баталсан байна. Монгол Улсын Үндсэн хуулийн “Төр нь үндэсний аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэсэн заалтыг үндэслэл болгон боловсруулсан “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх арга замыг боловсруулж, бүсчлэлээр дамжуулан нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах төрийн байгуулалт, эдийн засаг, нийгэм соёл, хүн амын нутагшилт, хот байгуулалт, гадаад хамтын ажиллагааны таатай орчныг бүрдүүлэх, эдийн засгийн бүсүүдийн хүрээнд бүс нутаг-хот байгуулалтын уялдааг хангах замаар аймаг, орон нутгийн хөгжлийг дэмжих төрийн бодлого, зохицуулалтын тогтолцоог бий болгох чиглэл, үйл ажиллагааны зарчмын үндсийг тодорхойлсон байна. Мөн Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэнцлийг хангах үүднээс эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалттай холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилготой бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийг 2003 оны 05-р сарын 30-ны өдөр УИХ-аас батлан гаргасан байна. Тус хуулинд Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, бүсчилсэн хөгжлийн асуудлаар Засгийн газрын ерөнхий стратегийг тодорхойлохын тулд орон тооны бус Үндэсний хороог ажиллуулахаар тогтоосон байна. Бүс нутгийн хөгжлийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бүсийн нийгэм, эдийн засгийн асуудлыг зохицуулах чиг үүрэг бүхий Бүсийн зөвлөл байхыг хуульчлан эрх үүргийг нь тодорхойлж өгсөн.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль болон шинэ тогтолцоонд шилжиж эхэлсэн үеэс өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн хөгжлийн бодлогын бусад баримт бичгүүдийн гол санаа, хэрэгжилтийн явц, үр дүн, залгамж чанар нь Монгол Улсын бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгалаа олсон юм.

Баруун, Хангайн, Төвийн, Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөрүүдийг эрдэмтэд судлаачидтай хамтран боловсруулж Засгийн Газрын 2005 оны 202 дугаар тогтоолоор, Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөрийг 2006 онд 197 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна. Бүсүүдийн тулгуур төв Хархорин, Улаанбаатар

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

хотуудаас бусад хотуудыг 2020 он хүртэл хөгжүүлэх хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг БХБЯ-тай хамтран Засгийн газрын 2005 оны 201 дүгээр тогтоолоор батлуулан мөрдүүлсэн байна. Бүсийн зөвлөлүүд, салбарын яамдуудтай хамтран ажиллах эрх зүйн орчныг бий болгож Засгийн газрын 2005 оны 38 дугаар тогтоолоор “Бүсийн хэлэлцээр байгуулах нийтлэг журам”, 2005 оны 39 дүгээр тогтоолоор “Бүсийн хөгжлийг дэмжих сан байгуулах, түүнд хөрөнгө бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ыг тус тус боловсруулан батлуулж, мөрдүүлжээ.

Хүснэгт 23. Бүсчилсэн хөгжилтэй холбоотойгоор гарсан хууль тогтоомжууд

	Нэр	Батлагдсан он
1.	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал	2001 -УИХ
2.	Бүсүүдийн тулгуур төв тогтоох тухай	2003-01-02 УИХ-ын 1 тогтоол
3.	Монгол улсын бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль	2003-05-30 УИХ хууль
4.	Монгол улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги батлах тухай	2003-06-12 УИХ –ын 24р тогтоол

Бүсчилсэн хөгжлийн хууль эрхзүйн хувьд нилээд олон хууль тогтоомж гарсан чиглэл нь эдийн засгийн чөлөөт бүсүүдийн тухай хуулиуд юм. Уг хуулиудын хүрээнд

Хүснэгт 24. Чөлөөт бүсийн тухай хууль тогтоомжууд

	Нэр	Батлагдсан он
1.	Монгол улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал	УИХ 87-р тогтоол 1995-12-04
2.	Чөлөөт бүсийн тухай хууль	УИХ 2002-06-28
3.	”Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн эрхзүйн байдлын тухай хууль	УИХ 2003-06-20
4.	“Алтанбулаг” худалдааны чөлөөт бүс байгуулах тухай	УИХ 37-р тогтоол 2002-06-28
5.	“Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн эрхзүйн байдлын тухай хууль	УИХ 2002-06-28
6.	Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн Эрхзүйн Байдлын тухай хууль	УИХ -2003
7.	“Цагааннуур” худалдааны чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба байгуулах тухай	ЗГ 2005-06 сар,134 дүгээр тогтоол
8.	“Цагааннуур” худалдааны чөлөөт бүс байгуулах тухай	УИХ 74-р тогтоол 2005 -12- 01

Чөлөөт бүсийн тухай хууль: Чөлөөлт бүсүүд нь үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын (худалдаа, үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, аялал жуулчлал) тусгайлан зарлагдсан газар

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

бөгөөд тусгай гаалийн, бусад татварын нөхцлийг эдлэнэ. Худалдааны чөлөөт бүс нь савлагаа, хадгалалт, барааны чанар, бүтэн байдлыг хамгаалах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилготой. Үйлдвэрлэлийн чөлөөт бүс нь экспортод чиглэгдсэн тэргүүний технологи, зах зээлд өрсөлдөх чадахуйц үйлдвэрлэлд чиглэгдэнэ. Аялал жуулчлалын бүс нь олон улсын хэмжээний дэд бүтэцтэй газарт хамаарагдана. Дээрх өргөн хүрээний арга хэмжээнүүд нь эдийн засгийн бүсэд хамаарагдана. Худалдааны чөлөөт бүсийг гаалийн байгууллага шалгах цэгүүдэд хянана. Засгийн газрын тодорхойлсноор чөлөөт бүс бүрийг тухайн орон нутгийн иргэдийн хурал батламжилана. Бүсийг Ерөнхий сайдаар томилуулсан Захирагч захирч, захирагч нь Ерөнхий менежерийг томилж болно. Чөлөөт бүс нь УИХ-аар батлагаажуулдаг төсвөөс санхүүжигдэнэ. Чөлөөт бүс рүү нэвтрэн ороход дараах татварын нөхцлүүд үйлчилнэ:

- 1) Онцгой, НӨАТ, импортын татвар үйлчлэхгүй;
- 2) Монголд орсон, онцгой татвар, НӨАТ-ийг төлсөн импортыг экспортын татвараас чөлөөлнө;
- 3) Монголын бараа бүтээгдэхүүн чөлөөт бүс руу ороход экспортын татварыг төлж, харин НӨАТ-ийг нь нөхөн олгоно.

Чөлөөт бүсээс гарахад дараах татварын нөхцлүүд үйлчилнэ:

- 1) Монгол руу орж байгаа бүтээгдэхүүнд импортын, онцгой татвар, НӨАТ ногдуулах;
- 2) Чөлөөт бүсэд орж ирэхээс өмнө импорт, онцгой татвар, НӨАТ-ыг төлсөн бол буцаад Монгол руу орохдоо эдгээрээс чөлөөлөх;
- 3) Монголын бараа бүтээгдэхүүн Монгол руу буцаад орж байгаа бол НӨАТ төлнө, харин импорт, онцгой татвар хамаарахгүй;
- 4) Чөлөөт бүсээс гадаадад гарч буй экспортод хуулинд өөрөөр заагаагүй бол экспорт, онцгой, НӨАТ хамаарахгүй.

Бусад татвар, хөнгөлөлтүүдийг хуулиар тогтооно. Газар эзэмшлий төлбөрийг УИХ-ын шийдвэрээр бууруулах боломжтой.

Бүсийн эдийн засгийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрхзүйн актууд болон тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэрэгслүүдийн харилцан уялдаа бүхий систем

Бүсчилсэн хөгжлийн зорилгод хүрхэд эдийн засгийн өсөлт чухал юм. Тиймээс бүс нутаг дахь эдийн засгийн харилцааг зах зээлийн зарчимаас гадна төрийн оролцоотойгоор зохицуулах, удирдан чиглүүлэх, хянах, дэмжлэг үзүүлэх нь зайлшгүй юм. Учир нь бүс нутаг дахь хүн амзүйн байдал, нийгмийн үйлчилгээний чанар хүртээмж, хүн амын төвлөрөл зэрэг нийгмийн хөгжлийг хангах тулгуур хөшүүрэг нь эдийн засгийн өсөлт юм. Иймээс эдийн засгийн өсөлтийг тогтвортой байлгах төрийн зохицуулалт нь амьдралд нийцтэй үндэслэлтэй, хэрэгжихүйц, үр дүнтэй, хурдан

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

шуурхай, уялдаа холбоотой байх шаардлагатай. Төрийн зохицуулалт нь хууль тогтоох, хэрэгжүүлэх, хяналт тавих гэсэн төрийн аппаратуудыг дамжин явагддаг.

Азийн хөгжлийн банкны бодлогын зөвлөмжийн баримт бичиг 6-д засгийн газрын бүс нутгийн хөгжилд үзүүлэх нөлөөг дараахь байдлаар тогтоосон байна.



Схем 6. Засгийн газрын бүс нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө

Эдгээр нөлөөллүүдийг тус бүрт хураангуйлж үзвэл:

- Өсөлтөнд чиглэсэн макро эдийн засгийн тогтолцоонд татвар, гаалиас чөлөөлөх, чөлөөт эдийн засгийн болон тусгай бүс байгуулах, зээлийн хэлбэрийг нэвтрүүлэх гэх мэт үйл ажиллагаанууд багтаж байна.
- Хөрөнгийн зах зээл буюу хөрөнгө оруулагчдад таатай зохистой орчныг бүрдүүлэх
- Зах зээл аж үйлдвэрийн салбарын тодорхой зорилтыг засгийн газар микро эдийн засгийн бодлогоор тодорхойлох
- Бүс нутагт ажлын байр бий болгох, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хийх
- Засгийн газар тухайн бүс нутгийн өрсөлдөх давуу байдлыг тодорхойлж, аж үйлдвэрийн тохиромжтой байрлалыг тодорхойлох гэсэн чиглэлүүд байна.

Эдгээрээс бүс нутгийн өрсөлдөх давуу талыг тодорхойлох, аж үйлдвэрийн оронзайн байршлыг нарийвлан тодорхойлох зэрэг нь ихээхэн сонирхол татахуйц асуудал юм. Аж үйлдвэрийн байршлын онол, чиглэлүүдийн талаар нарийвчлан судалгаа хийх, гадны орнуудаас туршлага судлах, үйлдвэрийн цогцолбор байгуулахад авч үзэх байршлын талаархи судалгаанд засгийн газрын зүгээс хөрөнгө оруулах шаардлагатай юм.

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги


Засгийн газар хүлээх үүрэгтээ голлон анхаарч, хувийн салбарууд л хөрөнгө оруулалт хийж өрсөлдөх давуу талыг тодруулахад тэдний үйл ажиллагааг дэмжиж, тухайн байршилд нь таатай, дэмжлэг үзүүлсэн, хөнгөвчилсөн орчныг бүрдүүлэх хэрэгтэй.¹¹

Дэмжлэг үзүүлсэн хөнгөвчилсөн орчныг бүрдүүлэх асуудал чухал боловч тухайн байршлыг эхлээд үнэлж, байршлын онолын болон практикийн иж бүрэн үнэлгээг хийсний дараа хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй гэж үзэж байна.

Энэ талаар “Өнөөгийн байгаа дэд бүтэц, аж үйлдвэржилтийн түвшин, зах зээлийн эрэлт хэрэгцээ, ханган нийлүүлэлт зэрэг хүчин зүйлд тулгуурлаж эдийн засгийн бүсүүдийг байгуулах нь чухал” [Д. Базаргүр] гэж үзсэн. Эдгээр нь дээр дурьдсан одоо байгаа байршлын судалгааг хийх хэрэгтэй гэсэн саналтай агуулгын хувьд нэгдэж байгаа юм. Мөн үүн дээр нэмэгдэж тухайн бүс нутгийн болон тулгуур төвийн хүрээнд эдийн засгийн оронзайн таталцлыг нэмж авч үзэх шаардлагатай юм.

Мөн тухайн эдийн засгийн бүсийн хил хязгаар хувьсан өөрчлөгдөх зүй тогтлын цаашдын хандлагыг мөн судалгаанд хамруулан авч үзэх шаардлагатай юм. Эдийн засгийн бүсийн хил хязгаарт тухайн бүс нутаг дахь үйлдвэрлэл, хүн ам, байгаль орчны болон нийгмийн салбарын бүхий л хүчин зүйлс цогцолбор байдлаар нөлөөлж байдаг. Тиймээс бүс нутгийн хөгжлийн судалгааг иж бүрнээр нь хийж байршлын хүчин зүйлстэй нь уялдуулах хэрэгтэй. Үүний үндсэн дээр бүсчилсэн хөгжлийн стратеги төлөвлөлтийг хийх нь үр дүнтэй юм.

Хууль эрхзүйн орчин болон төрийн оролцоо, шинжлэх ухааны судалгааг дараах дарааллаар хийх нь илүү үр дүнтэй болно гэж үзэж байна.




Схем 7. Хууль эрхзүйн орчин болон төрийн оролцоо, шинжлэх ухааны судалгааны дараалал

Бүсчилсэн хөгжлийн зорилгод хүрэхийн тулд хөгжлийн үзэл баримтлалыг хангахуйц хууль эрхзүйн орчин байх шаардлага зүй ёсоор урган гарч ирнэ. Энэ нь зөвхөн бүсчилсэн хөгжилтэй холбоотой хууль тогтоомжоос гадна бусад олон салбарын

¹¹Бодлогын зөвлөмжийн баримт бичиг №5 “Тулгуур төвүүд, үйлдвэр, аж ахуйн газрын кластер ба бүс нутгийн хөгжил” 2004 он

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

хууль, тогтоомжууд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хангаж чадахуйц байгаа дээр дүн шинжилгээ хийж үзвэл:




Схем 8. Төрийн байгуулалтын хүрээнд гаргасан хууль тогтоомж

Дээрхи хийгдэж байгаа ажлууд нь бүсийн болон бүс нутгийн хөгжлийн стратегийг тодорхойлж, тэдгээрийн хэрэгжүүлэх төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох ажлын хүрээнд бүсүүдийн болон аймгуудын хөгжлийн хөтөлбөр боловсруулагдсан.

Гэтэл энэ хөтөлбөрүүдийн тухайн бүс нутаг болон аймгийн түвшинд хэрэгжих хэрэгжилт сул байна. Үүний шалтгаан нь хоорондын уялдаа холбоо муу байгаагаас үүдэлтэй.

Татварын болон бизнесийн орчин нөхцлийг сайжруулах, бүсийн хөгжлийг хурдасгах зорилгын хүрээнд хамрагдах хууль тогтоомжийн заримыг авч үзвэл



Схем 9. Татварын болон бизнесийн орчин нөхцлийг сайжруулах, бүсийн хөгжлийг хурдасгах зорилгын хүрээнд хамрагдах хууль тогтоомж

Бүсийн хөгжлийг татварын бодлогоор дэмжих гэсэн заалт байгаа боловч татварын хуулинд бүс нутгаар ялгавартайгаар татвар тогтоох тухай нэг ч зүйл заалт байхгүй байна. Харин хуулийн 12-р зүйлийн Албан татвар ногдох орлогоос хасагдах зардал гэсэн хэсэгт

”Үйлдвэрлэл, технологийн паркийн эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах шугам сүлжээ, цэвэр усан хангамж, бохир усны шугам, цэвэрлэх байгууламж, авто зам, төмөр зам, харилцаа холбооны дэд бүтэц бий болгоход оруулсан хөрөнгө” гэж 2009 онд нэмж оруулсан ганц заалт л бүс нутгийн хөгжилд нөлөө үзүүлэх боломжтой юм.

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

Мөн уг хуулинд “Дор дурдсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн буюу тариалсан аж ахуйн нэгжийн зөвхөн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох албан татварыг 50 хувиар хөнгөлнө

- Үр тариа, төмс, хүнсний ногоо;
- Сүү;
- Жимс жимсгэнэ;
- Тэжээлийн ургамал” гэсэн заалтанд бүс нутгаар ялгавартай хөнгөлөлт үзүүлэх тухай заалтыг нэмж оруулах боломжтой юм.

2011 онд УИХ-аар хэлэлцэгдэж байгаа бүсийн нэмэгдлийн тухай хуулинд алслагдсан бүс нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдад бүсийн нэмэгдэл өгөх, түүнчлэн татварын хөнгөлөлт эдлүүлэх зэрэг арга хэмжээг авахаар тусгагдсан байна.

Цөөн тооны хуулийн хүрээнд авч үзэхэд бүс нутгийн бодлоготой бусад хуулиуд харилцан уялдаагүй байгаа нь харагдаж байна. Цаашлаад нилээд чухал ач холбогдолтойд тооцогдох “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулинд өөрчлөлт оруулах нь бүсийн хөгжлийг түргэтгэх боломжтой юм. Энэ хуулийн хүрээнд тодорхой ажлууд хийгдсэн боловч хуулийн хүрээнд өөрчлөлт ороогүй байсаар байна.

Дээрхи бүгдийг дүгнэж үзэхэд бүсчилсэн хөгжлийг хангах, зохицуулах, хууль эрхзүйн орчин, төрийн байгууллагын дэмжлэг маш сул байна гэж үзэх боломжтой байна.

Бүс нутгийн бодлогын улс төрийн дэмжлэг

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд “бүсчилсэн хөгжлийг төрөөс дэмжих бодлогын гол чиглэл нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, тэдгээрийн орчмын нутгийн хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний хэт бөөгнөрөл, удирдлагын төвлөрөл, экологийн тэнцлийн алдагдлыг сааруулж, бүсүүдийн хөгжлийн түвшинг эрэмбэ дараатай дээшлүүлэх явдал юм” гэж заажээ. Мөн бүсчилсэн хөгжлийн зорилго, зорилтыг төрөөс дараахь бодлогоор дэмжин хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Төрийн байгуулалтын хүрээнд
2. Эдийн засгийн байгуулалтын хүрээнд
3. Байгаль орчныг хамгаалах хүрээнд
4. Нийгэм, соёлын хүрээнд
5. Хүн амын нутагшил, хот байгуулалтын хүрээнд
6. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд тус тус төрөөс бодлогоор дэмжин хэрэгжүүлнэ.

Төрийн байгуулалтын хүрээнд гэдэгт төрөөс бүсчилсэн хөгжлийг дэмжих эрх зүйн зохицуулалтыг хийх, бүс нутгийн хөгжлийн стратегийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэх төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

болгох, бүсийн хөгжлийг төсөв, хөрөнгө оруулалт, мөнгө зээлийн бодлогоор дэмжих, бүс нутагт банк, санхүү, даатгалын тогтолцоог бүрдүүлэх, бүс нутгийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог дэмжин урамшуулах явдал юм. Түүнчлэн бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн нийтлэг зорилтыг шийдвэрлэхэд аймаг, нийслэл, хот, тосгоны хамтын ажиллагааг өргөжүүлж, засаг захиргаа нутаг дэвсгэрийн байгууламжийг боловсронгуй болгох зэрэг болно.

Эдийн засгийн байгуулалтын хүрээнд бүс нутгийн байгаль орчны даац, чадавхийг бүрэн зохистой ашиглах, орон нутгийн хүн амын хөдөлмөрийн дадлага, чадварыг дээшлүүлэх шаардлагад зохицсон жижиг, дунд үйлдвэрлэлийн сүлжээ бүрдүүлэх, дэлхийн зах зээлийн болон дотоодын хэрэгцээг харгалзан бүсүүдийн хүрээнд импортыг орлох, гадаад зах зээлд өрсөлдөх чадвар бүхий олон улсын стандартад нийцсэн, экологийн хувьд цэвэр бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг дэмжин хөгжүүлэх, тухайн бүсийн хүрээнд аймаг, нийслэл, хот, тосгоны хоорондын, салбар хоорондын аж ахуйн хоршилт, хослолыг дэмжин хөгжүүлэх, бүсийн төвүүдийг хооронд нь болон бусад хот, тосгонтой холбосон эрчим хүч, зам барилга, холбоо, мэдээллийн технологийн дэд бүтэц, сум дундын бөөний худалдааны сүлжээ байгуулах зэрэг улсын хэмжээний том асуудлыг авч үзнэ.

Байгаль орчныг хамгаалах хүрээнд нийгмийн хөгжлийг байгаль орчны даац чадавхтай тэнцэлтэй уялдуулахад чухал ач холбогдол бүхий бүсийн болон бүс нутгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, байгалийн гамшгийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгахтай холбогдсон хяналт, мэдээлэл, тусламжийн бүс нутгийн сүлжээ бүрдүүлэх, байгалийн баялгийг нөхөн сэргээх, хүн амын амьдрах орчны аюулгүй байдлыг хангахтай холбогдсон аймаг, сум дундын ач холбогдол бүхий нийтлэг арга хэмжээг санхүүжүүлэх, байгалийн баялгийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, нөхөн сэргээх, амьдрах орчинд хал багатай дэвшилтэт арга технологи-нэвтрүүлэх, шилжүүлэх үйл ажиллагааг дэмжих, тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг бүс нутаг, хот, тосгоны хөгжлийн чиг хандлагатай уялдуулан боловсронгуй болгох, бүс нутгийн хөгжлийн асуудлыг байгаль орчны даац, нөөц баялгийн экологи-эдийн засгийн үнэлгээ, төлбөр, тооцооны үндсэн дээр шийдвэрлэх чадвар бүхий бүсийн байгаль орчны төлөвлөлт, удирдлагын бие даасан тогтолцоог бүрдүүлэх, бүсийн хүрээнд тодорхой газар нутгийг гадаадын сонирхогч улс орон, гадаадын хөрөнгө оруулагчдад гэрээний үндсэн дээр урт хугацаагаар түрээслэн ашиглуулж байгаль орчин, хөгжлийн асуудлыг иж бүрэн шийдвэрлэх нөхцөлийг хангах зэрэг асуудлыг төрөөс дэмжинэ.

Нийгэм, соёлын хүрээнд бүсүүдэд их сургууль, коллежийн салбар, судалгаа, мэдээллийн болон сургалтын төвүүд байгуулахыг дэмжиж тухайн бүс нутгийн хөгжлийн чиглэлтэй уялдсан боловсрол, шинжлэх ухааны шинэ хэв шинж бүхий

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

тогтолцоо бүрдүүлэх, оношлогоо, эмчилгээний бүсийн болон бүс нутгийн төрөлжсөн төвүүдийг байгуулахын хамт, сум дундын эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн эдийн засгийн хөшүүргийг боловсруулж хэрэгжүүлэх, хөдөөгийн хүн амын ядуурлыг бууруулах, ажил эрхлэлтийг дэмжих сум дундын зориулалтын санхүүгийн механизм бий болгох, алслагдсан болон говийн бүс нутагт ажлын байр бий болгосон хөрөнгө оруулагчдыг татварын бодлогоор урамшуулах, хүн амын амьжиргааны доод түвшин, нийгмийн даатгалын шимтгэлийг бүс нутгийн ялгавартай тогтоох, алслагдсан болон говь нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагч, багш, эмч нарт цалин хөлсний нэмэгдэл урамшуулал олгох, амьдралын нөхцлийг нь сайжруулах, тогтвор суурьшилтай аж төрөхөд нь дэмжлэг үзүүлэх, хүн амын хүнсний хэрэглээний нормыг тогтоож, хүнсний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг бүс нутгийн бодлогод тусган хэрэгжүүлэх, мэргэжлийн соёл, урлагийн байгууллагыг хот, хөдөөгийн хүн амд үйлчлэх төрөл, хүрээгээр нь бүсчлэн байгуулж, үндэстэн, угсаатны соёл, ёс заншлыг хадгалж өвлүүлэхийн хамт, үндэстэн хоорондын соёл, урлагийн харилцааг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлэх, тухайн бүсийн хүрээнд хот, хөдөөгийн хүн ам амьдрах арга ухаан, хөдөлмөрлөх дадлага, туршлагаа харилцан солилцох, уугуул нутгаа хөгжүүлэх талаар орон нутгийн байгууллага, төрийн бус байгууллагууд хамтран ажиллах явдлыг хөхүүлэн дэмжих зэрэг болно.

Хүн амын нутагшил, хот байгуулалтын хүрээнд бүс нутгийн хөгжлийн үндсэн чиглэл, орон нутгийн байгаль, цаг уурын онцлог, хүн амын тоо, түүх, соёлын уламжлал, хот, хөдөөгийн хүн амд үйлчлэх хүрээ зэргийг харгалзан Монгол Улсын хот, тосгоны зохистой хэмжээ, бүтцийн загварыг боловсруулж, хот, тосгоныг үе шаттайгаар сэргээн хөгжүүлэх, бүсийн төв болгон хөгжүүлэх хотуудын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, Улаанбаатарын болон бусад бүсийн хэмжээнд Улаанбаатар хотын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний бөөгнөрлийг задлах зохистой чиглэл, хотын оршин суугчдын амьдрах орчны чанар, аюулгүй байдлыг хангах, хотын газрыг үр ашигтай ашиглах, инженерийн шугам сүлжээ, замын байгууламжийг шинэчлэх шаардлагыг бодолцон нийслэл хотын хөгжлийн стратеги, ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хамтын хүч чармайлтыг нэгтгэн зохион байгуулах, эрх зүй, эдийн засаг, нийгэм сэтгэл зүйн зохих нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр Монгол Улсын нийслэлийг Улаанбаатар хотоос тус улсын нутаг дэвсгэрийн төв хэсэгт шилжүүлэн байршуулах асуудлыг иж бүрнээр судалж 2020 он хүртлэх хугацаанд шийдвэрлэх, улсын хэмжээнд эдийн засгийн бүсчлэл, хот байгуулалтын стратегийн удирдлага, төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, эдийн засгийн бүсүүдийн хэмжээнд, нутаг дэвсгэр зохион байгуулалтын товчоод байгуулах ажлыг дэмжих зэрэг болно.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрийг зүүн бүсэд: Чойбалсан-Эрэнцав, Чойбалсан-Сүмбэр-Рашаантын чиглэлээр Азийн орнуудын

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

авто болон төмөр замын сүлжээнд холбож улмаар Зүүн хойт Азийн хамтын ажиллагааны “Түмэн гол” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, Ази Номхон далайн орнуудтай харилцах гарц нээх; төвийн бүсэд:

Алтанбулаг-Сүхбаатар-Улаанбаатар-Сайншанд-Замын үүдийн чиглэлээр Азийн авто болон төмөр замын олон улсын сүлжээнд холбож Ази-Европыг дамжсан улс хоорондын худалдаа-тээврийн харилцааны гол талбар болгох; баруун бүсэд: Цагаан нуур, Хандгайт, Арц суурь, Булган, Бургастайн чиглэлээр ОХУ, БНХАУ-ын худалдаа-эдийн засгийн сүлжээнд холбох зорилтыг үе шаттай хэрэгжүүлэх, цаашид Таван богдын шилийн чиглэлээр улсын хөндлөн гол тэнхлэгийг Дундад Ази, Ойрхи Дорнодын орнуудтай холбох боломжийг судлах; хангайн бүсэд: Бага -Илэнх, Ханх, Тэшиг, Шивээ хүрэнгийн чиглэлээр ОХУ, БНХАУ-тай худалдаа, эдийн засгийн сүлжээнд холбогдох зорилтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, эхний ээлжинд ОХУ-тай хил залгаа “Алтанбулаг” /Сэлэнгэ аймаг/, “Цагааннуур” /Баян-Өлгий аймаг/, БНХАУ-тай хил залгаа “Замын-Үүд” /Дорноговь аймаг/ боомтод түшиглэн худалдаа, гаалийн тусгай /чөлөөт/ бүсүүд байгуулж, олон улсын жишгийн дагуу уг бүсүүдийн хүрээнд дотоод, гадаадын худалдаа эрхлэгчид, хөрөнгө оруулагчид харилцан ашигтай, хамтран ажиллах бизнесийн орчныг бүрдүүлэх, зохих туршлага бүрдмэгц Монгол Улсын нутаг дэвсгэрийн гүнд тусгай /чөлөөт/ бүсийг зохистой төрөл, чиглэлээр байгуулах ажлыг өргөжүүлэх, гадаадын сонирхогч орнууд болон гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтран Монгол Улсын тодорхой бүс нутгийг хөгжүүлэх иж бүрэн арга хэмжээний хөтөлбөр боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх хүрээнд олон улсын банк, санхүү, мэдээлэл, технологийн өндөр үр ашигтай тогтолцоог тогтвортой ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилтын хэрэгжилтийг гадаад харилцааны олон сурвалжит бодлогоор дэмжих арга, хөшүүргийг тогтоож, дэлхийн хөгжингүй орнуудаас Монгол Улсад үзүүлж байгаа дэмжлэг, эдийн засгийн хамтын ажиллагааны боломжийг бүс нутгуудын хүрээнд өргөжүүлэн гүнзгийрүүлэх зэрэг асуудлуудыг төрөөс дэмжиж байна.

Бүсчилсэн хөгжлийн холбогдолтой эрх зүйн баримт бичгүүд, Баруун, Хангайн, Төвийн, Зүүн бүсийн зөвлөлгөөний материалыг хэвлүүлж, гарын авлага болгон гаргажээ. Бүс нутгийн хөгжлийн асуудлыг телевиз, радио, сонин зэрэг мэдээллийн хэрэгслээр сурталчилсны үр дүнд Монгол Улсыг бүсчилж хөгжүүлэх нь чухал гэсэн ойлголтыг төв, орон нутгийн засаг захиргааны бүх нэгжүүд авч үйл ажиллагаагаа бүсчилсэн хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдтэй уялдуулах болсон байна. Гэвч бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрийн үйл явц, үр дүнг иргэдэд таниулах тогтолцоо, үйл явц удаашралтай байгаагаас иргэд мэдээлэл авч чадахгүй байна. Бүсүүдийн зөвлөлийн хурал, гаргасан шийдвэр, үйл ажиллагааны тайлан материалын олдоц муу, Улаанбаатарын бүсийн зөвлөлөөс бусад зөвлөлүүд нь өөрийн гэсэн вэб сайтгүй зэрэг нь мэдээллийн ил тод, хүртээмжтэй биш байдлыг үүсгэж байна.

4.2 Бүс нутгийн чиг үүргийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд

Бүсийн хөгжлийн стратегийн төлөвлөлт

Судалгааны ном зохиол практикаас харахад өнөө үед стратеги гэдгийг хоёр янзаар төсөөлж байна. Энэ нь:

- Үйл ажиллагааны төлөвлөгөө
- Бодлогын удирдамж

Бид энэхүү нэр томъёог үйл ажиллагааны төлөвлөгөө гэдэг утгаар авч үзэж болно. Бүсийн хөгжлийн стратегийн төлөвлөгөө нь :

- Бүсийн хөгжлийн зорилго
- Тавьсан зорилгодоо хүрэх арга зам
- Бүсийн хөгжлийн чадавхи
- Нөөц, боломж, тэдгээрийг ашиглах арга зам
- Зохион байгуулалтын арга хэрэгсэл зэргийг харилцан хамааралтай авч үзсэн удирдамжийн чанартай баримт бичиг юм.

Тухайн бүсийн удирдлага болон төрөл бүрийн институци хамтран ажиллах боломж бүрдүүлэх нь стратегийн төлөвлөгөөний нэг чухал зорилт юм. Стратегийн төлөвлөгөөг зөвхөн засаг захиргаанд хамаатай баримт бичг гэхээсээ бүсийн хөгжлийн процесст оролцогч бүхэнд хамааралтай бөгөөд дээрээс өгсөн удирдамжаасаа илүү асуудлыг шийдвэрлэхийн тулд иргэд, бизнесийнхний зүгээс засаг захиргаандаа хандсан нэг ёсны шаардлага гэж үзвэл зохилтой. Асуудлын мөн чанарыг ингэж авч үзэхийн тулд төлөвлөлтийн процесст иргэд, улс төрчид, эрдэмтэд, ажил хэрэгч хүмүүс зэрэг сонирхсон бүх талын оролцоог хангах ёстой юм. Өөрөөр хэлбэл, бүс нутгийн хөгжлийн нөөц, боломжоос гадна өөр чухал хүчин зүйл бол аливаа жижиг эрх ашгаас нийт бүсийн эрх ашгийг дээгүүрт тавих, нийгмийн зөвшилцлийн нөхцлийг бүрдүүлэх, ингэснээр тухайн бүсийн иргэд, аж ахуйн нэгж, бусад субъектуудийн ашиг сонирхлыг жигд харгалзан үзэх явдал юм.

Стратегийн төлөвлөлтийн зайлшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг нь түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө юм. Бүсийн нийгэм-эдийн засгийн стратегийн төлөвлөгөөний үндсэн шинж чанар нь:

- Бүсийн сул болон давуу талыг тодорхойлох, давуу талаа хөгжүүлэх, төлөвшүүлэх, түүнийг юуны өмнө хүмүүсийн амьдралын нөхцлийг сайжруулах, бизнесийг хөгжүүлэхэд чиглүүлэх
- Төлөвлөгөө нь хөгжлийн ирээдүйг харсан шийдвэрийг биелүүлэхэд нь үйлдвэрлэгчид, хөрөнгө оруулагчид, нутгийн захиргаа болон хүн амд тус болохуйц үндсэн зарчим, үзэл санааг агуулж байх

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

- Төлөвлөгөө нь бүсийн хүн ам, үйлдвэрлэлд тус болох стратегийн шинжтэй арга хэмжээний нэг ёсны гэрээ болох
- Төлөвлөгөө нь хэтийн зорилт болон өнөөдрийн арга хэмжээний хослол бөгөөд хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх бүх чиглэлээр дэд зорилгууд тэдгээрт хүрэх арга механизм, хяналт шалгалт, хяналт шинжилгээ, үнэлгээний арга хэрэгслийг боловсруулах зэргээр илэрхийлэгдэнэ.

Бүсийн нийгмийн хөгжлийн түвшин түүний эдийн засгийн хөгжилтэй шууд уялдаатай учраас юуны өмнө эдийн засгийн хөгжлийг төлөвлөх шаардлагатай бөгөөд энд гол асуудлууд нь:

- Ажлын байр шинээр бий болгох
- Бүс рүү шинэ үйлдвэрлэлийг татах
- Одоогийн үйлдвэрлэлээ хөгжүүлэх
- Үйлдвэрлэлийн бүтцийг шинэчлэх зэрэг юм.

Хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлүүд нь газарзүйн тусгаарлагдмал байдал, дотоодын хуримтлалын доогуур түвшин, эдийн засгийн зохистой бус бүтэц, банк санхүүгийн сул тогтолцоо зэрэг юм.

Бүсийн эдийн засгийн хөгжлийн стратегийн төлөвлөлтийн циклийг товчоор дараах байдлаар томъёолж болно.

1. Хөгжлийн зорилгыг тодорхойлох. Төлөвлөгөө нь стратегийн дараах гурван зорилгод хүрэхэд чиглэсэн байвал зохино. Үүнд:


- Бизнесийн таатай орчныг бий болгох:
 - Олон төрлийн зөвшөөрөл, лицензийн системийг хөнгөвчлөх, хүнд суртлыг багасгах, авилгалтай тэмцэх
 - Татварын дарамтыг багасгах
 - Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх
 - Банк, санхүү, даатгал, хадгаламжийн найдвартай тогтолцоог бүрдүүлэх
 - Ажиллах хүчний зах зээлийг хөгжүүлэх
 - Бодит секторт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
- Эдийн засгийн интеграцчилах
 - Экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх
 - Өрсөлдөх чадвартай үйлдвэрлэгчийг дэмжих
 - Гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх
 - Хувь хүний болон бизнесийн аюулгүй байдлыг хангах
 - Шинжлэх ухаан, боловсролыг хөгжүүлэх
 - Мэдээллийн глобаль орчинд нэгдэн орох
- Нийгмийн орчныг сайжруулах
 - Бүсийн боловсрол, соёл, оюуны потенциалыг хөгжүүлэх
 - Төв суурин газрын орон сууцны асуудлыг шийдвэрлэх

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

- Ус, дулаан, эрчим хүчний хангамж, холбоо зам харилцааг сайжруулах
 - Нийгмийн аюулгүй байдлыг хангах
 - Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх
2. **Бүсийн хөгжлийн гадаад орчныг шинжлэх.** Гадаад орчин –газарзүйн байрлал, цагагаар, хүн амзүйн хандлага, улс орны макро эдийн засгийн байдал, хөрш зэргэлдээ улсууд, дэлхийн хөгжлийн ойр байрших төвүүдтэй холбогдох боломж
- Дотоод орчин – төрөл бүрийн нөөц, түүнийг ашиглах боломж, АА эрхлэх болон хөрөнгө оруулалтын орчин, дэд бүтэц
3. **Бүсийн давуу болон сул талыг тодорхойлох.** Гадаад орчны нийгэм, эдийн засаг, экологийн тоон болон чанарын шинжилгээний тусламжтайгаар тухайн бүсийн эдийн засгийг хөгжүүлэхэд ашиглаж болох гадаад нөөц (санхүүгийн, байгалийн, хүний)-ийг үнэлж болно.
4. **Байгаа давуу талаа үр ашигтай ашиглах, шинээр бий болгох.** Стратегийн төлөвлөлтийн энэ шатанд:
- Бүс өөрийн давуу талаа (байрлал, дэд бүтцийн хөгжил, үндсэн зах зээлд ойр гэх мэт) хөгжлийг түргэтгэх хөшүүрэг болгон ашиглах боломжийг авч үзэх
 - Өмнө нь хэрэгжүүлсэн бүсийн нийгэм эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтийг шинжлэх
 - Эдгээрт тусгасан арга хэмжээний ололт, дутагдлын шалтгааныг тодорхойлох
 - Бүсийн хөгжлийн дотоод хүчин зүйлсийг тодотгох, бүс хөгжлийн ямар шатанд байгааг тодорхойлох
 - Хаана ямар салбарт, хүчин зүйлсийн нөлөөгөөр нэмүү өртөг бүтээгдэж байгаа буюу бий болох боломжтойг тодорхойлсны үндсэн дээр бүсийн эдийн засгийн хөгжлийн зорилгыг нарийвчлан тодотгох ажил хийгдэнэ.
5. **Хөгжлийн үзэл баримтлал, стратеги боловсруулах.** Бүсийн нийгэм эдийн засгийн хөгжлийн зорилго, хүчин зүйлс, хөдөлгөгч механизм, хөгжлийг удирдах арга хэрэгслийн талаар эцсийн дүгнэлт хийгдэнэ. Дүгнэлт хийхдээ бүс нутгийн хөгжлийн шинэ хандлага, үндэсний эдийн засгийн өнөөгийн шатны онцлогийг тооцох учиртай. Үзэл баримтлалд тухайн бүсийн давуу тал, хөгжлийн голлох чиглэл, нөөцийг илрүүлэн гаргана. Үзэл баримтлалыг боловсруулснаар стратегийн хувилбарууд гарч ирэх ба харьцуулан үнэлж, оновчтой сонголт хийх буюу хувилбарын эерэг зүйлүүдийг авч боловсронгуй болгох боломж гарна.
6. **Үйл ажиллагааны тодорхой төлөвлөгөө боловсруулж, стратегийг хэрэгжүүлэх.** Нийгэм эдийн засгийн хөгжлийн үзэл баримтлал, стратегийн үндсэн дээр үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна. Энэ төлөвлөгөөнд хүлээгдэж буй үр дүн, шийдвэрлэх хугацаа, зорилт, санхүүжилтийн эх үүсвэр, хэмжээ, завсрын хяналт, тайлагнах механизмыг тусгана.
7. **Үр дүн, үр ашгийн шинжилгээ, зорилго, түүнд хүрэх арга барилаа эргэж харах.** Бүсийн хөгжлийн стратегийн удирдлага нь тухайн бүсийн нийгэм эдийн засгийн төлөв байдалд байнгын мониторинг хийж, түүнийхээ үр дүнг бүсийн хөгжлийн зорилго, шалгууртай харьцуулан, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, үр

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

ашгийг үнэлнэ. Стратеги нөөц, боломжтой нийцэж байна уу? Стратеги бүсийн тулгамдсан асуудлыг шийдэхэд тусалж байна уу? Стратеги хүн амын дэмжлэгийг авч байна уу? гэсэн асуултанд хариулт өгнө.



Схем 10. Бүсийн хөгжлийн стратегийн төлөвлөлтийн цикл

Бүс нутгийн чиг үүргийг тодорхойлох шалгуур үзүүлэлт

Ерөнхий утгаараа бол бүс нутгийн хөгжлийн гол зорилго нь “Бүс нутгийн хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх” гэж тодорхойлж болно. Гадаадын өндөр хөгжилтэй орнуудын жишээ туршлагаас харахад дээрх зорилгыг хэрэгжүүлэхэд хэд хэдэн шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан тогтоодог бөгөөд эдгээрийг төвийн бүсийн чиг үүргийг тодорхойлоход ашиглаж болох юм.

Ямар зориулалтаар бүс нутгийг ашиглах вэ гэдэг зорилгод тулгуурлан бүс нутгуудыг тодорхойлдог. Зорилгоос хамааран бүс нутгуудыг хэд хэдэн хувилбараар тогтоож болно.

Бүс нутгийг тодорхойлох, хил хязгаарыг тогтооход хүснэгт 5-д тусгасан шалгууруудын жагсаалтаас хэд хэдийг авч болох юм. Зарим нэг нь Монголын өнөөгийн хөгжлийн түвшинд тохирохгүй бөгөөд тэдгээрийг (ашиглах боломжгүй) гэж ялгасан болно. Түүнчлэн өнөөгийн төвийн бүсийн загварт эдгээр шалгуурууд нь нийцэж байгаа эсэхийг хүснэгтэд мөн ялган харуулав.

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

Хүснэгт 25. Бүс нутгууд /Бүс нутгуудын хил хязгаарыг тодорхойлоход ашиглаж болох шалгуурууд/

	Шалгуур үзүүлэлтүүд
1	Хот, хөдөөгийн ялгаа багасаж буй эсэх
2	Хүн амын амьжиргааны түвшин сайжирч буй эсэх
3	Хүн амын шилжих хөдөлгөөний эрчим
4	Эдийн засаг нийгмийн ижил үзүүлэлт, хөгжлийн индекс
5	Нийгэм хүмүүнлэгийн үйлчилгээг бүрэн хүргэх боломжтой бичил бүсүүд
6	Эдийн засаг, нийгмийн зөв төлөвлөлт бүхий хөгжлийн стратегийг дэмжих чадавхи бичил бүс
7	Ач холбогдол багатай нутаг дэвсгэрүүд
8	Бүс нутгийн бодлого төлөвлөлтөнд шаардагдах мэдээллийг гаргах боломжтой засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хил хязгаар
9	“Сонирхолын бүлгүүд” байж болох газар нутгууд
10	Засгийн газрын нэгдсэн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн төлөвлөлт, хөгжлийн бодлого
11	Томоохон хот, суурин газрууд түүний дагуул суурингууд (хүн амын кластер)
12	Уламжлал, түүхэн нөхцөл байдал
13	Үндэсний хэмжээний тулгуур бүс нутгууд
14	Байгаль, цаг уурын ижил төстэй нөхцөл байдал: Гадрага, хөрс ургамал, бэлчээр, усан хангамж г.м
15	Аж үйлдвэрийн кластерууд буюу эдийн засгийн сүлжээ
16	Соёл, шашин, түүх, уламжлал, зан заншил
17	Орлогын харилцан хамааралтай нутаг дэвсгэрүүд
18	улсын болон хувийн салбарын хүрээнд шийдвэр гаргах, мэдээлэл солилцооны чиглэлээр төв, тулгуур төвүүд нөлөө үзүүлж болох газар нутгууд
22	Орон нутгийн түвшинд бодлогын шийдвэр гаргахад нөлөөлөх чадавхи бүхий аж ахуйн нэгжүүд
23	Эдийн засаг санхүүгийн чадавхийн тэнцвэртэй байдал
24	Асуудлыг шийдвэрлэхэд орон нутаг иргэдийн оролцооны түвшин
25	Орон нутгийн түвшинд хэрэгжих үйл хөгжлийн нөөц бололцоо
26	Технологи
27	Бизнесийн болон төрийн бус байгууллагын хамт олны үүсэл санаачлагын байгууллагын (ББ) идэвхтэй оролцоог дэмжсэн засаг захиргаа, удирдлагын бүтэц

Бүс нутгуудыг тодорхойлох үндсэн зарчим нь ямар зориулалтаар эдгээр бүс нутгуудыг ашиглах вэ гэдэгт тулгуурладаг.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Монгол улсын бүс нутгийн хөгжлийн үндсэн гол зорилгыг дараах байдлаар тодорхойлсон өнөөгийн нөхцөл байдалд нийцсэн нь сайшаалтай юм. Үүнд: “Бүс нутгийн хөгжлийн үндсэн гол зорилго нь бүс нутаг

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

доторх хот, хөдөөгийн ялгааг багасгах, Монгол улсын эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, нийгмийн дэвшлийг дэмжих таатай орчинг бүрдүүлэхэд оршино.” Энэ нь төрийн үүргийг тодотгож өгч байгаагаараа ач холбогдолтой бөгөөд төр, бодлого боловсруулагчид бүс нутгийн хөгжлийг зааварчлан чиглүүлэх биш харин үйл ажиллагааг нь дэмжсэн, хөнгөвчилсөн бодлого, стратегид ажлаа чиглүүлэх замаар үндсэн чиг үүргийг нь тодорхойлсон байна..

Төвийн бүсийн чиг үүргийг илүү үр дүнтэй тодорхойлоход дараах холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзэх нь зүйтэй юм. Эдгээр шалгуур үзүүлэлтүүд нь өндөр хөгжилтэй орнуудын бүсчлэлийн бодлогод баримталдаг үзүүлэлтүүд бөгөөд манай улсын бүсчилсэн хөгжил, тэр тусмаа төвийн бүсэд авч хэрэгжүүлэхэд илүү тохиромжтой. Үүнд:

- Хот, хөдөөгийн ялгааг багасгах замаар нийслэлийн төвлөрлийг сарниулах, шилжилт хөдөлгөөнийг сааруулах
- Жижиг хот, суурин, хөдөөгийн ядуурлыг бууруулах, ажилгүйдэл ихтэй газруудад ажлын байр нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийг багасгах,
- Хөдөө болон бусад жижиг суурингуудад үзүүлэх хүмүүнлэг, нийгэм соёлын үйлчилгээг сайжруулах зэрэг юм.

Хүний Хөгжлийн Илтгэлд (НҮБ, 2003) эдгээр шалгууруудын ач холбогдлыг нилээд тод тэмдэглэсэн байна. Дэд бүтэц, аж үйлдвэржилтийн өнөөгийн байгаа түвшинд, түүнчлэн нийлүүлэлт, эрэлт хэрэгцээ зэрэг зах зээлийн хүчин зүйлд тулгуурласан бүс нутгуудыг байгуулах талаар Базаргүр (2003) нарын эрдэмтэн судлаачид тэмдэглэсэн байна.

Төвийн бүс нутгийн үүргийг авч үзэхэд дан ганц нэг үзэл баримтлалд тулгуурлан авч үзэх нь өрөөсгөл тул харьцангуй олон талаас нь чиг үүргийг тодорхойлохыг зорилоо. Чиг үүрэг тус бүрийг өнөөгийн нөхцөл байдал, цаашид урган гарах хэрэгцээ шаардлагыг харгалзан нийгмийн хөгжил, эдийн засгийн хөгжил, байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалалт гэсэн хэсгүүдэд хуваан тодорхойлсон болно.

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**




Схем 11. Нийгмийн хөгжилд төвийн бүсийн гүйцэтгэх үндсэн чиг үүрэг




Схем 12. Эдийн засгийн хөгжилд төвийн бүсийн гүйцэтгэх үндсэн чиг үүрэг

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги



Схем 13. Байгаль орчныг ашиглах, хамгаалахад төвийн бүсийн гүйцэтгэх үндсэн чиг үүрэг

Хүн амын нутагшил, суурьшлын хувьд төвийн бүсийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох нь энэхүү судалгааны ажлын нэг зорилго бөгөөд энэ үүргийг бүдүүвч 8-д үзүүлэв.



Схем 14. Хүн амын нутагшил, суурьшлын хувьд төвийн бүсийн

4.3 Төвийн бүсийн үндсэн үүрэг

2001 оны 6-р сарын 14-ний өдрийн УИХ-ын 57 дугаар тогтоолоор Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлагдсан юм. Энэ нь Монгол орныг бүсчлэн хөгжүүлэх асуудлаар явуулсан судалгаа, боловсруулсан ажлуудын үр дүнг нэгтгэн төр засгаас хэрэгжүүлэх үндсэн чиглэл, бодлогыг тодорхойлсон нь гол үр дүн юм. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4.2-т нь Бодлогын гол чиглэлийг хэрэгжүүлэх болсон Монгол улсад эдийн засгийн Баруун, Хангайн, Төвийн, Зүүн гэсэн дөрвөн бүсийг тогтоож, Улаанбаатар хотыг бие даасан бүсийн жишгээр хөгжүүлнэ гэж үзсэн.

Бүсүүдийн байгаль, түүхий эдийн нөөц, эдийн засаг, нийгэм, оюуны чадавхийг харгалзан:

- Баруун бүсэд: Бэлчээрийн мал аж ахуй, усалгаатай тариалан, жижиг дунд үйлдвэрлэлийг;
- Хангайн бүсэд: Бэлчээрийн мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, амралт сувилал, жижиг дунд үйлдвэр, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, мод боловсруулах үйлдвэрийг;
- Төвийн бүсэд: Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, аялал жуулчлал, амралт сувилалын үйлчилгээ, оюуны багтаамж ихтэй бусад үйлдвэр үйлчилгээ,
- Зүүн бүсэд: Уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, эрчимжсэн газар тариалан, мал аж ахуй, жижиг дунд үйлдвэр, аялал жуулчлалыг;
- Улаанбаатарын бүсэд: Оюуны багтаамж ихтэй бүх төрлийн үйлдвэр, үйлчилгээ, олон улсын банк санхүүгийн сүлжээг тус тус тэргүүлэх болон хөгжүүлэх юм.

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги



Зураг 24. Монгол улсын эдийн засгийн муж /2001/

Төвийн бүс нутаг бүрэлдэх гол хүчин зүйл бол улсын төв болсон Улаанбаатар хот болон Европ, Азийг холбосон олон улсын төмөр зам, төвийн эрчим хүчний системийн цахилгаан дамжуулах шугам, авто замын үндсэн сүлжээ, төмөр замын дагуу байрлаж буй хотууд, тэдгээрийн нийгмийн болон инженерийн дэд бүтэц, эдийн засгийн чадавхи нэгэн адил бүс нутаг бүрэлдэн тогтоход голлон нөлөөлж байна.

Сүүлийн жилүүдэд бүс нутгийн хөгжлийн дэлхийн нийтийн хандлага нь “функциональ бүс нутгууд”-ыг тодорхойлох буюу бүс нутгийн хөгжлийн чиглэл, нийгэм эдийн засагт гүйцэтгэх үүргийг тодорхойлоход чиглэгдэж байна. Үүнийг: “газар нутгийн функциональ нэгдмэл болон харилцан хамааралтай байдлыг хангасан, тухайн улсынхаа нөхцөл байдалд нийцсэн шалгууруудыг баримтласан газарзүйн нутаг дэвсгэр” гэж ойлгож болно.

Манай улсын хувьд бүс нутгийн бодлого, чиг үүрэг, хөгжлийн асуудал болон эдгээр бодлогыг хэрэгжүүлэх арга зам, чиг хандлагын асуудал нэн чухлаар тавигдаж байна. Дөрвөн том, түүнчлэн Улаанбаатар бүс нутгуудыг тогтоосон байдал нь бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, стратегийн гол зарчмын байр суурийг илэрхийлдэг боловч ямар шалгуураар эдгээр бүс нутгуудыг тогтоосон нь зарим талаар “тодорхой бүс” гэж дүгнэхээр байна.

Манай улс бүс нутгуудыг ерөнхий 5 хэсэгт хуваан тогтоосон нь Д.Базаргүр (2003) зэрэг эрдэмтдийн дурьдснаар “байгаа дэд бүтэц, үйлдвэржилтийн түвшин, зах зээлийн эрэлт хэрэгцээ, нийлүүлэлтийн хүчин зүйлд тулгуурлах” аргаар бус харин захиргааны аргаар тодорхойлсон нь асуудалтай юм.

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

“Бүс нутаг дахь хот, хөдөөгийн ялгааг багасгах таатай орчинг бүрдүүлэх, байгалийн баялаг, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын нөөц бололцоог тухайн бүс нутгийн онцлог давуу тал, чадавхитай нь уялдуулан дээд зэргээр үр ашигтай ашиглах, үүний үр дүнд хүн амын хэт их төвлөрлийг багасгах, эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, нийгмийн дэвшлийг дэмжих” нь бүс нутгийн хөгжлийн гол зорилго болдог гэдгийг олон улсын туршлага харуулж байна.

Төвийн бүс нутгийн бүрэлдэн тогтох үйл явц бусад бүс нутгийнхаас өвөрмөц онцлогтойн дээр Монгол орны хувьд эзлэх байр сууриар ихээхэн ялгаатай.

Байгаль газарзүйн олон төрөл байдал, өргөн уудам талбайг хамарсан, нийгмийн болон дэд бүтцийн хөгжлийн ихээхэн зөрүүтэй түвшин зэрэг нь тус бүс нутгийг тэнцвэртэй хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд ихээхэн бэрхшээл учруулах бөгөөд юуны өмнө орон нутгийн тулгуур төвүүдийг оновчтой тогтоох, хөгжлийн үндсэн тэнхлэгийг зөв тодорхойлсноор эл байдлыг гэтлэх эхний алхмуудыг шийдвэрлэх боломжтой болох юм.

Монгол орны хөгжлийн өнөөгийн нөхцөл байдлыг Төвийн бүс нутгийн хүрээнд бодитойгоор үнэлэн дүгнэх нь төлөвлөлтийн цаашдын хувь заяаг шийдвэрлэх зүг чиг болох билээ.

Зах зээлийн харилцаанд нийцүүлж улс орон бүс нутгаар цаашид хөгжихөд олон жилийн турш мөрдөж ирсэн хуучин тогтолцооны үеийн хэв загварт тохирсон засаг захиргааны хуваарь багагүй саад бэрхшээл болж байгаа учир төрөөс дорвитой зоримог өөрчлөлт хийснээр орон нутагт хөгжлийн тэнцвэрт байдлыг бий болгох үндсийг тавьж болно.

Ялангуяа Төвийн бүс нутгийн хувьд зэргэлдээ аймаг, сумдын хил хязгаарын ойролцоо ашигт малтмалын орд газрын байрлалыг түшиглэн нийгмийн болон дэд бүтцийн хөгжлөөрөө харьцангуй хүчирхэг үйлдвэрийн төвүүд бий болсон нь засаг захиргааны хил хязгаарыг үл харгалзсан нутагшил суурьшлыг үүсгэж байна.

Монгол орны нийт 2000 орчим км төмөр замын 90 орчим хувь нь энэ бүс нутгийг босоо чиглэлээр дайран өнгөрдөг бөгөөд тэдгээрийн дагуу Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг том хот, Зүүнхараа, Түнхэл, Дулаанхаан, Багахангай, Чойр, Сайншанд зэрэг томоохон суурин газрууд, олон арван жижиг суурингууд оршиж, тэдгээрт нийтдээ Монголын хүн амын 60 орчим хувь суурьшин амьдарч байгаа нь тус орны хүн амын төвлөрлийн цөм болж байна.

Эрдэнэт, Хөтөл, Зүүнхараа, Налайх, Багануур, Чойр, Бор-Өндөр зэрэг үйлдвэрийн томоохон төвүүд нь аймаг орон нутгийн хил хязгаарын заагт буюу ойролцоо байрлан хөгжиж ирснээр хөгжлийн явцад өөрийн ойр орчмын төв суурин орон нутгийг өөртөө татаж, улмаар өөрийн гэсэн бүлэг суурингийн тогтолцоог засаг захиргааны хуваарийг үл харгалзан бүрдүүлж байгааг нутагшилт, хот байгуулалтын

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

хэтийн бодлогод зайлшгүй тусгаж, улс орон бүс нутгаар хөгжих өнөөгийн чиг хандлагатай сайтар зохицуулах нь онцгой чухал ач холбогдолтой нь бидний явуулсан судалгааны явцад орон нутгийн иргэд, удирдлагын санал байдлаар илэрч байсан.

Олон арван жил аймгийн төвийн үүрэг гүйцэтгэж ирсэн хотууд маань өнөөдөр хөгжлийн хувьд зогсонги, бие биенээсээ ялгарах өөрийн онцлог төрхгүй, нэг хэв загварт хэт төлөвлөгдөн, барилгажиж, хүн ам ая тухтай амьдрах нөхцөл бололцоо төдийлөн хангагдаагүй зэрэг нь тухайн орон нутгийг өөртөө татах бүс нутгийн тогтолцоог бүрдүүлж чадаагүй юм.


Үүнтэй уялдан орон нутгийн төвүүд өөр хоорондоо харилцан уялдаатай хөгжих орчин нөхцөл бүрдээгүй, мөн төв суурингуудын барилгажилт хэт нэг маягжсан, тухайн үеийн ерөнхий төлөвлөгөөнүүд хөрөнгө оруулалттайгаа уялдаагүйгээс хэрэгжилт нэн сул зэрэг нь тухайн орон нутагт хөгжлийн тэргүүлэх чиглэлийг саатуулах үндсэн шалтгаан болсон бөгөөд орон нутаг хуучин шигээ дангаар амиа аргацаасан байдлаар хөгжих энэ чиг хандлага өнөөгийн хөгжлийн зүй тогтолтой огтхон ч нийцэхгүй байгаа нь энэ бүс нутагт хийсэн судалгаанаас харагдаж байна.

1996 онд Монгол улсын Их хуралд өргөн барьсан хүн амын нутагшилт, хөгжлийн ерөнхий төслөөр дэвшүүлэн тавигдсан бүс нутгийн төлөвлөлт, зохион байгуулалт, хөгжлийн тулгуур гол төвүүд, дэд бүтцийн үндсэн тэнхлэгүүдийг зураг төслийн үе шатны хувьд улам нарийвчлан боловсронгуй болгох, ерөнхий төслийн үзэл баримтлал, төлөвлөлтийн үндсэн зарчмыг алдагдуулалгүй байх нь энэ бүс нутгийг хөгжүүлэх төслийг боловсруулахад баримталсан гол чиг шугам юм.

Төвийн бүс нутаг нь улс орны нэгэн адил одоогийн засаг захиргааны хуваариар хөгжихгүй нь тодорхой бөгөөд аймаг, сумуудыг олшруулах бус харин бүтцийн хувьд зарчмын чанартай өөрчлөлт хийж, аймаг сумдыг томсгох чиглэлээр хөгжүүлэх хандлага сүүлийн үеийн судалгаануудад ажиглагдах боллоо.

Төвийн бүс нутгийн хилийг Монгол улсын хүн амын нутагшилт, хөгжлийн ерөнхий төсөлд дэвшүүлсэн үндсэн хувилбараар авч дотор нь байгаль-цаг уур, эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжил, үйлдвэрлэл, технологи, хөдөлмөр, санхүү, материал, түүхий эдийн уялдаа холбоонд тулгуурлан бүс нутгийн “макро” түвшингийн хүрээнд **Дархан-Сэлэнгийн дэд бүс нутаг, Улаанбаатарын бүс, Говийн дэд бүс** гэсэн албан бус дэд бүсүүд үүссэн байна.

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги



Зураг 25. Төв бүсийн эдийн засгийн оронзайн таталцал

Бүсчлэн хөгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүднээс дээр дурьдсан аймгийн төвүүд төдийгүй шилжилтийн үед байгуулагдсан Дархан-Уул, Орхон,

Говьсүмбэр зэрэг шинэ аймгуудыг улсын нийгэм-эдийн засгийн чиглэлд зохицуулах шаардлага зайлшгүй гарна.

Хөгжлийн тулгуур төвүүд нь бүс нутгийнхаа хойд хэсэгт багавтар хэмжээний орон нутгийг хамарч, нилээд нягтралтай оршдог нь тухайн орон нутагт эерэг нөхцлийг бүрдүүлэх боловч Төвийн бүс нутгийг нийтэд нь тэнцвэртэй буюу өөрөөр хэлбэл бүс нутгийн өмнөд хэсгийн хөгжлийг тэнцвэржүүлэх (Богдхан уул, Туул голоос урагш) шаардлагатай юм. Сүүлийн үеийн уул уурхайн хөгжил, Таван толгой (Ухаа худаг), Оюу толгойн томоохон уул уурхайн төслүүд, засгийн газраас говийн бүсийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй ажлууд нь төвийн бүсийн инженерийн болон нийгмийн дэд бүтцийн сүлжээг нэмэгдүүлж нийт Төвийн бүсийн хэмжээнд хөгжлийн тэнцвэржилт үүсэж буй нь нэн тэргүүнд хөгжүүлэх хот суурингуудын хөгжлийн хэтийн хандлага, үндсэн чиг үүргийг тодорхойлох шаардлагыг бий болгож байна.

Тухайлбал, Говь нутгийг харьцангуй хурдтай хөгжүүлэх асуудлыг дэд бүтцийг эрчимжүүлэн Тавантолгойн хүрэн нүүрс, Хараатын ураны орд, Цагаансуваргын зэсийг ашиглах, мал аж ахуйн ашигт чанарыг дээшлүүлэх замаар шийдвэрлэж болох юм.

Төлөвлөлт, зохион байгуулалтын бүтцийн хувьд Төвийн бүс нутгийн хөгжлийн тулгуур төв болон бүс нутгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах өөрийн нөлөөлөл бүхий орон зай-газар орныг зөв тодорхойлох нь чухал юм.

Монгол улсын нутагшилт, хөгжлийн ерөнхий төслөөр тогтоогдсон бүс нутгийн хөгжлийн тулгуур төвүүдийг нутагшилт, хот байгуулалтын үүднээс төв суурингуудын хоорондын харилцан уялдаа, үйлчилгээний төрөл байдал, орон зай зохион байгуулалтыг харгалзан, хэд хэдэн шатлалтайгаар авч үзэж болно.

4.4 Төвийн бүсийн хот суурингийн ангилал

Манай улсын хот суурингуудын үндсэн ангилалыг, хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлдхот, тосгон нь:

1. Хот нь 15000-аас доошгүй оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх хувь нь голлон үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжсөн, өөрийн удирдлага бүхий төвлөрсөн суурин газар мөн.
2. Тосгон нь 500-15000 оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газар мөн.
3. Улсын болон тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг нь харгалзан шаардлагатай гэж үзвэл тосгоныг хотод тооцох асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

4 дүгээр зүйлд хотын зэрэглэл нь:

1. Хот нь оршин суугчдын тоо, хот бүрдүүлэгч дэд бүтцийн хөгжлийн түвшин, улсын болон тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүргээс хамааран улсын буюу аймгийн зэрэглэлтэй байна.
2. 50000-аас дээш /шаардлагатай гэж үзвэл 50000 хүртэл/ оршин суугчтай хотод улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэж байгаа үүрэг, хотжилт, хот бүрдүүлэгч дэд бүтцийн хөгжлийн түвшинг харгалзан улсын зэрэглэл тогтоож болно.
3. Хотод улсын зэрэглэл тогтоох асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал, аймгийн зэрэглэл тогтоох асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өргөн мэдүүлснээр Засгийн газар тус тус шийдвэрлэнэ.

Дээрх хуульд хот суурины зэрэглэлийг оршин суугчдын тоонд тулгуурлах замаар тогтоосон байна. Энэ нь нэг талаас хот тосгоныг ангилах энгийн арга мэт боловч бодит амьдрал дээр хот тосгоныг ангилах, тэр тусмаа чиг үүргийг нь харгалзан ангилах тал дээр учир дутагдалтай юм. Учир нь аливаа хот суурины оршин суугчдын ажил эрхлэлтийн байдал, тухайн хот сууринд оруулж буй хөрөнгө оруулалтын хэмжээ (аль салбарт илүү хөрөнгө оруулалт орж байна), мөн нэг хүнд ноогдох зай талбайн, нийгмийн болон инженерийн дэд бүтэц зэрэг чухал хүчин зүйлүүдийг орхигдуулсан бөгөөд энэ нь хот суурины зэрэглэл, ангилалыг жинхэнэ утгаар нь тогтооход дан ганц хүн амын тоог харгалзсан нь өрөөсгөл болсон ажээ. Эрдэмтэн М.Баянтөр (2003)-ийн бүтээлд хот сууринг ажил эрхлэгчдийн эзлэх хувийн жингээр үүргийг тодорхойлсон нь дээрх ангилалаас харьцангуй дэвшилтэт болжээ. Үүнд:

1. Олон үүрэгтэй
2. Засаг захиргаа-үйлдвэрлэл-үйлчилгээ давамгайлсан
3. Засаг захиргаа – үйлчилгээний үүрэг давамгайлсан
4. Үйлдвэрлэл-үйлчилгээний үүрэг давамгайлсан
5. Үйлчилгээ- засаг захиргааны үүрэг давамгайлсан
6. Засаг захиргаа- хөдөө аж ахуй-үйлчилгээний үүрэг давамгайлсан (энэ ангилал тосгон сууринд хэрэглэгдэнэ)
7. Тээврийн транзит үүрэг давамгайлсан (энэ ангилал тосгон сууринд хэрэглэгдэнэ)
8. Амралт сувилал, аялал жуулчлалын үүрэг давамгайлсан (энэ ангилал тосгон сууринд хэрэглэгдэнэ)

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

Хүснэгт 26. Дээрх ангилалын хүрээнд төвийн бүсийн зарим томоохон хот, суурингуудыг авч үзвэл 2010 оны байдлаар

		Хот	Хүн ам
1	Олон үүрэгтэй хот	Улаанбаатар	1240037
2	Засаг захиргаа-үйлдвэрлэл-үйлчилгээ давамгайлсан хот	Дархан	94625
3	Засаг захиргаа – үйлчилгээний үүрэг давамгайлсан хот	Сайншанд	21147
		Мандалговь	13365
		Даланзадгад	15176
		Зуунмод	14830
4	Үйлдвэрлэл-үйлчилгээний давамгайлсан хот үүрэг	Налайх	28152
		Багануур	25969
		Зүүнхараа	23154
		Хөтөл	6071
		Бор-Өндөр	8491
5	Үйлчилгээ- засаг захиргааны давамгайлсан хот үүрэг	Чойр	9694

Эндүүг агаартай илүүдэл дараах үйлдвэрлэл, үйлчилгээний төв бүсийн төв бүс болон хот, суурины хөгжлийн стратеги дээрх ангилалын хүрээнд төвийн бүсийн зарим томоохон хот, суурингуудыг авч үзвэл 2010 оны байдлаар

Төвийн бүс нь төв бүсийн төв бүс болон хот, суурины хөгжлийн стратеги дээрх ангилалын хүрээнд төвийн бүсийн зарим томоохон хот, суурингуудыг авч үзвэл 2010 оны байдлаар

Төв бүсийн төв бүс болон хот, суурины хөгжлийн стратеги дээрх ангилалын хүрээнд төвийн бүсийн зарим томоохон хот, суурингуудыг авч үзвэл 2010 оны байдлаар

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

Хүснэгт 27. Төвийн бүс дэх томоохон хот, суурины үүрэг, хөгжлийн чиг хандлага

	Хот суурин	Үүрэг	
		Одоо	Хэтийн чиг хандлага
1	Улаанбаатар	Улсын нийслэл, хөгжлийн цөм	Улсын нийслэл, хөгжлийн цөм
2	Дархан	Суурьшил, хүнд аж үйлдвэр, хөнгөн үйлдвэр	Суурьшил, хүнд аж үйлдвэр, химийн үйлдвэр, агуулах
3	Сайншанд	Аймгийн төв, суурьшил, ХАА-н үйлдвэрлэл	Аймгийн төв, суурьшил, ХАА-н үйлдвэрлэл, аж үйлдвэрийн парк
4	Мандалговь	Аймгийн төв, суурьшил, ХАА-н үйлдвэрлэл	Аймгийн төв, суурьшил, ХАА-н үйлдвэрлэл
5	Даланзадгад	Аймгийн төв, суурьшил, ХАА-н үйлдвэрлэл	Аймгийн төв, суурьшил, ХАА-н үйлдвэрлэл, уул уурхай, аялал жуулчлал
6	Зүүнхараа (Мандал)	Сумын төв, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, уул уурхай	Сумын төв, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, эрчимжсэн МАА, туслах аж ахуй, уул уурхай
7	Хөтөл	Суурьшил, барилгын материалын үйлдвэрлэл, (Өртөө)	Суурьшил, барилгын материалын үйлдвэрлэл, эрчимжсэн мал аж ахуй, туслах аж ахуй, хүлэмжийн аж ахуй, амралт сувилал
8	Чойр	Аймгийн төв, суурьшил, МАА	Аймгийн төв, суурьшил, МАА, нефть боловсруулах үйлдвэр, агуулах
9	Бор-Өндөр	Суурьшил, уул уурхай, МАА	Суурьшил, уул уурхай, МАА, Хөнгөн үйлдвэрлэл, засаг захиргааны төв
10	Налайх	Үйлдвэрлэл, нүүрсний уурхай, засаг захиргааны төв, суурьшлын бүс	Үйлдвэр, уурхай, агуулах, засаг захиргаа, гэр хороолол, оюутаны хотхон
11	Багануур	Үйлдвэрлэлийн томоохон төв, суурьшлын бүс, тусгай зориулалтын бүс, засаг захиргааны төв	Уул уурхай, үйлдвэрлэл, аялал жуулчлал, оюутны хотхон
12	Багахангай	Засаг захиргааны төв, мах боловсруулах, хоёрдогч түүхий эд боловсруулах үйлдвэр,	Мах боловсруулах үйлдвэр, засаг захиргаа, хоёрдогч түүхий эд боловсруулах чиглэл бүхий хот, оюутны хотхон
13	Зуунмод	Засаг захиргааны төв, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	Засаг захиргааны төв, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, оюутны хотхон
14	Сүхбаатар	Аймгийн төв, хүнсний үйлдвэр, суурьшил	Аймгийн төв, хүнсний үйлдвэр, суурьшил, агуулах
15	Алтанбулаг	Худалдааны чөлөөт бүс, сумын төв,	Худалдааны чөлөөт бүс, сумын

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

		гадаад худалдаа, агуулах	төв, гадаад худалдаа, агуулах
16	Замын- Үүд	Худалдааны чөлөөт бүс, сумын төв, гадаад худалдаа, агуулах	Худалдааны чөлөөт бүс, сумын төв, гадаад худалдаа, агуулах

Íëíí àðààí æðë àéíàèéí ò°àèéí ÿÿðÿã ãÿéóÿðãÿæ èðñÿí òíðòóã àààíü °í°ã°ð ò°ãæèèéí òòüü çíàñííàè, áèà áèáíÿñÿÿ ÿèàððàð °°ðèéí ííöèíã ò°ðòãÿé, íÿã òÿã çàãããðð òÿð ò°è°ãè°ãã°í, ààðèèããæèæ, òÿí àì àÿ òòòàé àìüãðàð í°òò°è áíèèöîíí ò°àèèé°í òàíããããããÿé çÿðÿã íü òòòàéí íðíí íòòàèéã °°ðò° òàðàð áÿñ íòòàèéí òíàðíèöîííã áÿðãÿÿæ ÷ããããÿé ðì. Бусад суурингууд ч мөн адил байдалтай байна.

ÿÿðÿé öÿèããí íðíí íòòàèéí ò°ãÿã °°ð òííðííãíí òàðèèöòáí öÿèãããðàé ò°ãæèè ìð÷éí í°òò°è áÿðãÿÿé, ì°í ò°ã òòòèíãòòüí ààðèèããæèèð òÿð íÿã àÿãæñáí, òòòàéí ÿàèéí àð°íòèé ò°è°ãè°ãã°íÿã ò°ð°íã íðòòèèèðòàéããà öÿèããããÿéÿÿñ öÿðÿãæèèð íÿí òöè çÿðÿã íü òòòàéí íðíí íòòàð ò°ãæèèéí öÿðãÿÿéÿð ÷èèÿèèéã òàðòòòèèð ÿíãñÿí òàèòãããí áíèñíí áãã°ã íðíí íòòãã òòò÷éí òèèÿÿ ààíãããð àìèà àðããòããñáí áàéèèããð ò°ãæèèð ÿÿÿ ÷èã òàíãèèããã °í°ãèéí ò°ãæèèéí çÿé òíãòíèðíé íãððíí ÷ íèéóÿðãÿé áàéããã íü ÿÿÿ áÿñ íòòããð òèèñÿí òòãèèãããíãã òàðããããæ áàéíã. Иймээс өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан хот суурингууд засаг захиргааны нэгжид ямар үүрэг гүйцэтгэж буйг дараах хүснэгтээр харуулхыг зорилоо.

Хүснэгт 28. Төвийн бүс дэх хот суурингуудын гүйцэтгэх үүрэг (Засаг захиргааны нэгжээр)

	Хот суурингууд	Улсын түвшинд гүйцэтгэх үүрэг	Бүс нутгийн түвшинд гүйцэтгэх үүрэг	Аймгийн түвшинд гүйцэтгэх үүрэг	Сум, дүүргийн хэмжээнд гүйцэтгэх үүрэг
1	Óèààí áããððð	Засаг захиргааны төв, хөгжлийн тулгуур төв, ази европын холбосон дэд бүтцийн тэнхлэгүүдийн зангилаа	Бүсийн тулгуур төв	Хүчтэй таталцал бүхий хот	Удирдлага, зохион байгуулалт
2	Дархан	Засаг захиргааны төв, хүнд аж үйлдвэр	Дэд бүсийн төв	Хүчтэй таталцал бүхий хот	Соёл боловсрол, зах зээлийн төв
3	Сайншанд	Аймгийн төв	Авто тээврийн зангилаа	Засаг захиргааны төв, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	Удирдлага, зохион байгуулалт
4	Мандалговь	Аймгийн төв	-	Засаг	Удирдлага,

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

				захиргааны төв, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	зохион байгуулалт
5	Даланзадгад	Аймгийн төв	Аялал жуулчлал	Засаг захиргааны төв, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	Удирдлага, зохион байгуулалт
6	Зүүнхараа (Мандал)	Спиртийн үйлдвэр	ХАА-н үйлдвэрлэл, хөнгөн хүнсний үйлдвэр	Засаг захиргааны төв, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	Сүү махны эрчимжсэн мал аж ахуй, туслах аж ахуй, улаан буудайн тариалалт, спиртийн үйлдвэр
7	Хөтөл	Цементийн үйлдвэрлэл	Төмөр замын өртөө	Төмөр замын өртөө, туслах аж ахуй, МАА	Мал аж ахуй, туслах аж ахуй
8	Чойр	Аймгийн төв	-	Засаг захиргааны төв, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	Удирдлага, зохион байгуулалт
9	Бор-Өндөр	Жонш (уул уурхай)	Уул уурхай	Суурьшил, таталцал бүхий хот	Багийн төв, мал аж ахуй, худалдаа, үйлчилгээ, нийгмийн дэд бүтэц
10	ᠶ᠋ᠠᠭᠠᠨ ᠶ᠋ᠢᠨ	Нүүрсний уурхай	Нүүрсний уурхай	Нүүрсний уурхай	Хүнд үйлдвэрлэл, ᠴᠠᠩᠠᠭ ᠴᠠᠳᠤᠳᠠᠭᠠ ᠶ᠋ᠨ ᠣᠶᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠨᠣᠪᠣᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ
11	ᠶ᠋ᠠᠭᠠᠨ ᠶ᠋ᠢᠨ	Нүүрсний уурхай	Нүүрсний уурхай	Нүүрсний уурхай	ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠣᠶᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠨᠣᠪᠣᠳᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ, ᠣᠶᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠴᠢᠳᠤᠳᠠᠭᠠ ᠶ᠋ᠢᠨ
12	ᠶ᠋ᠠᠭᠠᠨ ᠶ᠋ᠢᠨ	-	ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ, ᠣᠶᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ	ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ, ᠣᠶᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ	ᠴᠠᠩᠠᠭ ᠴᠠᠳᠤᠳᠠᠭᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

			ᠠᠶᠢᠨᠢᠮᠤᠨᠲᠥᠪ	ᠠᠶᠢᠨᠢᠮᠤᠨᠲᠥᠪ	ᠤ᠎ᠠᠶᠢᠨᠢᠮᠤᠨᠲᠥᠪ
13	Зуунмод	Аймгийн төв	Аймгийн болон бүсийн тулгуур төв	Засаг захиргааны төв, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	Удирлага, зохион байгуулалт
14	Сүхбаатар	Аймгийн төв	-	Засаг захиргааны төв, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	Удирлага, зохион байгуулалт
15	Алтанбулаг	Чөлөөт бүс	Чөлөөт бүс	Сумын төв, нийгмийн үйлчилгээ	Гадаад, дотоод худалдаа, үйлчилгээ, суурьшил, нийгмийн дэд бүтэц
16	Замын- Үүд	Чөлөөт бүс	Чөлөөт бүс	Сумын төв, нийгмийн үйлчилгээ	Гадаад, дотоод худалдаа, үйлчилгээ, суурьшил, нийгмийн дэд бүтэц

4.4.1 Дархан-сэлэнгийн бүсийн эдийн засгийн болон нийгмийн хөгжлийн түвшний харьцуулсан үнэлгээ

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий үйлдвэрлэл, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, эдийн засгийн салбарын бүтцийн болон ХАА, аж үйлдвэр, дэд бүтцийн хөгжлийн түвшингийн үзүүлэлтүүдийг манай улсын бусад аймгуудын эдгээр үзүүлэлтүүдтэй харьцуулах замаар Дархан-Сэлэнгийн бүсийн эдийн засгийн хөгжлийн түвшинг тодорхойлов. Үүнд:

Дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн харьцуулсан үнэлгээ. Дархан-Сэлэнгийн бүс нь 2010 оны байдлаар Монгол Улсын ДНБ-ний 5.8 хувийг, Төвийн бүсийн ДНБ-ний 47.3 хувийг үйлдвэрлэж байна (График 20).

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги




График 20. Төвийн бүсийн ДНБ-ий бүтэц, аймгаар

Баруун болон Зүүн бүсийн зарим аймгуудынхтай харьцуулбал Дархан-Сэлэнгийн бүсийн ДНБ-ий үйлдвэрлэлийн эзлэх хувь өндөр байгаа юм. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн ДНБ-ий үйлдвэрлэл Ховд, Сүхбаатар, Завхан аймгуудаас 1.9 дахин өндөр байгаа бол Дархан-Уул 1.2 дахин өндөр байгаа юм. Гэхдээ Сэлэнгэ, Дархан Уул аймгийн ДНБ-ий хэмжээ нийлээд Орхон аймгийнхаас 2,4, Улаанбаатрынхаас 8,8 дахин доогуур байгаа юм.




График 21. Нэг хүнд ногдох ДНБ, оны үнээр

Дархан, Сэлэнгийн бүсийн эдийн засгийн салбарын бүтцийн харьцуулсан үнэлгээг бас хийсэн болно. ДНБ-нд салбаруудын эзлэх хувийг авч үзвэл Дархан уул аймагт 2008 оны байдлаар хөдөө аж ахуй 14,9 хувийг, аж үйлдвэр, барилга -51.7 хувийг, үйлчилгээний салбар 33.5 хувийг тус тус эзэлж байсан бол 2010 онд хөдөө аж ахуй 17.4, аж үйлдвэр, барилга 44.1, үйлчилгээний салбар 38.5 хувийг эзлэлж аж үйлдвэр, барилгын салбарын эзлэх хувийн жин буурсан байна (График 22).

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги



График 22. Дархан-Уул аймгийн ДНБ-ий бүтэц, хувиар

Дархан Уул аймгийн ДНБ-ний салбарын бүтцийг улсын дүнтэй болон Баруун бүс, бусад аймгуудтай харьцуулбал эдийн засгийн салбарын бүтэц үйлдвэр, үйлчилгээний салбар түлхүү хөгжсөн нь харагдаж байна.

Сэлэнгэ аймгийн хувьд 2008 оны байдлаар хөдөө аж ахуй 44,5 хувийг, аж үйлдвэр, барилга 22.8 хувийг, үйлчилгээний салбар 22.7 хувийг тус тус эзлэж байсан бол 2008 онд хөдөө аж ахуй 37.1, аж үйлдвэр, барилга 48.1, үйлчилгээний салбар 14.7 хувийг эзэлж аж үйлдвэр, барилгын салбарын эзлэх хувийн жин нилээдгүй өссөн байна. Харин хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарын эзлэх хувийн жин буурсан байна (График 23).




График 23. Сэлэнгэ аймгийн ДНБ-ий бүтэц, хувиар

Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн ДНБ-д аж үйлдвэр, барилгын салбарын эзлэх хувийг бусад аймгууд болон бүсүүдтэй харьцуулбал Хангайн бүс болон Өмнөговь аймгаас доогуур бусад аймгууд болон бүсийн эзлэх хувиас дээгүүр байна (График 24).

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги




График 24. ДНБ-нд аж үйлдвэр, барилгын салбарын эзлэх хувь, 2010 он

Сэлэнгэ аймгийн ДНБ-д үйлчилгээний салбарын эзлэх хувийг бусад аймгуудтай харьцуулбал Улаанбаатараас 3.6, Дархан-Уул аймгаас 2.6, Дорноговь аймгаас 2.2 дахин бага байна (График 25).




График 25. ДНБ-нд үйлчилгээний салбарын эзлэх хувь, 2010 он

Дээр ДНБ-ий салбарын үзүүлэлтүүдээс дүгнэж үзэхэд Дархан уул, Сэлэнгэ аймагт аж үйлдвэр, барилгын салбар бусад салбаруудаасаа арай түлхүү хөгжсөн нь харагдаж байна.

Эдийн засгийн хөгжлийн түвшин аймгийн татварын орлого болон аймгийн төсөвт улсын олгох татаасаас ихээхэн шалтгаалж байдаг. Дархан-уул аймгийн төсвийн орлого 2010 онд 7576.7 сая.төг болж өмнөх оноосоо 10.6 хувиар, төсвийн зарлага 4126.3 сая.төг болж өмнөх оноосоо 27.7 хувиар нэмэгдсэн бөгөөд улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг 597.0 сая.төг болсон байна.

Дархан-Сэлэнгийн бүсийн суурь дэд бүтцийг хөгжүүлэх

Зам тээвэр

- ❖ Сүхбаатар, Зүүнхараагийн төмөр замын вокзалын хүчин чадлыг нэмэгдүүлэх
- ❖ Хот, суурин хоорондын замыг сайжруулж, зам дагуух суурингуудыг эрчимтэй хөгжүүлэх

Цахилгаан, эрчим хүч

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

- ❖ Нар, салхины сэргээгдэх эрчим хүч, бусад дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар сум, суурингуудыг, цахилгаанаар бүрэн хангах .
- ❖ Дархан-Уул аймгийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх

Усан хангамж

- ❖ Олон улсын хилийн усны гэрээний дагуу хил дамжсан усны бохирдолтыг хамтран хянах, мэдээллийг шуурхай солилцох талаар ОХУ-ын зэргэлдээх аймаг хотуудтай хамтран ажиллах
- ❖ Хараа, Ерөө, Орхон, Сэлэнгэ мөрний усны нөөцөд түшиглэн, экологид халгүйгүл усалалтын систем барих, шинэчлэх замаар усалгаатай газар тариаланг хөгжүүлэх
- ❖ Орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан хур тунадас, үерийн усыг хуримтлуулж газар тариаланд ашиглах төслийг төр хувийн хэвшлийн түшлэлийн зарчмаар хэрэгжүүлэх

Холбоо, мэдээлэл

- ❖ Аймаг, сумдын төвд мэдээлэл холбооны технологийн шинэ төрлийн үйлчилгээг, тухайлбал алсын зайн сургалт, теле-эмчилгээний өндөр хурдны үйлчилгээг тууштай нэвтрүүлэх
- ❖ Бүх суурингуудад өндөр хурдны шилэн кабель,интернэтийн үйлчилгээг жигд нэвтрүүлэх

Аж үйлдвэрийг хөгжүүлэх, тэдгээрийн дэд бүтцийг хөгжүүлэх

- Төвийн бүсийн тулгуур төв Дархан хотыг Үйлдвэрлэлийн жишиг хот болгон хөгжүүлэх /Үйлдвэр технологийн парк байгуулах/ ажлыг эрчимжүүлэх, үүн дээр тулгуурлан бүсийн төвийг байгуулах
- Онцгой техник технологи бүхий үйлдвэрүүдийг тусгайлан дэмжих
- Эрчимжсэн газар тариалан ба ургамлын аж ахуй, мал аж ахуйг хөгжүүлэх
- Алтанбулагийн чөлөөт бүсийг хөгжүүлэх ажлыг эрчимжүүлэх
- Жуулчны бааз, амралт сувиллын газруудын материаллаг баазыг сайжруулж, аялал жуулчлалын үйлчилгээг өргөтгөх;
- Хөдөө аж ахуйд усалгаатай газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйд суурилсан фермерийн аж ахуйг хөгжүүлэх;
- Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- МАА, газар тариалангийн түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж экологийн цэвэр бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх
- Усалгаатай тариалангийн үйлдвэрлэлийг эрчимтэй нэмэгдүүлэх
- Мал аж ахуйг эрчимжүүлэх замаар малын тоо толгойг тогтвортой хэмжээнд барьж ашиг шим өндөртэй сайн үүлдрийн болон нутгийн шилмэл малыг тэжээл үйлдвэрлэлтэй хослуулан түлхүү хөгжүүлж, суурин ба хагас суурин хэлбэрээр мал аж ахуйг төрөлжүүлэн тэжээлийн үйлдвэрлэлтэй нь хамтатган хөгжүүлэх. Бэлчээрийн ургац, тэжээлийн нөөцийн хэмжээнд тохирсон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх орчинг бий болгох
- Арьсыг дээлийн нэхий, үслэг эдлэлийн нэхий бэлтгэх стандартад нийцүүлэн

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

бэлтгэх нөхцлийг бүрдүүлэх, одоо байгаа үйлдвэрүүддээ сайн чанарын ихээхэн түүхий эд нийлүүлэх

- Махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр хэрэгцээнийхээ 80 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний 70 хувь, гурил гурилан бүтээгдэхүүний 60 хувийг хангах

Эдийн засгийн өндөр ач холбогдолтой ашигт малтмалын олборлох болон боловсруулах үйлдвэрүүдийг Ерөө ба Сэлэнгэ, Хараа-Орхоны бүсэд байгуулах

- Төмөртэй, Баянгол, Гачуурт, Улаан-Овоогийн эрдэс баялагийн стратегийн орд газруудыг ашиглалтанд оруулах
- Апт олборлох бичил уурхайг нэн тодорхой бодлого, зохицуулалт, хөдөлмөр хамгааллын хяналтан дор байгуулж ажиллуулах замаар хөдөөгийн ядуурлыг арилгах
- Эдэлбэр газрын экологи-эдийн засгийн үнэлгээг хөрсний үржил шим, бүтэцтэй нь уялдуулан хийж, экологийн хохирлын төлбөр, нөхөн төлбөр, хураамжийг газрын ренгийн ялгавраар тооцох, хариуцуулах, төлүүлэх орон нутгийн онцлогийг тусгасан механизмыг бий болгох

Боловсруулах аж үйлдвэрийг бий болгож өндөр технологийг нэвтрүүлэн дотоодын зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ.

- Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийг эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд чиглүүлж хөгжүүлэх, одоо байгаа үйлдвэрээ илүү түлхүү хөгжүүлэх
- Хүн, малын өвчин эмгэгийг оношлох чадавхи бий болгож, сэргийлэх эм, бэлдмэлийг орон нутагтаа үйлдвэрлэж бусад аймаг сумдад нийлүүлэх
- Мал аж ахуй, газар тариалангийн түүхий эдийг өндөр технологи хэрэглэн бүрэн боловсруулж, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоодын зах зээлд өрсөлдөх
- Байгаль орчинд сөрөг нөлөөгүй, шинэ дэвшилтэт техник, технологи бүхий “Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр”, “Арьс шир боловсруулах үйлдвэр”, “Мод боловсруулах үйлдвэр”-ийг байгуулах

Эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хүрээнд мэргэжилтэй ажилчин бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх

Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн нэг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх

- Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар, Зүүнбүрэн, Цагаан-нуур, Баруунбүрэн сумдыг түүх, соёлын, Ерөө, Хүдэр, Жавхлант, Түшиг сумдыг ан агнуур, Сант, Орхон, Хушаат, Сайхан сумдыг байгалын үзэсгэлэнт газрын,- Мандал, Баянгол, Орхонтуул сумдыг өвлийн спортын аялал жуулчлалын чиглэлээр тус тус төрөлжүүлэн хөгжүүлэх
- Орхон Сэлэнгийн бэлчир орчим өвлийн спортын төв, Асмалжин, Ерөөгийн

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

халуун рашааныг түшиглэсэн жилийн турш жуулчин хүлээн авах бололцоотой амралт, сувиллын газруудыг байгуулж ажиллуулах

Хот, суурины инженерийн дэд бүтэц болон нийгмийн суурь үйлчилгээг хөгжүүлэх


- Түлшний мод хэрэглэхийг багасган байгалийн хий болон бусад төрлийн түлш Гэр хорооллыг цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбож, оршин суугчдын орон сууцны нөхцлийг сайжруулах
- Сүхбаатар-Алтанбулагийн Эдийн засаг, худалдааны чөлөөт бүсийг түшиглэн орчин үеийн хот бий болгох
- Хот суурин газарт газар эзэмшигчдийн эзэмшил газрын 10%-иас доошгүйг ногоон байгууламжтай болгох арга хэмжээг газар эзэмших гэрээнд тусгах

Байгаль орчин


- Зүүнхараа, Хөтөл, Сүхбаатар хотууд, уул уурхайн томоохон үйлдвэр бүхий сумдын орчны бохирдлыг бууруулах эрх зүй, эдийн засаг, удирдлага зохион байгуулалтын нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх
- Хог хаягдал ялган боловсруулах бага оврын үйлдвэр бүсийн төвдүүдэд байгуулах
- Бүсийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах.
- Элэгдэл, эвдрэлд орсон тариалангийн талбай болон атаржсан газрыг нэрвэгдэлтийн зэргээр нь ялгаварлан тогтоож, шатлан сайжруулж, хөрсжүүлэх, олон наст тариалах төлөвлөгөөг бүс, сум, газар эзэмшигч байгууллага, иргэдийн хүчээр хийлгэж тогтмолжуулах.
- Тариалангийн газрын хөрсийг салхины элэгдэл, эвдрэлээс хамгаалж зурваслан тариалалтыг нийт эргэлтийн талбайн 70%-д хүртэл хамруулах.
- Эрдэсжилт ендер болон хатуулаг ихтэй усны чанарт хяналт— шинжилгээ хийх, ус цэвэршүүлэх тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах
- Хөдөө орон нутагт гүний худгийг сэргээн засварлаж, дундын эзэмшлийн гэрээ байгуулах замаар эзэнтэй болгож, хүн амын цэвэр усны хүртээмжийг сайжруулах
- Ойн санд шинээр сансрын мэдээ ашиглаж зайнаас тандан судлах аргаар хайгуул, судалгаа хийж тархалт, бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоон ойн зураглал, ойн тогтвортой менежментийн хөтөлбөр боловсруулж, газар зүйн мэдээллийн системд суурилсан ойн мэдээллийн сан байгуулах
- Ойн экологийн тэнцвэрт байдал, нөхөн ургах нөхцөлд сөрөг нөлөө үзүүлэхгүй мод бэлтгэлийн шинэ технологийг ой, ургамалжилтын онцлогт тохируулан боловсруулж нэвтрүүлэх
- Элсний нүүлт, цөлжилтийг сааруулах, гол, горхи, булаг шандны эхийг хамгаалах, төв, суурин газрын орчны бохирдлыг бууруулах зорилгоор ойжуулах ажлыг эрчимжүүлэх

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

- Түлшний мод хэрэглэхийг багасган байгалийн хий болон бусад төрлийн түлш хэрэглэх, барилга, модон эдлэлийн үйлдвэрлэлд өөр төрлийн материал орлуулан ашиглахад чиглэсэн дэвшилтэт технологийг дэмжих
- Тужийн нарсан ойг сэргээж, байгаль, аялал жуулчлалд түлхүү нэмэр оруулах зэрэг олон олон санал, зөвлөмж, гарах үр дүн, ач холбогдол бий болж байна.



Зураг 26. "Хөгжлийн ПИРАМИД"



Зураг 27. "Хөгжлийн ПИРАМИД"

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

Хүснэгт 29. Дархан-Сэлэнгийн дэд бүс дэх хот, суурингуудын үүрэг, хөгжлийн чиг хандлага

№	Хот суурин	Үүрэг	
		Одоогийн чигхандлага	Хэтийн чиг хандлага
1.	Дархан	Суурьшил, хүнд аж үйлдвэр, хөнгөн үйлдвэр	Суурьшил, хүнд аж үйлдвэр, химийн үйлдвэр, агуулах
2.	Зүүнхараа (Мандал)	Сумын төв, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, уул уурхай	Сумын төв, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, эрчимжсэн МАА, туслах аж ахуй, уул уурхай
3.	Хөтөл	Суурьшил, барилгын материалын үйлдвэрлэл, (Өртөө)	Суурьшил, барилгын материалын үйлдвэрлэл, эрчимжсэн мал аж ахуй, туслах аж ахуй, хүлэмжийн аж ахуй, тариалалт, спиртийн
4.	Сүхбаатар	Аймгийн төв, хүнсний үйлдвэр, суурьшил	Аймгийн төв, хүнсний үйлдвэр, суурьшил, агуулах
5.	Алтанбулаг	Худалдааны чөлөөт бүс, сумын төв, гадаад худалдаа, агуулах	Худалдааны чөлөөт бүс, сумын төв, гадаад худалдаа, агуулах

Хүснэгт 30. Дэд бүс дэх хот суурингууд гүйцэтгэх үүрэг (засаг захиргааны нэгжээр)

№	Хот суурингууд	Улсын түвшинд гүйцэтгэх үүрэг	Бүсийн түвшинд гүйцэтгэх үүрэг	Аймгийн түвшинд гүйцэтгэх үүрэг	Сум, дүүргийн хэмжээнд гүйцэтгэх үүрэг
1.	Дархан	Засаг захиргааны төв, хүнд аж үйлдвэр	Дэд бүсийн төв	Хүчтэй таталцал бүхий хот	Соёл боловсрол, зах зээлийн төв
2.	Зүүнхараа (Мандал)	Спиртийн үйлдвэр	ХАА-н үйлдвэрлэл, хөнгөн хүнсний үйлдвэр	Засаг захиргааны төв, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	Сүү махны эрчимжсэн мал аж ахуй, туслах аж ахуй, улаан буудайн тариалалт, спиртийн
3.	Хөтөл	Цементийн үйлдвэрлэл	Төмөр замын өртөө	Төмөр замын өртөө, туслах аж ахуй МАА	Мал аж ахуй, туслах аж ахуй

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

4.	Сүхбаатар	Аймгийн төв		Засаг захиргааны төв, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	Удирлага, зохион байгуулалт
5.	Алтанбулаг	Чөлөөт бүс	Чөлөөт бүс	Сумын төв, нийгмийн үйлчилгээ	Гадаад, дотоод худалдаа, үйлчилгээ, суурьшил, нийгмийн дэд бүтэц

Эдгээр үзүүлэлтүүдээс үзэхэд хот суурингууд бүгд өөр өөрийн гэсэн онцлог давуу тал, үзүүлэлтүүдтэй байна.

Үүнээс үүдэлтэйгээр “ХӨГЖЛИЙН ПИРАМИД”-дыг үүсгэхэд тун дөхөм байна. Жишээ нь:

- Эдгээр хот суурингуудын чиг үүргээс нь хамаараад нэгэн цогц, цогцолбор болгох
- Дархан хотыг түшиглэн, түүнийг өргөтгөх замаар хойд бүсийн төвийг байгуулах
- Апиваа үйлдвэрлэл үйлчилгээ бий болгох, түүхий эдийн нөөц зэргийг тухайн энэхүү бүсээсээ бэлтгэн нийлүүлэх. Жишээ нь: “Дархан нэхий” ХХК-ний түүхий эдийг Хөтөл, Мандал сумуудаас нийлүүлэх гэх мэт
- Нэгдсэн төлөвлөлт бий болгох
- Аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх
- Шинэ шинэлэг шийдэл, архитектуртай барилга байгууламж барих
- Ногоон бүсийн асуудлыг нухацтай авч үзэх гэх мэтчилэн олон асуудлыг дэвшүүлж байна.

4.5 Хот суурингийн хөгжлийн төлөвлөлт ба бүсийн тулгуур төвүүдийг илрүүлэн тогтоох аргазүйн асуудал

Өнөөг хүртэл хот, район төлөвлөлтөнд хоёр хандлага зонхилж ирэв. Энэ нь:

- Нэгэн төрлийн районуудын концепци: шалгуурыг вектор хувьсагчаар тодорхойлох нь тохиромжтой байх ба энэ хувьсагч ямар нэг шинж чанар, шалгуурын хэмжээ чиглэлийг заадаг.
- Таталцлын (туйлширсан эсвэл зангилаа) районуудын концепци юм.

Судалгааны гол хэрэгслийн нэг нь газарзүйн өгөгдлийн матрицын гэж нэрлэгддэг арга юм. Энэ матрицын мөр нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хуваалтанд харгалзана.

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

Хүн амын нутагшилтын янз бүрийн түвшиний системүүдийн хэмжээнд хот суурин газруудын сүлжээг судлахдаа арга зүйн хувьд дараах хэдэн чиглэлд бас ихээхэн анхаарч байна. Үүнд:

1. *Хот суурин газруудын хоорондын харилцан үйлчлэлийг судлах чиглэл.* Судлаачид аливаа хотуудын хоорондын харилцан үйлчлэл нь “хоёр бие хоорондоо тэдгээрийн масстай шууд пропорциональ, зайн квадраттай урвуу пропорциональ хүчээр таталцаж байдаг” гэсэн Ньютоны II хуулиар илэрч байна гэж үздэг ба үүнийг гравитацийн загвар гэж нэрлэдэг. Хотын “масс” үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ, хүн амын худалдан авах чадвар зэрэг олон төрлийн үзүүлэлтээр илэрхийлэгдэж болох авч ихэнхдээ тухайн хотын хүн амын тоог авдаг. Энэ утгаараа хүн ам зүйн татах хүч гэсэн нэр томъёог ч ашигладаг. Энэ зүй тогтлыг анх судалсан америк эрдэмтний нэрээр “Рейлийнхууль” гэж нэрлэгдсэн хүн ам зүйн харилцан үйлчлэлийн (татах хүчний) загвар ёсоор хоёр хотын хүн амын хоорондын холбоо, харилцааг (үүний статистик үзүүлэлтээр хотуудын хооронд зорчигчдын тоо, телефон ярианы тоо, байгуулсан гэрээ хэлцэлийн тоо гэх мэт олон тоо баримтыг ашиглаж болно)

$$F = k \frac{M_1 M_2}{d^\alpha}$$

томъёогоор тодорхойлогдоно. M_1, M_2 –хотуудын масс буюу хүн амын тоо d –хоорондын зай, α –холбоо, харилцааны хэлбэрээс шалтгаалан ялгаатай утгатай байх зайнаас хамааралтай коэффициент, k –гравитацийн тогтмолтой төстэй утгатай тогтмол хэмжигдэхүүн юм.

2. *Хот суурин газруудын энгийн болон хэв шинжийн ангилал боловсруулах чиглэл.* Хотуудын хүн амын тоо нь энгийн ангиллын хүрээнд тэдгээрийг хот гэж үзэх эсэхийг тодорхойлдог үндсэн үзүүлэлтүүдийн нэг болдог.
3. *Хот суурин газруудын эдийн засгийн газарзүйн байрлалыг судлах чиглэл.*
 - Орон зайн ялгааны тоон үнэлгээ гаргах хялбар аргын нэг нь дундаж квадрат хазайлтыг арифметик дундажид харьцуулснаар илэрхийлэгдэх вариацийн коэффициент байдаг. Энэ нь тодорхойлолт ёсоор

$$V_j = \frac{\sigma_j}{x_j} * 100$$

Хэлбэртэй байх ба гэхдээ зөвхөн ганц үзүүлэлт буюу газарзүйн матрицын нэг л багана болно.

- Байршлын индекс – үүнийг төрөлжилтийн индекс, өөрийгөө хангах болон газарзүйн ассоиацийн индекс гэх мэт олон янзаар нэрлэдэг. Энэ нь ямар нэг салбарт тухайн бүс нутгийн эзлэх хувь хэмжээг мөн бүсийн бүсийн суурь

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

хэмжээтэй харьцуулах, ингэснээрээ суурь түвшнөөс хазайх хазайлтыг тогтоох боломж олгоно.

- Байршлын коэффициент –нутаг дэвсгэрийн нэг нэгжийн түвшинд 2 шинжүүрийг харьцуулах байршлын шинжүүрээс ялгаатай нь нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд тархалтын концентрацын хэмжээг илэрхийлдэгт оршино.

$$\frac{\sum_{i=1}^n |x_{ij} - x_{ik}|}{2 * 100}$$

$j=1,2,3,\dots,m$ –судалж буй шалгуурын индекс

k –суурь үзүүлэлтийн индекс

X_{ij} –нийт нутаг дэвсгэрийн хэмжээгээр тооцсон j -р үзүүлэлтийн нийлбэр утганд i -р бүсийн эзлэх хэмжээ

X_{ik} –суурь үзүүлэлтэнд мөн энэ бүсийн эзлэх хувь

- Бүсүүдийн төрөлжилтийн коэффициент – хэрвээ байршлын коэффициент нутаг дэвсгэрийн объектуудын олонлогийн өгөгдлүүдийн үндсэн дээр тухайн салбарын хувьд бодогддог бол төрөлжилтийн коэффициент эсрэгээр салбаруудын мэдээллийн үндсэн дээр бүс тус бүрийн хувьд бодогдоно.

$$\frac{\sum_{i=1}^n |x_{ij} - a_j|}{2 * 100}$$

j –шинжүүрийн индекс

a_j –судалж буй нутаг дэвсгэрийн системийн хувьд j -р шинжүүрийн утга юм.

Судлаачид эдийн засгийн газарзүйн байрлалд нь дүн шинжилгээ хийсний үндсэн дээр дараах хэв шинжийн хотууд байдаг болохыг тогтоожээ.

- Төрөл бүрийн замын огтлолцолд байршилтай хот
- Ашигт малтмал эрчимтэй олборлолтын бүс нутгуудад байршилтай хот
- Томоохон боловсруулах үйлдвэрүүдийн бүс нутгуудад байршилтай хот
- ХАА зонхилсон бүс нутагт байршилтай хот зэрэг болно.

4. *Хот суурин газруудын үүргийг судлах чиглэл.* Өнөөгийн байдлаар хот суурин газруудыг үүргийнх нь хувьд дараах хэв шинжид ангилж байна. Үүнд:

- Олон үүрэгтэй хотууд
- Аж үйлдвэр болон тээврийн үүрэг давамгайлсан хотууд
- Аж үйлдвэр болон зам тээврийн үүргээс бусад үүрэг нь давамгайлсан хотууд

5. Хот суурин газарт үйлдвэрлэлийг байршуулах асуудал

Дэд бүтцийн хөгжлийн түвшин:

$$K_j = \frac{\sum_{i=1}^R K_{rj} I_r}{\sum_{i=1}^R I_r} \quad j = 1, 2, \dots, n$$

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

J - хот суурин газрын зэрэглэлийн дугаар

r –дэд бүтцийн төрөл

K_{rj} – j-р зэрэглэлийн хотууд дах r-р төрлийн дэд бүтцийн хөгжлийн тухайн индекс

I_r –сүүлийн 5-н жилээр тооцсоноор төрөл бүрийн эх үүсвэрээс (улсын, хувийн, болон гадаадын) r-р төрлийн дэд бүтцийг хөгжүүлэхэд оруулсан хөрөнгийн хэмжээ

Хөдөлмөрийн бүтээмжийн индекс:

$$K_j^1 = \frac{\sum_{i=1}^m K_{ij}^1 P_{ij}^1}{\sum_{i=1}^m P_{ij}^1} \quad j = 1, 2, \dots, n$$

Фонд өгөмжийн индекс:

$$K_j^2 = \frac{\frac{\sum_{i=1}^m K_{ij}^2 P_{ij}^2}{\sum_{i=1}^m P_{ij}^2}}{\frac{\sum_{i=1}^m T_{ij}^1 P_{ij}^1}{\sum_{i=1}^m P_{ij}^1}} \quad j = 1, 2, \dots, n$$

Фонд зэвсэглэмжийн индекс:

$$K_j^3 = \frac{\sum_{i=1}^m K_{ij}^3 P_{ij}^1}{\sum_{i=1}^m P_{ij}^1} * \frac{\sum_{i=1}^m T_{ij} P_{ij}^1}{\sum_{i=1}^m P_{ij}^1} \quad j = 1, 2, \dots, n$$

Үүнээс гадна үйлдвэрлэлийг байршуулах сонголт хийх, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, цаашид ашигтай ажиллах нөхцлийг хангахад нөлөөлөх хүчин зүйлүүдийг сайтар тооцон судалгаа, дүгнэлт хийх явдал нэн чухал юм. Одоо бид эмпирик аргаар гаргасан зарим хүчин зүйлүүдийг авч үзье:

I. Зах зээлийн хүчин зүйл

Эрэлт

1. Зах зээлд ойр байх
2. Борлуулалтын зах зээлийг өргөтгөх боломж

II. Үйлдвэрлэлийн зардалд нөлөөлөх хүчин зүйлүүд

Ажиллах хүч

1. Ажиллагчдын мэргэжлийн чадвар
2. Цалин, хөдөлмөрийн хөлсний түвшин
3. Хөдөлмөрийн бүтээмж
4. Хөдөлмөр, цалин хөлсний талаархи хууль тогтоомж
5. Ажиллах хүчний хүрэлцээ
6. Бусад бүсээс ажиллах хүч авах боломж

Материал, түүхий эд, түлш, эрчим хүч

1. Түүхий эд, түлш эрчим хүчний үнэ

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

2. Тээврийн тариф
3. Орон нутгаас түүхий эд бэлтгэх, эрчим хүч нийлүүлэх чадавхи
4. Усны хангамж

Бусад зардал

1. Зээлийн хүүгийн түвшин
2. Хөрөнгө
3. Эцсийн бүтээгдэхүүнийг тээвэрлэх тариф
4. Үйлдвэрлэлийн хаягдлыг зайлуулах боломж
5. Цаг агаарын нөхцөл

Орон нутгийн нөхцөл

1. Нийгмийн дэд бүтэц
2. Тухайн объектыг байршуулах талаар орон нутгийн иргэдийн санал бодол
3. Татварын тогтолцоо
4. Орон нутгийн засаг захиргааны дэмжлэг
5. Хил, гаалийн дэглэм, бүтээгдэхүүнээ тухайн бүс нутгаас гадагш нийлүүлэх боломж

III. Субъектив хүчин зүйлүүд

1. Байгаль, цаг уурын тааламжтай байдал
2. Эдийн засгийн шинжтэй хувийн хуримтлал
3. Эдийн засгийн бус шинжтэй хувийн хуримтлал

IV. Бусад хүчин зүйлүүд

6. *Хот суурин газруудын зэрэглэлийг тогтоох асуудал.* Энэ чиглэлийн судалгаа шинжилгээний ажлын үр дүн, судлаачдын бүтээлүүдэд шинжилгээ хийж үзэхэд хот суурин газруудын зэрэглэл, эдийн засгийн бүсүүдийн хөгжлийн тулгуур төвүүдийг илрүүлэн тогтоох судлагаанд өнөө үед тэргүүлэх байр суурьтай байгаа аргазүйн үндсэн чиг хандлагыг дараах байдлаар тодорхойлж болох юм. Үүнд:

- ❖ Тухайн улсын болон эдийн засгийн бүсүүдийн хүн амын нутагшилтын янз бүрийн түвшний системүүдийг системийн хандлагад тулгуурлан илрүүлж дүн шинжилгээ хийх замаар тэдгээрийг зэрэглэх
- ❖ Хүн амын нутагшилтын янз бүрийн түвшний (эдийн засгийн бүсийн, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн г.м) системүүдийн хэмжээнд хот суурин газруудын сүлжээг тэдгээрийн бүтэц, хувьсал өөрчлөлт, хөгжлийн хандлага болон нөлөөлж буй хүчин зүйлс (эдийн засгийн, нийгмийн, байгалийн г.м)–ийг тооцон үнэлэх замаар зэрэглэх
- ❖ Улсын болон эдийн засгийн бүсүүд түүнчлэн засаг захиргаа-нутаг дэвсгэрийн нэгжүүдийн түвшинд хот суурин газруудын зэрэглэлийг

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

тогтоож, үүн дээрээ үндэслэн хөгжлийн тулгуур төвүүдийг илрүүлэн, тэдгээрийн хөгжлийн хэтийн төлвийг тодорхойлох зэрэг болно.

7. Монгол улсын хот суурин газрын зэрэглэл, хөгжлийн тулгуур төвийг тогтоох асуудал. Бүс нутгийн хөгжлийн түвшинг тодорхойлохын тулд шалгуур үзүүлэлтүүдийг сонгох шаардлагатай. Эдгээрийг сонгохдоо Германы П.Юрцек, Л.Шеатцел, А.Г.Гранберг, Г.В.Гутман, А.П.Градов Монголын эрдэмтэд Л.Цэдэндамба, О.Батхишиг, Х.Маам, Л.Энхтайван болон бусад судлаачдын хандлагуудыг үндэс болгов. (Хүснэгт 2)

Хүснэгт 31. Бүсийн тулгуур төвийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн сонголт

№	Үзүүлэлтүүд	П.Юрцек	Л.Шеатцел	А.Г.Гранберг	Г.В.Гутман	А.П.Градов	Л.Цэдэндамба ба бусад	Давгамж
1	Хүн ам	+	+	+		+	+	5
2	Хөрөнгө оруулалт	+	+	+	+	+		5
3	Бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүн	+	+	+	+	+	+	6
4	Нэг хүн амд ногдох ДНБ	+	+		+		+	4
5	Нийгмийн дэд бүтэц	+	+	+	+	+	+	6
6	Үйлдвэрлэлийн дэд бүтэц	+	+	+	+	+	+	6
7	Экологийн байдал	+	+	+		+	+	5
8	Байгалийн нөөц баялаг				+	+	+	3
9	Эдийн засгийн секторуудын хөгжил	+	+	+	+	+	+	6
10	Хэрэглээний үнийн индекс					+		1
11	Төсөв			+		+		2
12	Дундаж цалин хөлс				+			1
13	Орон сууц	+			+			2
14	Санхүү, банкны систем					+		1
15	Судалгаа хөгжлийн үйл ажиллагаа	+	+					2

Эдгээр хандлагуудыг авч үзэхэд Р.Юрцек, Г.В.Гутман нарын судлаачид ниймгийн талын хүчин зүйлсийг илүү түлхүү анхаарсан байхад бусад нь бизнесийн үйл ажиллагаа болон эдийн засгийн талаас нь түлхүү анхаарчээ. Үүний зэрэгцээ дийлэнх судлаачид экологийн шалгуур үзүүлэлтийг авч үзжээ. Мөн Оросын судлаачид байгалийн нөөц баялгийг, харин Германы судлаачид судалгаа хөгжлийн үйл

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

ажиллагааг авч үзсэн ялгаатай байдал ажиглагдаж байна. Харин манай улсын судлаачдын хувьд харьцангуй цөөн тооны тодорхой үзүүлэлтийг хамран судалгааг явуулсан байна. Өөрөөр хэлбэл байгаль цаг уур, мал аж ахуй, газар тариалан, зам тээвэр гэх зэргээр тодорхой чиглэлийг хамран судалсан байна. Бүс нутгийн (тулгуур хотын) хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийг дээрх судлаачдын хандлагууд дах түгээмэл үзүүлэлтүүдийг сонгон авлаа.

Бүсийн тулгуур төвийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүд:

1. Хүний нөөц
2. Капитал (хөрөнгө оруулалт)-ын нөөц
3. Экологийн төлөв байдал
4. Дэд бүтцийн хөгжил
5. Эдийн засгийн хөгжил:
 - Нийт үйлдвэрлэлт
 - Нэг хүнд амд ногдох ДНБ
 - Хөдөө аж ахуй
 - Аж үйлдвэр
 - Үйлчилгээ
6. Нийгмийн хөгжлийн асуудлууд

Эдгээр үзүүлэлтүүд нь ерөнхийдөө нийгмийн хөгжлийн асуудлууд, эдийн засгийн хөгжлийн асуудлууд, байгалийн нөхцөл, нөөцийн ашиглалт хамгаалалтын асуудлуудын хүрээнд багтах юм.

Эдгээр үзүүлэлтийг тодруулбал:

1. Хүний нөөц: Эдийн засгийн идэвхитэй хүн ам, ажил эрхлэлтийн байдал, хүн амын нас хүйсний бүлэг зэргээр тодорхойлогдоно.
2. Капиталын нөөц: Бүсийн (тулгуур төвийн) хөрөнгө оруулалтын хэмжээгээр тодорхойлогдоно.
3. Экологийн төлөв байдал (байгалийн нөхцөл, нөөцийн ашиглалт хамгаалалтын асуудлууд): Тухайн бүс дэх газрын сангийн нөөц (газар нутаг, усны сан, ойн сангийн нөөц), амьтан ургамлын нөөц, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө (гангүй, зудгүй, цөлжилтгүй байх магадлал), хүрээлэн байгаа орчны цэвэр байдал (агаар, ус, хөрс) зэргээр тодорхойлогдоно.
4. Дэд бүтцийн хөгжил: Үйлдвэрлэл (зам тээвэр, харилцаа холбоо, эрчим хүчний хангамж)-ийн дэд бүтцийн хөгжлийн түвшингээр тодорхойлогдоно.
5. Эдийн засгийн хөгжил:
 - а) Нийт үйлдвэрлэлт: Бүсийн (тулгуур төвийн) дотоодын нийт бүтээгдэхүүнээр тодорхойлогдоно.
 - б) Нэг хүнд ногдох ДНБ: Бүсийн (тулгуур төвийн) нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнээр тодорхойлогдоно.

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

- c) Хөдөө аж ахуй: Мал аж ахуй болон газар тариалангийн салбарын хөгжлөөр тодорхойлогдоно. Газар тариалангийн хувьд хураасан ургацын хэмжээгээр, харин мал аж ахуйн салбарын тухайд хээлтэгч малын тоо, махны болон ноос ноолуурын нөөцөөр тодорхойлогдоно.
- d) Аж үйлдвэр: Бүсийн (тулгуур төвийн) аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтаар тодорхойлогдоно.
- e) Үйлчилгээ: Жижиг бизнесийн гол төлөөлөл болох үйлчилгээний чиглэлээр тодорхойлогдоно.

6. Нийгмийн хөгжлийн асуудлууд:

- a) Хүн амын жилийн дундаж өсөлт
- b) Хотуудын шилжих хөдөлгөөний хандлага
- c) Ажилгүйдлийн түвшин: Ажлын байрны нэмэгдэл ба ажил хайж буй хүний тоо
- d) Хүн амын эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар: Нэг их эмч, нэг сувилагчид ногдох хүний тооны харьцаа
- e) Боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар: Хичээлийн байр болон багшлах боловсон хүчний чанар, хангамж
- f) Мэдээллийн үйлчилгээний хүртээмж чанар
- g) Орлого: нэг хүнд ногдох орлого
- h) Орон сууцны нөхцөл
- i) Соёл урлаг
- j) Цэвэр ус, аюулгүй хоол хүнсээр хангагдаж байгаа эсэх асуудал

ДҮГНЭЛТ

Монгол орны төвийн бүсийн нийт 7 аймгийн 95 сумын хүрээнд хүн амын нутагшилт, хотжилтын өнөөгийн байдлыг судаллаа. Судалгааны бүсийн хувьд:

- ❖ Дархан-Уул, Сэлэнгэ, Говьсүмбэр аймгууд харьцангуй нягтшил ихтэй улсын дундажаас ойролцоогоор 2 дахин илүү, Дундговь болон Өмнөговь аймгууд харьцангуй нягтшил багатай байгаа бөгөөд улсын дундажаас 3 дахин бага байна.
- ❖ 1990 оноос шилжих хөдөлгөөн нийслэл хотруу чиглэж байснаас гадна газар тариалан эрчимтэй хөгжиж байсан Сэлэнгэ, Дархан, Төв, сүүлийн жилүүдэд уул уурхайн хөгжлийг даган Өмнөговь аймаг руу түлхүү хандсан байна.
- ❖ 2000 оноос 2012 оны ажил эрхлэлтийг авч үзэхэд хөдөлмөрийн насны хүн ам 60,7 хувиар, эдийн засгийн идэвхтэй хүн ам 34,5 хувиар, ажилчдын тоо 20,6 хувиар өссөн бол ажилгүйчүүдийн тоо 21 хувиар буурсан байна.
- ❖ Энэ нь бүсийн ажил эрхлэлтийн түвшин өндөр байгааг харуулж байна. Төвийн бүсийн 45 хувь нь хотжсон бөгөөд 1990 оноос 2000 он хүртэл хотжилт 4.4%-аар өссөн бол 2000 оноос 2012 оны хооронд 2.5% -иар өсжээ.
- ❖ Аймгийн төвөөс алслагдсан байдал нь сумдын хүн ам өсөлт нөлөөлж байгаа нь ажиглаж байна. Нутагшилтын шугаман, төвлөрсөн, ареал, бичил бүс, зурвас хэлбэрүүд ажиглагдаж байна.
- ❖ Уг бүсийн нэг хүнд ноогдох аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ 2000 онд 0.19 сая, төгбайсан бол 2012 он гэхэд 2.23 болж даруй 11.7 дахин нэмэгдсэн байна.
- ❖ Үйлдвэрлэл дагасан хот суурингийн хүн амын тоо 10 орчим хувиар нэмэгдсэн байгаа нь аж үйлдвэр уул уурхай нь хүн амыг татах гол хүчин зүйл гэдгийг харуулж байна.
- ❖ Сүүлийн жилүүдэд илүүтэй хөгжиж байгаа томоохон уул уурхай болон аж үйлдвэр дагасан төвлөрөл нь Дархан болон Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сумуудад ажиглагдаж байна.
- ❖ Газар тариалан эрчимтэй хөгжсөн Төв, Сэлэнгэ, Дархан аймгуудад 2000 оноос хойш төмсний тариалалтын хэмжээ 3.2 дахин, үртариан тариалалтын хэмжээ 1.6 дахин, хүнсний ногоо тариалалтын хэмжээ 1.5 дахин нэмэгдсэн байна.
- ❖ Харин говийн аймгуудын хувьд төмс 1.2, хүнсний ногоо -7%-иар өссөн бөгөөд Өмнөговь аймаг 17.2 тн үр тариа тариалж эхлээд байна.
- ❖ Уг бүсийн хэмжээнд төмөр зам эсвэл хар зам дайрч өнгөрдөг сумдын хүн амын өсөлт 9.55%, Хар зам болон төмөр зам хоёулаа зэрэг дайрдаг сумдын хүн амын өсөлт 12.68%-н өсөлттэй байгаа бол бусад сумдын хүн амын тоо 11.40%-иар буурсан байна.
- ❖ Төвийн бүсийн хэмжээнд нийт 156 ЕБС-д 83091 сурагч суралцах, 7 Мэргэжлийн сургалтын төв, 5 их дээд сургууль үйл ажиллагаа явуулдаг бөгөөд нийт 6555 оюутан суралцаж байна.

Үүнээс дүгнэж үзэхэд

Дунд хэмжээний сумын төвийн оршин суугчид нийслэл хот, аймгийн төв, томоохон сумын төв, тэнхлэг рүү шилжин нүүдэлснээр дунд хэмжээний сумын төвийн оршин суугчдын тоо цөөрч, жижиг(хөдөөгийн суурин) сумын төвийн тоо нэмэгдэж байна.

Сэлэнгэ Төв аймгуудын хувьд байгаль, газарзүйн нөхцөл сайтай нь мал аж ахуй, газар тариалан эрхлэхэд тохиромжтой тул эдгээр аймгуудад зам дагасан жижиг сум суурингуудын суурьшил нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Шинээр Өмнөговь аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал бий болж байна.

Тухайлбал: томоохон хэмжээний ашигт малтмалын стратегийн ач холбогдол бүхий орд газрууд болох Таван Толгой, Оюу Толгой зэрэг нь хүн амыг ихээр татах болсноос ажлын байр эрэлхийлэн говийн аймгуудад шилжин ирж суурьших үйл явц ихэссэх төлөвтэй байна. Уул уурхайн үйлдвэрлэлүүд ашиглалтанд орсноор эдийн засгийн өсөлт хурдацтай нэмэгдэж, хөдөлмөр эрхлэлтийн хэмжээ нэмэгдэх төлөв ажиглагдаж байна. Гагцхүү эдийн засгийн энэхүү тааламжтай цаг үеийг хүн амын хөдөлмөр эрхлэлтийг хангах, ажилгүйдлийг бууруулахад оновчтой ашиглах нь чухал.

Сум, суурингуудад байр, орон сууцыг бий болгоход төрөл бүрийн хөрөнгийн эх үүсвэрийг чиглүүлж, жижиг дунд үйлдвэрлэл, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд зах зээлийн жишигт нийцүүлсэн арга барилыг нэвтрүүлэх эзэмшүүлэх зэргээр хамгийн оновчтой хэлбэрийг үр өгөөжтэй ашиглан хүн амьдрах таатай орчинг бүрдүүлэн хүн амын шилжих хөдөлгөөнийг урсгалыг сааруулж, хүн амын тогвортой суурьшлыг бий болгох нь чухал юм. Үүний тулд төрөөс бүс нутаг, хөдөө орон нутаг руу хандсан бодлогыг явуулж хөдөөгийн суурин, сумдын түлхэх хүчин зүйлсийг багасгаснаар хүн амын сууршил тогтвортой байхын зэрэгцээ хүн амын хэт төвлөрөлийг багасгаж хүн амын нутагшилтын зохистой хэлбэр бүрэлдэн тогтоно.

Ийнхүү бид үндэсний төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратегийн ач холбогдол бүхий орд газрууд болох Таван Толгой, Оюу Толгой зэрэг нь хүн амыг ихээр татах болсноос ажлын байр эрэлхийлэн говийн аймгуудад шилжин ирж суурьших үйл явц ихэссэх төлөвтэй байна. Уул уурхайн үйлдвэрлэлүүд ашиглалтанд орсноор эдийн засгийн өсөлт хурдацтай нэмэгдэж, хөдөлмөр эрхлэлтийн хэмжээ нэмэгдэх төлөв ажиглагдаж байна. Гагцхүү эдийн засгийн энэхүү тааламжтай цаг үеийг хүн амын хөдөлмөр эрхлэлтийг хангах, ажилгүйдлийг бууруулахад оновчтой ашиглах нь чухал юм. Үүний тулд төрөөс бүс нутаг, хөдөө орон нутаг руу хандсан бодлогыг явуулж хөдөөгийн суурин, сумдын түлхэх хүчин зүйлсийг багасгаснаар хүн амын сууршил тогтвортой байхын зэрэгцээ хүн амын хэт төвлөрөлийг багасгаж хүн амын нутагшилтын зохистой хэлбэр бүрэлдэн тогтоно.

Ийнхүү бид үндэсний төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратегийн ач холбогдол бүхий орд газрууд болох Таван Толгой, Оюу Толгой зэрэг нь хүн амыг ихээр татах болсноос ажлын байр эрэлхийлэн говийн аймгуудад шилжин ирж суурьших үйл явц ихэссэх төлөвтэй байна. Уул уурхайн үйлдвэрлэлүүд ашиглалтанд орсноор эдийн засгийн өсөлт хурдацтай нэмэгдэж, хөдөлмөр эрхлэлтийн хэмжээ нэмэгдэх төлөв ажиглагдаж байна. Гагцхүү эдийн засгийн энэхүү тааламжтай цаг үеийг хүн амын хөдөлмөр эрхлэлтийг хангах, ажилгүйдлийг бууруулахад оновчтой ашиглах нь чухал юм. Үүний тулд төрөөс бүс нутаг, хөдөө орон нутаг руу хандсан бодлогыг явуулж хөдөөгийн суурин, сумдын түлхэх хүчин зүйлсийг багасгаснаар хүн амын сууршил тогтвортой байхын зэрэгцээ хүн амын хэт төвлөрөлийг багасгаж хүн амын нутагшилтын зохистой хэлбэр бүрэлдэн тогтоно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Л.Цэдэндамба “Бүсчилсэн хөгжлийн бодлогын онол, аргагүйн үндэс УБ 2011
2. Л.Цэдэндамба, О.Батхишиг, Х.Маам “Монгол улсын өрнөд бүс” УБ1999
3. “Монгол улсын хөгжлийн судалгаа” ҮХХ 2003, 2004, 2005, 2007, 2008, 2009
4. Б.Гунгаадаш “БНМАУ-ийн Үндэсний-Үндэсний Газарзүй” УБ 1986
5. Үндэсний бодлого-ийн үндэсний бодлого-ийн 2009 үйл
6. Өмнөд бүс 2010 үйлдвэржилтийн 2010.
7. Өмнөд бүс 2010 үйлдвэржилтийн 2010 үйл.
8. Үндэсний бодлого-ийн үндэсний бодлого-ийн үндэсний бодлого-ийн 2001 үйл.
9. Гранберг А.Г. Основы региональной экономики: Учебник для вузов. М.; Научная литература, 2006
10. Барыгин, И.Н. Основы регионоведения: Учебное пособие/ И.Н. Барыгин. – М.: Гардарики, 2007. – 399 с.
11. Дульщикова, Ю.С. Региональная политика и управление / Ю.С. Дульщикова. – М.: РАГС, 2006. – 362 с.
12. Градов.А.П, Кузин.Б.И, Медников.М.Д, Соколицын.А.С. Региональная экономика, Питер, 2003. – 222 с.
13. Некрасов, Н.Н. Региональная экономика. Теория, проблемы, методы / Н.Н. Некрасов. – М.: Экономика, 2004. – 268 с.
14. Региональная экономика: Учебник / Под ред. В.И. Видяпина, М.В. Степанова. – М.: ИНФРА-М, 2007. – 612 с.
15. Д.Даш, Н.Мандах “Газарзүйн шинжлэх ухааны хөгжлийн түүх”, УБ 2011
16. Р.Ринчинбазар “Монголын бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт, удирдлагын асуудлууд”, Ред: Л.Дашдорж, Т.Энэбиш, УБ 2004
17. Р.Ринчинбазар “Монголын бүс нутгийн хөгжлийн эдийн засаг –математикийн загварчлал”, Ред: Акад Т.Дорж, проф С.Будням, проф Р.Энхбат, УБ 2004
18. Р.Ринчинбазар “Монголын бүс нутгийн тогтвортой хөгжлийн асуудлууд”, Ред: Т.Энэбиш, УБ 2004
19. Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газар, ШУА-ийн харьяа Үндэсний хөгжлийн хүрээлэн “Монгол улсын хөгжлийн судалгаа” (Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл) 2007(1,2), УБ 2007
20. Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газар, ШУА-ийн харьяа Үндэсний хөгжлийн хүрээлэн “Монгол улсын хөгжлийн судалгаа” (Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл) 2008(1,2,3), УБ 2008
21. Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газар, ШУА-ийн харьяа Үндэсний хөгжлийн хүрээлэн “Монгол улсын хөгжлийн судалгаа” (Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл) 2009(1), УБ 2009
22. Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газар, ШУА-ийн харьяа Үндэсний хөгжлийн хүрээлэн “Монгол улсын хөгжлийн судалгаа” (Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл) 2010, УБ 2010

23. Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газар, ШУА-ийн харьяа Үндэсний хөгжлийн хүрээлэн “Монгол улсын хөгжлийн судалгаа” (Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл) 2011(1,2), УБ 2011
24. Баруун бүсийн зөвлөл, Ховдын их сургууль, Бүс нутгийг дэмжих хөтөлбөр “Баруунбүсийнбайгаль, нийгэм, эдийнзасгийннолол, практикийнасуудлууд”, Эрдэмшинжилгээнийбагахурлынилтгэлийнэмхтгэл, Ховдохот 2011
25. МУ-ын ШУА, Газарзүйн хүрээлэн “Монголулсынзасагзахиргаа, нутаг дэвсгэрийн шинэчлэлийн нийгэм-эдийн засгийн газарзүйн тандах судалгаа” /Д.Базаргүр, Б.Батбуян/, УБ 2007
26. “A Study on the Factors of RegionalCompetitiveness”, A draft final report for The European Commission, Directorate-General Regional Policy,
27. Economic Commission for Europe “Spatial Planning: Key Instrument for Development and Effective Governancewith Special Reference to Countries in Transition, UNITED NATIONS, New York and Geneva, 2008
28. Department for Regional Development. REGIONAL DEVELOPMENT STRATEGY, RDS 2035
29. Econometric Analysis of Income Convergence in Selected EU Countries and Their Nuts 3 Level Regions, Tiiu Paas, Andres Kuusk, Friso Schlitte, Andres Võrk, Tartu 2007
30. INFRASTRUCTURE IN MONGOLIA:CHALLENGES AND OPPORTUNITIES Ulaanbaatar, Mongolia April, 2009
31. Southern Mongolia Infrastructure Strategy Ulaanbaatar 2009 The World Bank
32. www.nso.mn
33. www.pmis.gov.mn
34. <http://en.wikipedia.org/>

ХАВСРАЛТ 1

“ Эдийн засгийн хөгжлийн дэд бүс болон нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх хот,
суурины хөгжлийн стратеги “ төслийн асуулга судалгаа (хувь хүнээс)

Асуулгын агуулга


1. Насны бүтэц
2. Хүйсийн бүтэц
3. Ажил албан тушаал
4. Үндсэн харьяалал
5. Цаашид орон нутагтаа тогтвортой суурьших эсэх
6. Тухайн нутагт нэн тэргүүнд ямар үйлдвэрлэлийг хөгжүүлэх тухай
7. Өнөөгийн засаг захиргааны бүтцийн тухай
8. Орон нутгийн хөгжлийн нөөц, чадавхи
9. Үл хөдлөх хөрөнгөтэй эсэх
10. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж
11. Боловсролын үйлчилгээний хүртээмж
12. Өрх гэрийн өргөн хэрэглээний материаллаг хангамжын талаар
13. Тээвэр, дэд бүтцийн хангамж
14. Говийн бүсийн хот, суурингуудаас алийг нь нэн тэргүүнд хөгжүүлвэл зохистой эсэх
15. Тухайн орон нутгийн хөгжлийн хэтийн төлвийн талаарх иргэдийн санал бодол

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

1. Насны бүтэц

Нийт асуулга судалгаанд 16-75 насны 69 хүн оролцсоны 16-25 насны залуучууд – 20 буюу 29.0% , 26-35 насныхан – 23 буюу 33.4% , 36-45 насныхан – 13 буюу 18.8% , 45-с дээш насныхан – 13 буюу 18.8%-ийг эзэлж байна.

Хүснэгт 1. Насны бүтэц



Эх сурвалж : Анкетийн судалгаа 2010

Дээрх насны бүтцийг ажиглахад 26-35 насны залуучууд ихэнх хувийг эзэлж байгаа харагдаж байна. Эндээс дүгнэхэд Монголын хүн амын ихэнх хэсгийг залуучууд бүрдүүлдэг нь тод харагдлаа.

Хүснэгт 2. Суурин хүн амын тоо

Аймаг	2005	2006	2007	2008
Дүн	436,1	436,5	437,9	442,6
Говьсүмбэр	12,2	12,3	12,6	12,9
Дархан-уул	87,7	87,5	87,6	88,2
Дорноговь	53,3	54,5	55,6	57,2
Дундговь	49,6	49,2	48,8	48,2
Өмнөговь	46,1	46,5	46,9	47,7
Сэлэнгэ	99,8	100,1	100,5	101,6
Төв	87,4	86,4	85,9	86,8


Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

Эх сурвалж : Статистикийн эмхэтгэл 2008

2. Хүйсийн бүтэц

Нийт судалгаанд оролцсон 69 хүний 26 буюу 37.6 % нь эрэгтэй 43 буюу 62.4 % нь эмэгтэй хүн байна.

График 1. Хүйсийн бүтэц



Эх сурвалж : Анкетийн судалгаа 2010

Энэ саналын дүнгээс харахад дийлэнхи нь эмэгтэй хүмүүс байгаа нь эмэгтэйчүүд илүү нийгмийн идэвхитэй байгааг мөн харуулж байна.

Нийт гэр бүлтэй иргэдийн ам бүлийн хувьд 3-14 гишүүнтэй байна. Эдгээр гэр бүлийн гишүүдийн дийлэнхи нь оюутан сурагч байгаа ба гэр бүлийн 1-2 хүн л ажил хийж амьдралаа авч явдаг. Ерөнхийдөө хүмүүсийн амьжиргааны түвшин нилээн доогуур байна.

3. Ажил албан тушаал

Хүснэгт 3. Эдийн засгийн идэвхитэй хүн ам / мян.хүн ам /

Аймаг	2005	2006	2007	2008	2009
Бүгд	176,4	180,3	183,2	185,5	215,6
ᠠᠶᠢᠨᠠᠨᠢᠨᠠᠨᠠᠨᠠᠨ	4,3	3,9	4,3	4,3	6,1
ᠠᠠᠳᠳᠠᠶᠢ-ᠣᠶ᠋ᠡ	27,2	28,8	29,2	34,5	40,4
ᠠᠶᠢᠳᠢᠶᠢᠨᠠᠨᠠᠨ	19,9	19,7	20,1	20,8	25,3
ᠠᠳᠢᠶᠢᠨᠠᠨᠠᠨ	23,4	23,3	23,6	22,7	24,1
^a ᠢᠶᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠨ	22,1	21,7	22,5	20,6	27,3
ᠨᠢᠶᠡᠭᠢᠶᠢ	36,1	38,5	38,8	39,2	50,1
ᠣᠶᠠ	43,4	44,4	44,7	43,4	42,3

Эх сурвалж : Статистикийн эмхэтгэл 2009

Хүснэгт 4. Ажиллагсадын тоо / мян.хүн ам /

Аймаг	2005	2006	2007	2008	2009
Бүгд	171,9	175,9	179,3	181,4	191,4
ᠠᠶᠢᠨᠠᠨᠢᠨᠠᠨᠠᠨ	4,2	3,8	4,2	4,2	4,8

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

Ääððàí-Óóë	26,4	27,9	28,2	33,3	34,1
Äîðíîäîü	19,5	19,5	19,8	20,5	20,1
Äóíääîü	22,6	22,5	23,0	22,2	20,9
^a ìí°äîü	21,6	21,2	22,2	20,1	23,2
Ñüýíäý	34,9	37,4	37,8	38,2	48,8
Ò°ä	42,7	43,6	44,1	42,9	39,5

Эх сурвалж : Статистикийн эмхэтгэл 2009

Хүснэгт 5. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо

Аймаг	2005	2006	2007	2008	2009
Бүгд	4514	4369	4161	3972	5379
Äîäüñç ìäýð	129	134	164	113	157
Ääððàí-Óóë	837	881	1066	1159	1641
Äîðíîäîü	415	222	385	322	532
Äóíääîü	778	759	589	448	554
^a ìí°äîü	494	506	339	492	484
Ñüýíäý	1176	1096	1008	978	1120
Ò°ä	685	771	610	460	891

Эх сурвалж : Статистикийн эмхэтгэл 2009

Хүснэгт 6. Ажиллагсадын тоо / мян.хүн ам /

Салбар	2005	2006	2007	2008	2009
ХАА ан агнуур, ойн аж ахуй	386,2	391,4	385,6	377,6	348,1
Уул уурхай олборлох аж үйлдвэр	39,8	41,9	44,1	46,5	34,8
Боловсруулах аж үйлдвэр	45,6	47,0	47,9	47,5	62,7
Цахилгаан дулааны үйлдвэрлэл усан хангамж	28,5	30,0	31,1	30,1	9,5
Барилга	48,9	56,3	60,0	66,8	6,1
Бөөний жижиглэнгийн худалдаа	141,9	160,6	162,2	169,7	49,6
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	16,1	16,8	17,4	19,8	10,1
Боловсрол	58,8	62,0	64,8	66,2	74,9
Эрүүл мэнд	39,5	39,3	40,2	42,3	35,7
Төрийн удирдлага батлан хамгаалах нийгмийн даатгал	46,7	46,9	48,5	50,9	8,9


Эх сурвалж : Статистикийн эмхэтгэл 2009

Асуулга судалгаанд оролцсон хүмүүсийн 27 буюу 39.1 % нь ажилгүй , 42 буюу 60.9 % нь ажилтай байна.

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги


График 2. Ажил эрхлэлт

Эх сурвалж : Анкетийн судалгаа 2010



Дээрх статистикийн тоо баримттай судалгааны дүнгээ харьцуулан үзэхэд бидний судалгаа бодитой болсон нь харагдаж байна. Учир нь ажиггүй иргэдээс илүү ажигтай иргэд нь жил ирэх тусам нэмэгдсэн нь тодорхой байна.


График 3. Ажилгүйчүүд



Судалгааны дүнгээс харахад говийн бүсийн аймгуудын ажилгүйдлийн түвшин харьцангуйгаар гайгүй бага байгаа нь харагдаж байна.

Эх сурвалж : Анкетийн судалгаа 2010

График 4. Ажил эрхлэлтийн байдал



Эх сурвалж : Анкетийн судалгаа 2010

Ажил эрхлэлт

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

- Улсын байгууллагад нийт судалгаанд оролцогчдын 12 хүн буюу 23%
- Уул уурхайн салбарт 5 хүн буюу 9%
- Бусад 14хүн буюу 35%
- Хувиараа бизнес эрхлэгчид 9 хүн буюу 17%-ийг тус тус эзэлж байна.




График 5. Ажиллагсад

Эх сурвалж : Анкетийн судалгаа 2010


Ажиллаж байгаа иргэд:

- Нийт судалгаанд оролцогчдын 30% улсын байгууллагад
- Нийт судалгаанд оролцогчдын 13% уул уурхайн салбарт
- Нийт судалгаанд оролцогчдын 22% хувиараа
- Нийт судалгаанд оролцсон хүмүүсийн 35%- бусад салбарынх тус тус эзэлж байна.

4. Үндсэн харьяалал

Нийт судалгаанд оролцсон 69 хүний 39 нь буюу 57% Өмнөговь , 3 хүн буюу 5% Дундговь , 5 хүн буюу 7% Дорноговь , 8 хүн буюу 12% Говьсүмбэр , 13 хүн буюу 19% Хэнтий аймгийн харьяалалтай хүмүүс байна.

График 6. Харьяалал




Эх сурвалж: Анкетын судалгаа 2010

5. Цаашид нутаг орондоо тогтвортой суурьших эсэх

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

Нийт 69 хүний 62 хүн нь буюу 95% тийм, 7 хүн буюу 5% нь үгүй гэж хариулсан байна.

График 7. Тогтвортой суурьших эсэх



Тийм гэсэн хариулт өгсөн хүмүүс нь:


- Ажил энд учраас
- Энэ нутгийн хүн учраас
- Хөгжиж байгаа учраас

Ажил хийх зорилгоор гэсэн учир шалтгаанаар нутаг орондоо амьдарна гэсэн байна.

Эх сурвалж : Анкетийн судалгаа 2010

Үүнийг нийт хүн амтай харьцуулан үзвэл энэ нутгийн хүн – 31% , ажил энд – 33% , хөгжиж байгаа -26% , ажил хийх зорилгоор – 10% тус тус саналаа өгсөн байна.

График 8



Эх сурвалж : Анкетийн судалгаа 2010

Харин үгүй гэж хариулсан хүмүүсийн 37% нь хотод амьдарна, 13% нь энэ нутагт харьяалалгүй, 50% нь амьдрах нөхцөл боломж муу гэсэн шалтгаануудыг дурдсан байна.

6. Танай нутагт ямар үйлдвэрлэл хөгжүүлэх шаардлагатай вэ?

Аймаг бүр өөр өөрийн онцлогтой ба үүнд нь тохируулан үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлагатай нь иргэдийн саналаас харагдаж байсан. Доорх хүснэгтийн хувьд төвийн бүсийн голлох салбаруудын тухай мэдээлэл байна.

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

Хүснэгт 7. ҮЙЭ АÆÈÈÈÀÀÀÀ ßÁÓÓÈÆ ÁÀÉÀÀÀ ÀÆ ÀÕÓÉ Í ÍÝÃÆ, ÁÀÉÃÓÓÈÈÀÀÛ Í ÒÍ Í, үяаеі çañāēēі çēē àæ èèèāāāī ū ñāēāāðāāð, æ èè áçðēēі ýöýñò

ÁŸГÄ	30 817	32 105	36 498	36 877
Õ°ä°° àæ àðóé, íéí àæ àðóé, àí àāíóóð, çāāñāí ū àæ àðóé	1 402	1 577	1 584	1 762
Óóé óóðóæ, íēāíðēīð çēēāāýð	305	312	347	323
Áíēíāñðóóēāð çēēāāýð	2 098	2 167	2 243	2 364
Öāðèēāāí, äóēāāí ū çēēāāýðēýē, óñāí ðāíāāìæ	231	213	214	209
Áaðèēāā	1 059	1 233	1 313	1 064
Á° íèé áíēíí æðæðāēýí ðóāāēāā, āýð àðóéí áāðāāí ū çañāāðēāð çēē÷èēāāýý	10 924	11 429	15 031	14 691
Çí÷èā áóóāāē, çííāèéí āāçāð	1 367	1 366	1 376	1 371
Öýāýýð, āāóóēāð ū í àæ àðóé, ðíēāíí	937	896	1 025	1 045
Ñāíðççāèéí āçēēāāýý ðèéð çēē àæèèèāāā	891	957	774	1 069
° è ð°äè°ð ð°ð° íā°, ðçðýýñ, áèçíāñèéí áóñāā çēē àæèèèāāā	2 241	2 596	2 728	2 895
Ò°ðèéí óāèðāēāā, áāðēāí ðāì āāæēāð, àēāāí æóðì ū í íèēāìèéí āāāðāāē ū í çēē àæèèèāāā	1 312	1 477	1 514	1 536
Áíēíāñðíē ū í ñāēāāð ū í çēē àæèèèāāā	1 877	2 005	2 005	2 047
Ýðççē íýíā, íèēāìèéí ðāèāìæèéí çēē àæèèèāāā	2 022	2 230	2 216	2 275
Íèēāýì, áèā ðçíä ççççýð áóñāā çēē÷èēāāýý	4 148	3 644	4 126	4 224
Áóñāā	3	3	2	2

Эх сурвалж : Статистикийн эмхэтгэл 2009

Хүснэгт 8. ÀÆ ÀÕÓÉ Í ÍÝÃÆ, ÁÀÉÃÓÓÈÈÀÀÛ Í ÒÍ Í, ðāðèðöēāāí ū ðýēāýðýýð, æ èè áçðēēі ýöýñò


Хариуцлагын хэлбэр	2006	2007	2008	2009
ÁŸÃÄ	48879	55901	60535	64574

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

ᠡᠢᠶᠢᠭᠢᠨ	32327	38011	43130	46893
ᠣᠳᠡᠶᠢᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ	539	562	651	660
ᠣᠳᠡᠳᠡᠨ	3226	3223	2595	2681
Нөхөрлөл	3759	3801	3174	3304
Төсөвт байгууллага	3902	4191	4044	4047
Төрийн бус байгууллага	5118	6050	6858	6908
Бусад (Сургууль, цэцэрлэг) г.м	18	63	83	81


Эх сурвалж : Статистикийн эмхэтгэл 2009

График 11. Хөгжүүлэх шаардлагатай салбарууд. Хэнтий аймаг




Эх сурвалж : Анкетийн судалгаа 2010

График 12. Хөгжүүлэх шаардлагатай салбарууд. Дорноговь




Эх сурвалж : Анкетийн судалгаа 2010

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги



Эх сурвалж : Анкетийн судалгаа 2010

График 13. Хөгжүүлэх шаардлагатай салбарууд



Эх сурвалж : Анкетийн судалгаа 2010

7. Өнөөгийн засаг захиргааны бүтцийг оновчтой гэж үздэг үү

Нийт 69 хүний санал асуулгаас - Үгүй – 53% , тийм – 38% , мэдэхгүй – 9% гэсэн саналтай байна. Судалгаанд оролцсон нийт иргэдийн 53% нь Үгүй, 38% нь Тийм, 9% Мэдэхгүй гэж санал өгсөн байна.

Нийт санал өгсөн иргэдийн дийлэнхи нь өнөөгийн засаг захиргааны бүтцийг оновчгүй дэд бүтцийг түлхүү хөгжүүлж хот суурингийн тал дээр илүү анхаарах хэрэгтэй гэж үзсэн байна.

8. Танай орон нутгийн хөгжлийн нөөц

Өмнөговь

- Уул уурхайд – 95%
- МАА – 5%-ийн саналтай байна.

Дорноговь

- Уул уурхай – 67%

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

- Төмөр зам – 33%-н саналтай байна.

Дорноговь аймгийн санал өгсөн ихэнхи иргэд өөрсдийн хөгжлийнхөө нөөц гарцыг уул уурхай, төмөр зам гэж саналаа өгсөн байна.

Говьсүмбэр

- Уул уурхайн салбарт - 100%-ийн санал авсан байна.

Хэнтий

- Уул уурхай – 92%
- Худалдаа – 8%-ийн саналтай байна.


Хэнтий аймгийнхан өөрийн хөгжлийн ирээдүйн нөөц бол уул уурхай, худалдаа үйлчилгээний салбар гэж үздэг байна.

9. Та үл хөдлөх хөрөнгөтэй юу?

Нийт судалгаанд оролцсон 69 хүний асуулга - Тийм – 93% , үгүй – 7% -ийн саналтай байна.

Хашаа байшин , гэр – 51% , орон сууц – 26% , машин – 21% , дэлгүүр -2%-ийг эзэлж байна.

График 20. Хөрөнгийн төрлүүд



Эх сурвалж : Анкетийн судалгаа 2010

10. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж

Өмнөговь аймаг

- Сайн- 27%, Дунд – 32%, Муу – 38%, Мэдэхгүй – 3%

Дорноговь

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

- Сайн – 39%, Дунд – 19%, Муу- 19%,Мэдэхгүй – 23%

Говьсүмбэр

- Сайн- 32%,Дунд – 53%,Муу – 15%,

Хэнтий

- Сайн – 47%, Дунд – 36%, Муу – 17%

11. Боловсролын үйлчилгээний хүртээмж

Өмнөговь

- Сайн – 22%,Дунд – 39%,Муу – 36%,Мэдэхгүй – 3%

Дорноговь

- Сайн – 58%,Муу- 19%,Мэдэхгүй – 23%

Хэнтий


- Сайн – 58%,Дунд – 29%,Муу – 13%

Говьсүмбэр

- Сайн – 22%, Дунд – 56%, Муу – 22%

12. Өрх гэрийн өргөн хэрэглээний бараа материалыг хаанаас авдаг, ямар тээврийн хэрэгслээр зорчдог вэ?

Нийт судалгаанд оролцсон 69 хүнээс/санал давхардсан байгаа/ *График 30*



Орон нутгаас – 72% , хотоос – 26%, хятадаас – 2% гэсэн саналтай байна.


Автомашин – 85% , нийтийн тээврээр – 12% , галт тэрэг- 3% зорчдог гэсэн санал авсан

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

байна.

Эх сурвалж : Анкетийн судалгаа 2010

13. Говийн аймгуудын хот суурингаас алийг нь нэн тэргүүнд хөгжүүлвэл зохистой вэ?



Эх сурвалж : Анкетийн судалгаа 2010

14. Та өөрийн нутгийн хөгжлийн цаашидын хэтийн төлөвийг юу гэж боддог вэ?




График 32. Дорноговь




График 32. Говьсүмбэр

Эх сурвалж: Анкетийн судалгаа 2010

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги




График 33

Эх сурвалж : Анкетийн судалгаа 2010

ХАВСРАЛТ 2.

“Эдийн засгийн хөгжлийн дэд бүс болон нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх хот, суурингийн хөгжлийн стратеги” төслийн судалгаа (байгууллага компаниудаас авсан судалгаа)


Асуулгын агуулга

1. Судалгаа авсан байгууллагуудын байршил
2. Байгуулагдсан он
3. Албан хаагчдын тоо
4. Бизнесийн төрөл
5. Зах зээлийн хамрах хүрээ, байршлын хувьд гарсан өөрчлөлт
6. Анхдагч түүхий эд материалын хангамж, зах зээл
7. Ажилтан албан хаагчдын байршил, тэдний хангамж үйлчилгээ
8. Анхдагч түүхий эд материалаа худалдан авдаг зах зээл болон хэмжээний хувьд гарч буй өөрчлөлт
9. Өрсөлдөгч компаниудын тухай
10. Үйлдвэрлэл үйлчилгээ явуулахад үүсч буй саад бэрхшээл
11. Хамтын ажиллагаа
12. Үйл ажиллагаагаа өргөжүүлэхийг зорьж буй байдал
13. Улсаас явуулж буй жижиг дунд үйлдвэрүүдийг дэмжих бодлого

1. Байршил

Судалгаанд нийт 37 аж ахуй нэгж компаниуд оролцсон байна. Энэ нь төвийн бүсийн өмнөд хэсгийн нийт аж ахуй нэгж байгууллагуудын бүрэн төлөөлөл болж чадахгүй учир тандалтын байдлаар ашиглав.

График 1. Судалгаа авсан газрууд:



Эх сурвалж: Анкетын судалгаа 2010

Судалгааг нийт 6 суурин газраас авсан байна. Судалгаанд эзлэх хувийг авч үзвэл: Сайншанд 25%, Чойр 22%, Даланзадгад 22%, Бор-Өндөр 14%, Ханбогд 11%, -ийг нь Тавантолгой 6% байна.

Судалгаа авсан компаниудын ихэнх нь хувийн компаниуд байв.

2. Байгуулагдсан он

Судалгаанд хамрагдсан компаниудыг байгуулагдсан оноор авч үзвэл:





График 2. Компаниудын байгуулагдсан он (Эх сурвалж: Анкетын судалгаа 2010)

Хөдөө орон нутагт худалдаа үйлчилгээний хувийн компаниуд нилээн хожуу хөгжсөн нь илэрхий байна. Судалгаанд хамрагдсан компаниудын 73% нь 2005 оноос хойш байгуулагдсан залуу компаниуд байна.

Судалгаанд хамрагдсан нийт компаниудын 73% нь 2005 оноос хойш байгуулагдсан, 14% нь 2000-2005 онд байгуулагдсан, 13% нь 2003 оноос өмнө байгуулагдсан байна.

График 3. Албан хаагчдын тоо (Эх сурвалж: Анкетын судалгаа 2010)



Үүнээс үзэхэд хөдөө орон нутаг дахь уг компаниудын ажиллагсдын тоо маш бага ихэнх компаниуд 1-2 ажилчинтай байдаг байна.


Судалгаанд хамрагдсан нийт 37 байгууллагын 86% нь 1-2 ажилчинтай, 8% нь 10-30 ажилчинтай, 3% нь 30-50

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

ажилчинтай, мөн 3% нь 50-аас дээш ажилчинтай байна.

3. Бизнесийн төрөл

Бизнесийн төрлүүд




Эх сурвалж: Анкетын судалгаа 2010

Нийт аж ахуй нэгжүүдийн өмчийн хэлбэр нь хувийн өмч байна.

Нийт судалгаа авсан байгууллагуудын 62% нь худалдаа, 33% нь үйлчилгээ, үлдсэн 5% нь худалдаа үйлчилгээний хосолсон үйл ажиллагаа явуулдаг байна.

Худалдааны бүтэц



Эх сурвалж: Анкетын судалгаа 2010

Нийт худалдаа эрхэлж буй байгууллагуудын 38% нь хүнсний худалдаа, 25% нь жижиглэн худалдаа, 21% нь хувцас гоёл чимэглэлийн худалдаа, 8% нь эмийн худалдаа, 4% барилгын материалын худалдаа, 4% цагаан идээний худалдааг нь эрхэлдэг байна.


Үйлчилгээний бүтэц



Эх сурвалж: анкетын судалгаа 2010


Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

Нийт үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын 34% нь гар утас болон телевизор засварын газар, 33% нь цайны газар, 22% нь банк санхүү, 11% нь оёдлын цех байна.



Эх сурвалж: Анкетын судалгаа 2010

Уг аж ахуй нэгжүүд нь тус бүртээ өөрийн орон нутагтаа л худалдаа үйлчилгээгээ явуулдаг.



Нийт худалдаа үйлчилгээ эрхэлж буй аж ахуй нэгжүүдийн 25% нь хүнсний худалдаа, 17% нь жижиглэн худалдаа, 14% нь хувцас гоёл чимэглэл, 8% нь цайны газар, 6% нь эмийн худалдаа, 5% нь банк санхүү, 5% нь гар утас, сэлбэг хэрэгслийн худалдаа эрхэлдэг байна.

Худалдаа үйлчилгээнд гарч буй өөрчлөлтийг дараах байдлаар тодорхойлжээ.

4. Зах зээлийн хамрах хүрээ, байршлын хувьд гарсан өөрчлөлт

Худалдаа үйлчилгээнд гарсан өөрчлөлт төдийлөн байхгүй байна.

Ерөнхийдөө судалгаанд хамрагдсан байгууллагуудын 31% нь худалдан авагчдын тоо өсч байгаа, 25% нь бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл нь олширч чанар нь сайжирсан гэж үзсэн.


Үйлчилгээгээ явуулж эхэлсэн хугацаанаас хойш зах зээл ерөнхийдөө тэлэгдэж байна, худалдан авагч, үйлчлүүлэгчдийн тоо өсч байна. Мөн үйлчилгээ болон бүтээгдэхүүний чанар өсч байна гэж ихэнх аж ахуй нэгжүүд үзэж байна. Бүтээгдэхүүн болон түүхий эдийн үнэ хэт өссөнөөс хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурч байна гэж үзэх хүмүүс ч байна.

Аж ахуй нэгжүүд анхдагч түүхий эд болон материалаа худалдан авдаг байдлыг харуулав.

5. Анхдагч түүхий эд, материалаа худалдан авдаг зах зээл

Судалгаанд хамрагдсан нийт 37 компанийн 36 нь шууд бэлэн бүтээгдэхүүн худалдан авч цааш нь борлуулдаг байна.


График 9. Анхдагч түүхий эд материал худалдан авдаг газрууд (Эх сурвалж: Анкетын судалгаа 2010)



Анхдагч түүхий эд материалыг 42% нь Улаанбаатараас, 33% нь гадаадаас, 25% нь орон нутгаасаа авдаг байна.

Үүнээс хүнсний худалдаа эрхэлдэг газрууд нь түүхий эдээ гол төлөв орон нутгаасаа авдаг. Харин хувцас болон жижиглэн худалдаа эрхэлдэг газрууд нь гадаадаас болон УБ-аас бүтээгдэхүүнээ оруулж ирдэг байна.

График 10. Гадаадаас түүхий эд материал худалдан авдаг газрууд:



Эх сурвалж: Анкетын судалгаа 2010

Гадаадаас авдаг гэсэн байгууллагуудын хувьд 54% нь Эрээнээс, 31% нь Бээжингээс, 8% нь Хонгконгоос, 7% нь Солонгосоос

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги

авдаг гэжээ. Үүнээс БНХАУ-аас 85% нь бараа материалаа татан авдаг байна.

Иймд худалдаа үйлчилгээ эрхэлж буй компаниудын үйлдвэрлэл үйлчилгээ БНХАУ-ын зах зээлээс ихээхэн хамааралтай болох нь харагдаж байна.

6. Уг аж ахуй нэгжүүдийн өрсөлдөгчийн хувьд:

График 11. Өрсөлдөгч бий эсэх



Эх сурвалж: Анкетын судалгаа 2010

Судалгаанд оролцсон 37 аж ахуй нэгжийн 32 нь өрсөлдөгчтэй гэж хариулсан бол, 5 нь өрсөлдөгчгүй гэж хариулжээ. Өрсөлдөгчгүй гэсэн тодотголтой компаниудыг доор гаргалаа.

Өрсөлдөгчгүй аж ахуй нэгжүүдийн явуулж буй үйл ажиллагаа

1. Цагаан идээний үйлдвэрлэл
2. 8 нэрийн барааны дэлгүүр
3. Хүнс, бараа, гэр ахуйн бүтээгдэхүүн худалдаалдаг байгууллага

7. Орон нутгийн аж ахуй нэгж компаниудад түгээмэл тохиолддог бэрхшээлүүд:

Тохиолдож буй бэрхшээлүүд




График 12. Эх сурвалж: Анкетын судалгаа 2010

8. Хамтын үйл ажиллагаа

Орон нутгийн бусад компаниудтай
хамтарч ажилладаг эсэх




График 13 Эх сурвалж: Анкетын судалгаа 2010

Судалгаанд оролцсон 37 компанийн 18 нь орон нутгийн бусад байгууллага компаниудтай хамтран ажилладаггүй гэсэн байна.

Зарим компаниуд орон нутгийн бусад компаниудтай хамтарч ажиллахгүй байгаа нь салбар хоорондын холбоо харилцаа бага байгааг илтгэдэг.

9. Үйл ажиллагаагаа өргөжүүлэхийг зорьж буй ажлууд:




График 14. Үйл ажиллагаагаа өргөжүүлэх (Эх сурвалж: Анкетын судалгаа 2010)

65% нь ажлын байраа томсгохыг хүссэн бол 16% нь ямар нэг өргөтгөл хийхгүй гэж хариулсан. Мөн 8% нь барааны нэр төрлөө олшруулна, 6% нь шинэ салбар нээнэ гэж хариулсан.

Хүснэгт 1. Төвийн бүсийн аймгуудын ажиллагсдын тоо

Аймаг	2006	2007	2008	2009*
Говьсүмбэр	3.8	4.2	4.2	4.8
Дархан-Уул	27.9	28.2	33.3	34.1
Дорноговь	19.5	19.8	20.5	20.1

**Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги**

Дундговь	22.5	23	22.2	20.9
Өмнөговь	21.2	22.2	20.1	23.2
Сэлэнгэ	37.4	37.8	38.2	48.8
Төв	43.6	44.1	42.9	39.5
Дүн	175.9	179.3	181.4	191.4

Эх сурвалж: Статистикийн эмхэтгэл 2009





График 15. Төвийн бүсийн аймгуудын нийт ажиллагсдын тоо
(Эх сурвалж: Статистикийн эмхэтгэл 2009)

Бидний судалгаанд нийт 37 байгууллага оролцсоноос нийт ажилчдынх нь тоо 206 байгаа юм. Харин төвийн бүсийн нийт ажилчдын тоо 2008 оны байдлаар 181400 байна гэсэн дүн мэдээ байна.

1-рт Даланзадгад хот: Даланзадгад хотын үйлдвэрлэл, үйлчилгээний бүтэц

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги


Судалгаанд хамрагдсан үйлдвэрлэл үйлчилгээний газрууд



Эх сурвалж: Анкетын судалгаа 2010

Ханбогд

Судалгаанд хамрагдсан үйлдвэрлэл үйлчилгээний
газрууд




Эх сурвалж: Анкетын судалгаа 2010

Бор-Өндөр

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх
дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги


Судалгаанд хамрагдсан үйлдвэрлэл үйлчилгээний газрууд



Эх сурвалж: Анкетын судалгаа 2010

Чойр

Судалгаанд хамрагдсан үйлдвэрлэл үйлчилгээний газрууд



Эх сурвалж: Анкетын судалгаа 2010

Сайншанд

Эдийн засгийн төв бүсийн нэн тэргүүнд эрчимтэй хөгжүүлэх дэд бүс болон хот, суурины хөгжлийн стратеги



Эх сурвалж: Анкетын судалгаа 2010

Хөдөө орон нутгийн төвлөрсөн суурингуудад үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэхийн тулд дараах алхамуудыг хийж болох юм.

Зөвлөмж:

- Үйлчилгээний томоохон цогцолбор төвтэй болох
- Орон нутаг хоорондын томоохон цогцолборт холбогдох бараа бүтээгдэхүүн, түүхий эдийг бөөний үнээр худалдаалах
- Үндэсний үйлдвэрлэлийг төрөөс дэмжих
- Ажлын байр болоод үйлдвэрлэлийн хүчин чадлыг нь нэмэгдүүлэх
- Зээл авах боломж нөхцлөөр нь хангаж өгөх
- Төрийн байгууллагууд болон орон нутгийн томоохон уул уурхайн компаниудтай хамтарч ажиллах боломж нөхцлөөр хангах
- Түүхий эд бараа бүтээгдэхүүний үнийг тогтмол нэг хэмжээнд барьж байх